

DDC
363.2
Б-342

ЦАГДАА СУДЛАЛ

Онол арга зүйн
улирал тутмын
сэтгүүл

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Ч.Гэрмаа

Хэвлэлийн хуудас ...

Цаасны хэмжээ: В.5

Хэвлэсэн газар: Номын цацал ХХК

Дугаарыг эрхлэн гаргасан: Докторант Г.Бямбадорж

ISBN 978-99962-8882-2-7

2015 №3 (15)

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Зөвлөлийн дарга: **Ж.Болдбаатар** Хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор

Зөвлөлийн гишүүд:

- **Ж.Долгorsүрэн** Хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор
- **Б.Пүрэв** Хууль зүйн доктор (Ph.D), хүндэт профессор
- **Ж.Заанхүү** Түүхийн шинжлэх ухааны доктор, (Sc.D), дэд профессор
- **Г.Гантөмөр** Хууль зүйн ухааны доктор,(Ph.D), профессор
- **З.Төрмандах** Хууль зүйн ухааны доктор (Ph.D)
- **Т.Оюунчимэг** Хууль зүйн ухааны доктор (Ph.D),профессор
- **Ж.Мөнхболд** Хууль зүйн ухааны (Ph.D)

Сэтгүүлийн эрхлэгч: ХСИС-ийн тэргүүн дэд захирал
Б.Бат-Эрдэнэ Хууль зүйн ухааны доктор (Ph.D), профессор

Эрхлэн гаргасан, нарийн бичгийн дарга: Докторант **Г.Бямбадорж**

Сэтгүүлийн редакцийн зөвлөл:

- **Т.Бямбаа** Хууль зүйн ухааны доктор (Ph.D)
- **О.Цэцэгмаа** Хууль зүйн ухааны доктор (Ph.D)
- **Д.Энхжаргал** Хэл шинжлэлийн ухааны доктор (Ph.D), дэд профессор
- **Д.Мягмарцэрэн** Хууль зүйн ухааны доктор (Ph.D)
- **Ш.Ариунбилэг** Хууль зүйн ухааны доктор (Ph.D)
- **Б.Баярмагнай** Хууль сахиулахуйн доктор (Ph.D)

ЦАГДАА СУДЛАЛ

Онол арга зүйн улирал тутмын сэтгүүл

(дугаар, 2015 №3)

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ

- З.ДАШДАВАА.** ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ДОТООД ХЯНАЛТ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АЛБАНЫ ҮҮСЭЛ ХӨГЖИЛ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА.....
- Б.БАЯНМӨНХ.** ОНЦГОЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ ҮҮСЭХЭД НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛ, ТҮҮНИЙ ШАЛТГААН НӨХЦЛИЙГ ТОДОРХОЙЛОХ НЬ.....
- Э.РЭГДЭНДАГВА.** МАЛ, АМЬТНЫ ГОЦ ХАЛДВАРТ ӨВЧИН, ТҮҮНЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗАРИМ АСУУДАЛ
- Д.БЯМБАХҮҮ.** ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ЭРЭН СУРВАЛЖЛАХ АЖИЛЛАГААГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗАРИМ АСУУДАЛ.....
- Д.БУЛГАН.** ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТАЛААР ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГААС НИЙТИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ НЬ.....
- Д.МӨНХЖАРГАЛ.** ГАЛЫН БЭЛТГЭЛ ХИЧЭЭЛИЙН ДАДЛАГА ХИЙХ ОРЧИН ҮЕИЙН ЭЛЕКТРОН ТИР АШИГЛАХ АСУУДАЛ.....
- Д.ИДЭРМӨНХ.** ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН АЖЛЫН ҮНЭЛГЭЭ БА ӨӨРИЙГӨӨ ХӨГЖҮҮЛЭХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА.....

ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ

- О.ОТГОНТУЯА.** ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ХҮҮХДИЙН ЭРХ.....

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ

- Б.ХИШИГТОГТОХ.** ХУУЛЬ ЁСНЫ ЭРХЭЭ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨРӨЛ, АНГИЛАЛТ

КРИМИНОЛОГИЙН ОНОЛ ПРАКТИКИЙН СУУДАЛ

- С.ХАСБААТАР.** СОГТУУРСАН, МАНСУУРСАН ЭТГЭЭДИЙГ ЭРҮҮЛЖҮҮЛЭХ, АЛБАДАН СААТУУЛАХ АЖИЛЛАГААНЫ ҮЕД ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ.....
- Г.БЯМБАДОРЖ.** МАНСУУРУУЛАХ БОЛОН СЭТГЭЦГЭД НӨЛӨӨЛӨХ ЭМ БЭЛДМЭЛ, БОДИСТОЙ ХОЛБООТОЙ ГЭМТ ХЭРЭГ, ТҮҮНИЙГ ХЭРЭГЛЭСЭН ЭТГЭЭДИЙГ ТОГТООХОД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ
- Ш.ЧУЛУУН.** ХАР ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИСТОЙ ХОЛБООТОЙ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗАРИМ АСУУДАЛ

ГАДААД ХЭЛ ДЭЭР БИЧИГДСЭН ӨГҮҮЛЭЛ, НИЙТЛЭЛ

- Д.МЯГМАРЦЭРЭН, Д.ТҮВШИНТӨР.** КРИМИНОЛОГИЧЕСКИЕ ОСОБЕННОСТИ СЕМЕЙНО-БЫТОВЫХ УБИЙСТВ В МОНГОЛИИ.....

ОРЧУУЛАГЫН НИЙТЛЭЛ

- Я.ЦЭЛМЭН.** НОТОЛГОО ГЭЖ ЮУ ВЭ?

**ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ДОТООД ХЯНАЛТ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
АЛБАНЫ ҮҮСЭЛ ХӨГЖИЛ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ,
ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА**



З.Дашдаваа

Хууль сахиулахын их сургуулийн, Цагдаагийн
сургуулийн захирал, цагдаагийн хурандаа

Манай улсад 1990 онд өрнөсөн улс төр, нийгэм, эдийн засгийн өөрчлөлтийн дагуу Засгийн газрын шийдвэрээр Улсын цагдан сэргийлэх ерөнхий газрыг Цагдаагийн Ерөнхий Газар болгон өөрчлөн зохион байгуулсан байна.

1992 онд Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдаж түүнд нийцүүлэн “Монгол улсын Цагдаагийн байгууллагын тухай хууль”¹ шинээр батлагдан гарсан нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр болоод зогсохгүй эрх зүйн шинэчлэлтийн чухал алхам болсон юм.

Энэ хууль нь орчин үеийн цагдаагийн байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааны үндсэн зарчим, зорилго, зорилт, үндсэн үүрэг, бүрэн эрх, үйл ажиллагааны эрх зүйн арга хэлбэрийг тодорхойлсон анхны төрөлжсөн хууль болсон бөгөөд цагдаагийн байгууллага нь үйл ажиллагаагаа хуулийг дээдлэх, шударга ёс, тэгш байдлыг хангах, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх зарчмаар явуулах эрх зүйн үндэс бүрдэж, улмаар гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам хамгаалах үүргээ нэр төртэй биелүүлэн ажиллаж ирсэн юм.

Тус хуулинд Цагдаагийн төв байгууллага нь цагдаагийн нийт байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаанд, цагдаагийн байгууллагын дарга, захирагч нар тухайн байгууллагын алба хаагчийн өдөр тутмын ажилд дотоодын хяналт тавьж хууль тогтоомж, цагдаагийн алба хаагчийн ёс зүйн шаардлага, хүний эрх, эрх чөлөөг зөрчих явдалтай тэмцэж шалтгаан, нөхцлийг арилгах арга хэмжээ авна ² гэж тусгайлан заасан нь өнөөгийн Дотоод хяналт- Аюулгүй аюулгүй байдлын газар байгууллагдах анхны эрх зүйн зохицуулалт болсон байна.

Цагдаагийн байгууллага, алба хаагч нь үндсэн үүрэг, зорилгоо биелүүлэн ажиллаж байгаа ч гэсэн зарим тохиолдолд алба хаагчдын дотроос гэмт хэрэг үйлдэх, зөрчил гаргах, архидан согтуурах, иргэдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлт, мэдээллийг шалгахгүй дарагдуулах, иргэдээс эд зүйл хурааж авахдаа тогтоосон журам зөрчих, хураасан эд зүйлээ ашиглах, үрэгдүүлэх зэргээр хууль тогтоомж зөрчих явдал гарч байжээ.

Иймд цагдаагийн байгууллагын хэмжээнд дотоодын хяналтын үр нөлөөг дээшлүүлэх, ажилтан нарын ажлын идэвхи санаачлагыг өрнүүлэх, ажлын хариуцлага, сахилга, цэрэгжилт, жагсаалч байдлыг сайжруулахад гол үйл ажиллагаагаа чиглүүлж ажиллах үүрэг бүхий хяналт шалгалтын нэгж бий болох хэрэгцээ шаардлага зүй

¹Цагдаагийн байгууллагын тухай хууль 1993 оны 12-р сарын 02-нд батлагдсан 8 бүлэг, 53 зүйлтэй хууль юм. Энэ хууль 1994 оны 01-р сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдсөн.

² Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 8-р бүлгийн 51-р зүйл

ёсоор урган гарч ирсэн юм. Энэхүү ажлын хүрээнд Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар³ цагдаагийн анги, байгууллагын ажилд туслах, шалган зааварлах үүрэг бүхий анхны тусгай тасаг байгуулагдсан нь одоогийн Дотоод хяналт аюулгүй байдлын газрын үндэс суурь нь болж үйл ажиллагаагаа явуулах эхлэл нь болсон байна.

Тус тушаалаар тусгай тасаг нь тасгийн дарга 1, зохион байгуулагч 6, санхүүгийн хяналт шалгалтын байцаагч 4, нийт 11 орон тоотойгоор ажлын гараагаа эхэлж байсан түүхтэй байна.

Тусгай тасаг нь Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд Монгол улсын хууль, бусад хууль тогтоомж, Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаал, даалгавар, даргын зөвлөлийн хурлын шийдвэр мөн газрын бодлого, зорилт хэрхэн хэрэгжиж байгаа байдал, аж ахуй санхүүгийн ажиллагааг газар дээр нь биечлэн танилцан, шалгаж гарсан зөрчил дутагдлыг шуурхай арилгуулах ажлыг цаг алдалгүй зохион байгуулж, хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн шууд чиглүүлэн ажиллаж иржээ.

Мөн шаардлагатай тохиолдолд цагдаагийн байгууллагын ажилтны хууль бус ажиллагааны тухай иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээлэл, шүүхийн энгийн магадлал, прокурорын мэдэгдэл, цагдаагийн ажилтны эрүүл мэнд, эрх ашгийг хохироосон үйлдэл зэргийг шалгаж холбогдох арга хэмжээг авах ажлыг зохион байгуулах үүргийг гүйцэтгэж байсан юм.

Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар⁴ тусгай тасгийн анхны дүрмийг баталсан нь үйл ажиллагааг нь зохицуулсан анхны эрх зүйн баримт бичиг болжээ.

Тус тасгийн бүтэц, зохион байгуулалтанд өөрчлөлт оруулах зорилгоор Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаал⁵ гарч улмаар бүтэц, зохион байгуулалт, орон тоог шинэчлэн баталсан байна.

Тус тушаалаар тусгай тасгийг хяналт, шалгалтын тусгай тасаг болгон өөрчилж дарга 1, зохион байгуулагч 6, санхүүгийн хяналт шалгалтын ахлах байцаагч 3, бүгд 10 орон тоотойгоор ажиллуулахаар шийдвэрлэж байсан байна.

Хяналт, шалгалтын тусгай тасгийн үйл ажиллагаандаа баримтлах эрх зүйн баримт бичгийг Цагдаагийн ерөнхий газрын тушаалаар⁶ шинэчлэн баталж мөрдлөг болгон ажиллуулсан байна. Тус тушаалын 1-р хавсралтаар хяналт шалгалтын тусгай тасгийн дүрэм, 2-р хавсралтаар цагдаагийн анги байгууллага, алба хаагчдын ажлыг шалгах нэгдсэн удирдамжийг батлуулсан бөгөөд Цагдаагийн ерөнхий газрын иж бүрэн шалгалтыг байгууллага, албадад 3 жилд 1 удаа хийж тодорхой хугацааны дараа биелэлтийн шалгалт хийж байхаар дүрэмд тусгаж өгчээ.

Хяналт шалгалтын тусгай тасгийн дүрмийг цаг үе, нийгмийн хөгжил, хууль тогтоомж, эрх зүйн актын өөрчлөлттэй холбогдуулан Цагдаагийн ерөнхий даргын тушаалаар⁷ шинэчлэн өөрчлөн боловсронгуй болгож үйл ажиллагаанд нь баримтлуулан ажиллуулжээ.

Цагдаагийн байгууллагын хяналт, шалгалтын нэр нөлөө, ач холбогдлыг удирдлагаас харгалзан үзэж хяналт шалгалтын тусгай тасгийг Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар⁸ хяналт шалгалтын хэлтэс болгон өргөтгөн зохион байгуулжээ.

³ЦЕГ-ын 1993 оны 01-р сарын 09-ны өдрийн 05 тоот тушаал

⁴ЦЕГ-ын 1993 оны 02-р сарын 09-ны өдрийн 35 тоот тушаал

⁵ЦЕГ-ын 1997 оны 07-р сарын 14-ний өдрийн 165 тоот тушаал

⁶ЦЕГ-ын 1998 оны 04-р сарын 13-ны өдрийн 61 тоот тушаал

⁷ЦЕГ-ын 2005 оны 02-р сарын 22-ны өдрийн 86 тоот тушаал

⁸ЦЕГ-ын 2005 оны 06-р сарын 27-ны өдрийн 301 тоот тушаал

Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар⁹ Цагдаагийн ерөнхий газрын төв аппаратын бүтцэд өөрчлөлт орсонтой холбогдуулан Хяналт шалгалтын хэлтсийг Дотоод хяналт шалгалт, аюулгүй байдлын хэлтэс болгон өөрчлөн байгуулсан байна.

Тус тушаал гарсантай холбогдуулан Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар¹⁰ Дотоод хяналт шалгалт, аюулгүй байдлын хэлтсийн дүрмийг шинэчлэн баталж үйл ажиллагаандаа мөрдүүлэх ажлыг зохион байгуулж биелэлтэнд хяналт тавьж ажилласан байна.

Хэлтсийн дүрэм шинэчлэн батлагдсантай холбогдуулан төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсээс дотоод хяналт шалгалт, аюулгүй байдал хариуцсан ажилтнуудыг томилуулах саналыг авч, нэгтгэн Цагдаагийн ерөнхий газрын удирдлагад танилцуулж улмаар ЦЕГ-ын даргын тушаалаар¹¹ төв, орон нутагт дотоод ажил, хяналт шалгалт хариуцсан байцаагч нарын томилуулан ажиллуулсан байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар¹² Дотоод хяналт шалгалт, аюулгүй байдлын хэлтсийг Дотоод хяналт-аюулгүй байдлын газар болгон шинэчлэн зохион байгуулсан байна. Тус зохион байгуулалтаар дотоод хяналт-аюулгүй байдлын газар нь:

- Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтэс
- Аюулгүй байдлын хэлтэс
- Төрийн нууц, шифрийн харилцааны тасаг гэсэн нэгжтэйгээр үйл ажиллагаагаа чиглүүлэн ажилласан байна.

Хууль зүйн сайдын тушаалаар¹³ Цагдаагийн байгууллагын зохион байгуулалтын бүтцийг баталсан бөгөөд энэхүү бүтцэд Дотоод хяналт-аюулгүй байдлын газрыг шинэчлэн зохион байгуулалтын арга хэмжээ авсан байна. Үүнд:

- Хяналт шалгалтын хэлтэс
- Хяналт- шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс
- Аюулгүй байдлын хэлтэс
- Тусгай субъектийн гэмт хэргийг мөрдөх хэлтэс
- Төрийн нууц, шифрийн харилцааны тасаг
- Ёс журмын хэсэг гэсэн нэгжтэйгээр үйл ажиллагаагаа зохион

байгуулан ажиллаж иржээ.

Мөн Хууль зүйн сайдын тушаалаар¹⁴ Цагдаагийн байгууллагын зохион байгуулалтын бүтцийг дахин шинэчлэн баталсан бөгөөд энэхүү ажлын хүрээнд Дотоод хяналт-аюулгүй байдлын газрыг дараах бүтэц, зохион байгуулалттай байхаар тусгаж өгчээ. Үүнд:

- Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс
- Аюулгүй байдал, төрийн нууц, шифрийн харилцааны хэлтэс гэсэн нэгжтэйгээр өнөөдрийг хүртэл үйл ажиллагаагаа зохион байгуулан ажиллаж байна.

Дотоод хяналт-аюулгүй байдлын газар нь үүсэн байгуулагдсан цагаасаа төв, орон нутгийн цагдаа, дотоодын цэргийн байгууллагад төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалт хийх, алба хаагчтай холбоотой гомдол мэдээлэлд албаны шалгалт явуулах, байгууллага, алба хаагчдын аюулгүй байдлыг хангах, түүний гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд халдах, хүч хэрэглэх, заналхийллээс хамгаалах, хүний нөөцийн ажилд дэмжлэг үзүүлэх, алба хаагчдыг гэмт хэрэг, эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх үндсэн

⁹ЦЕГ-ын 2006 оны 12-р сарын 29-ний өдрийн 618 тоот тушаал

¹⁰ЦЕГ-ын 2007 оны 12-р сарын 12-ны өдрийн 526 тоот тушаал

¹¹ЦЕГ-ын 2013 оны 04-р сарын 22-ны өдрийн 252 тоот тушаал

¹²ЦЕГ-ын 2013 оны 12-р сарын 31-ний өдрийн тушаал

¹³Хууль зүйн сайдын 2014 оны 10-р сарын 06-ны өдрийн А/167 тоот тушаал

¹⁴Хууль зүйн сайдын 2015 оны 04-р сарын 28-ны өдрийн А/89 тоот тушаал

чиг үүргийг гүйцэтгэн эрх бүхий албан тушаалтанд биелэлтийг тайлагнан ажиллаж ирсэн юм.

Цагдаагийн ерөнхий газар нь цагдаагийн нийт байгууллага, алба хаагчдад дотоод хяналт тавихын зэрэгцээ цагдаагийн өдөр тутмын үйл ажиллагаанд хуулийн хэрэгжилтийг хангаж тайлан тавих эрх хэмжээг нэгж, байгууллага хариуцсан удирдах албан тушаалтанд олгосон байдаг.

Энэхүү чиг үүргийг төв удирдлагын түвшинд Дотоод хяналт-аюулгүй байдлын газар нь хариуцан хэрэгжүүлэн зохион байгуулж ирсэн бөгөөд дараах ажил үүргийг гүйцэтгэдэг байна. Үүнд:

- Цагдаагийн байгууллагын хэмжээнд эрсдлийн үнэлгээ удирдлага, үнэлгээ, шинжилгээг нэгтгэн зохион байгуулж мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах
- Цагдаагийн байгууллагын төсөв, санхүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилт, төсвийн үр ашигтай зарцуулалт, ил тод байдлыг хянан шалгах, дүн шинжилгээ хийх
- Албан хаагч, ажилтныг хүний эрх, эрх чөлөө, хууль, ёс зүй зөрчихөөс сэргийлэх, илрүүлж шалгах, таслан зогсоох, шалтгаан нөхцлийг судалж мэдээлэлийн сан бүрдүүлэх, албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэж хянан шалгах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх зэрэг үйл ажиллагааг тус тус явуулж байна.

Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд: “Хууль сахиулах байгууллагын алба хаагчид тавих ёс зүй, мэргэжлийн чадвар, хариуцлага, хууль сахин биелүүлэх шаардлагыг өндөр түвшинд байлгаж дотоод аюулгүй байдлыг хангана.”

Мөн Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт: “Хууль сахиулах байгууллагыг авлигаас ангид, хариуцлагатай, хяналттай, нээлттэй, ил тод, иргэнд ойрхон болгож төлөвшүүлнэ.”¹⁵ гэж тус тус хууль сахиулах байгууллага болон алба хаагчийн үүрэг, хариуцлагыг тусгайлан тодотгон зааж өгсөн байна.

Дээр дурдсан үзэл баримтлал, үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн агуулга, үзэл санаанд тулгуурлан Дотоод хяналт-аюулгүй байдлын газар нь өөрийн үйл ажиллагаандаа дараах чиг хандлагыг баримтлан ажиллахаар хэтийн зорилго дэвшүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Дотоод хяналтад суурилсан цагдаагийн үйл ажиллагааг хөгжүүлж Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Засгийн газрын мөрийн хөтөлбөр, Цагдаагийн хөгжлийн стратегийн зорилго, зорилтыг хангах
- Иргэний зөвлөлийг олон улсын жишиг хандлагад нийцүүлэн хөгжүүлж бэхжүүлэхэд туслах
- Байгууллагын дотоод хяналтын үйл ажиллагаанд удирдах албан тушаалтнаас гадна ажилтнуудын оролцоо түвшинг тодорхойлох, авлигагүй орчин бий болгох
- Цагдаагийн байгууллага, алба хаагчийн бие даасан хараат бус байдлыг бэхжүүлж улс төр, бизнесийн бүлэглэл, эрх мэдэл, албан тушаалтны болон бусад нөлөөллөөс ангид байлгах
- Хуулиар нууцалснаас бусад цагдаагийн үйл ажиллагаа, төсөв санхүүжилтийн ил тод байдлыг улам бүр бэхжүүлэх гэж тус тус тусгайлан тодотгож өгчээ.

¹⁵2012-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр

ОНЦГОЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ ҮҮСЭХЭД НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛ, ТҮҮНИЙ ШАЛТГААН НӨХЦЛИЙГ ТОДОРХОЙЛОХ НЬ



Б.Баянмөнх

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн
ЦЭЗТ-ийн дэд профессор, цагдаагийн хошууч

Онцгой нөхцөл байдал гэдэг нь салхи, шуурга, үер, гал түймэр, газар хөдлөлт, хүн малын халдварт болон гоц халдварт өвчин зэрэг байгалийн болон хүний хүчин зүйлээс хамаарч бий болж байгаа зэвсэгт мөргөлдөөн, дайн байлдаан, террорист халдлага, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, техник, үйлдвэрлэлийн осол, аваар зэрэг нийгмийн салбарт бий болсон гамшиг, осолтой холбоотойгоор үүсч, улмаар нийгэм, төр, байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн эрх ашиг, сонирхол, амьдрах орчинд хохирол учруулдаг үзэгдэл, үйл явцын нэгдэл юм.

Ийм онцгой нөхцөл үүссэн үед төрөөс байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн эрх ашиг сонирхлыг хамгаалах, амьдралын хэвийн нөхцөлийг бүрдүүлэх, сэргээхэд чиглэгдсэн нийгэм эдийн засаг, эрх зүй, зохион байгуулалтын цогц арга хэмжээ зохион байгуулж явуулдаг.

Онцгой нөхцөл байдал нь үүсгэж буй хүчин зүйл, түүнээс учруулсан хор уршгийн хэр хэмжээ, төрийн тусгай чиг үүргийн байгууллагуудын явуулж байгаа үйл ажиллагааны цар хүрээнээс ихээхэн хамаарах бөгөөд гагцхүү тэдний явуулж буй үйл ажиллагааны онцлогоос хамаарч эрх зүйн тодорхой дэглэмээр үйл ажиллагаа нь зохицуулагддагаараа бусад ердийн үйл ажиллагаануудаас ялгагддаг байна.

Онцгой нөхцөл байдлыг үүсгэж буй хүчин зүйлээс нь хамаараад:

- а. Хүний хүчин зүйлээс үл хамаарах онцгой нөхцөл байдал (байгалийн гамшигт үзэгдэл)
- б. Хүний хүчин зүйлээс хамаарах онцгой нөхцөл байдал (дайн байлдаан, зэвсэгт мөргөлдөөн, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, террорист халдлага)

Өнөөдөр нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдал алдагдахад дараах хүчин зүйлсүүд нөлөөлж байна үзэж болно. Үүнд:

1. Согтууруулах ундааны хэрэглээ, архидалтын улмаас учирч байгаа хор уршиг

Сүүлийн хэдэн арван жил согтууруулах ундааны хэрэглээ хөгжингүй орнуудад буурч, харин хөгжиж буй орнуудад нэмэгдэн дэлхийн хэмжээнд жил бүр 1,8 сая хүн согтууруулах ундаа хэрэглэсэнтэй холбоотойгоор нас барж байгаа нь өвчин, эмгэгийн улмаас нас барсан нийт тохиолдлын 3,2 хувийг эзэлж байна.

Согтууруулах ундаа үйлдвэрлэдэг, худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг цэг, аж ахуйн нэгжүүдийн тоо олширсон, тэд архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр гарсан хууль тогтоомжийг мөрдөж ажиллах явдал хангалтгүй байгаагаас олон нийтийн аюулгүй байдалд учирч болох заналхийлэл тодорхой хэмжээгээр нэмэгдэх хандлагатай байна.

Согтууруулах ундааг хэвийн хэмжээнээс хэтрүүлж хэрэглэх нь нийгмийн ашиг сонирхлыг үл хайхран хууль тогтоомжийн заалт, ёс суртахууны хэм хэмжээг байнга зөрчих нөхцөл бүрддэг байна.

Архидан согтуурсаны улмаас гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэж байгаа шалтгаан, нөхцөлийг хооронд нь уялдаа холбоо бүхий хоёр шатанд авч үзэж, ялгаж ойлгож болно.

Нэгдүгээрт, согтууруулах ундааны нийлүүлэлт зах зээлд хангалттай байгаа, хэн ч, хаанаас ч, хүссэн үедээ аваад уух боломж бараг бүрэн бүрдсэн, мөн архи ууж стресс, бухимдлаа тайлах, хийх ажилгүй сэлгүүцэх, наргих, цэнгэх, зугаацах зэрэг нь хүмүүсийн архидаг согтуурлын шалтгаан, нөхцөл болж байна.

Хоёрдугаарт, архидаг согтуурахын шалтгаан, нөхцөлөөр нөхцөлдсөн байгаль, нийгэм, эдийн засаг болон хувь хүний хүчин зүйлсийн нөлөөтэйгээр согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг бий болгож байна. Өөрөөр хэлбэл гэмт явдлын шалтгаан, нөхцөлийн өмнө архидаг согтуурлын шалтгаан, нөхцөл байна гэж үзэж байгаа юм.

Согтуугаар үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн хувьд байгаль, нийгэм, эдийн засгийн сөрөг үзэгдэл, үйл явц, хүн амын төвлөрөл, ажилгүйдэл, ядуурал, улс төрийн тогтворгүй байдал зэрэг нийтлэг хүчин зүйлүүд суурь шалтгаан, нөхцөл болж байна.

Согтуугаар үйлдэгдсэн гурван хэрэг тутмын нэг нь олон нийтийн газар үйлдэгдэж байна.

2. Эдийн засгийн тогтворгүй, үр ашиггүй бодлогоос учирч байгаа хор уршиг

Зах зээлийн өнөө үед нийгмийн давхраажилтын дүр төрхийг илэрхийлэх нэгэн үзэгдэл бол олонхийн ядуурал, цөөнхийн баяжилт юм. Нийтийн өмч ноёрхсон социализмын үед харьцангуй адил төстэй ахуй, амжиргааны нөхцөлд амьдарч байсан Монголчууд өнөөдөр давхраажилтын 2 туйл руу хуваагдаж байгаа нь нийгмийн хуваарилалт хэт шударга бус явагдаж байгааг харуулж байна.

Ядуурал ([англ. Poverty](#); [ор. Бедность](#)) гэж амьдралын чанарыг тодорхойлогч [хүнс тэжээл](#), [хувцас](#), [гэр орон](#) зэрэг ердийн хэрэгцээний дутагдал гачигдлыг хэлнэ. Үүнээс гадна ядуурлаас гарахад буюу хүн ам дотор хүндтэй байр суурьтай эзлэхэд зайлшгүй хэрэгтэй [боловсрол](#), [ажлын байр](#) зэрэг боломжуудад хүрч чадахгүй байдлыг илтгэж болно.

Ядуурлыг Дэлхийн хүн амын тал хувь нь ядуу гэх статистик байдаг. Ядуурлыг [үнэмлэхүй](#) ба [харьцангуй ядуурлаар](#) хэмжиж болно.

Үнэмлэхүй ядуурал гэж улс гүрнүүд ба цаг хугацааны турш тогтмол байж ирсэн стандартыг хэлнэ. Үнэмлэхүйн хэмжилтийн жишээ гэвэл хүнд зайлшгүй хэрэгтэй хоол тэжээлийгээ (насанд хүрсэн эр хүнд 2000-2500 калор орчим) хүртэж чадахгүй байгаа хүн амын хувийг хэлнэ.

Үнэмлэхүй ядуурал гэдэг нь амьдралын наад захын хэрэгцээгээ хангах чадваргүй байдал. Үүнийг өөрөөр нэн ядуу, туйлын ядуу гэж нэрлэдэг. **Харьцангуй ядуурал** гэдэг нь амьдралын боломжийн жишиг гэж тухайн нийгмийн үзэж байгаа зүйлсийг хангах чадваргүй байдал юм. Өөрөөр хэлбэл наад захын хэрэгцээгээ хангачихаад тогтоосон амжиргааны доод түвшинд хүрэхгүй байхыг хэлнэ. Иргэдийн ядуурлын шалтгааныг:

1. Өнгөрсөн үе буюу социализмтай
2. Зах зээлийн эдийн засагт шилжих шилжилттэй холбон үздэг.

Эхний шалтгаан: Социализм иргэдийг хэт бэлэнчлэх сэтгэлгээнд сургасан гэж үздэг. Учир нь сургууль төгсөөд ажил нь бэлэн, ажиллаад шууд цалинтайгаа золгоно, амьдрах орон байраар хангуулдаг гэх мэт.

Социализмын үед манай оронд хувийн өмч байгаагүй бөгөөд ажил хийж чадах бүх хүн албадлагаар хөдөлмөрлөж, цалин хөлс авч, түүгээрээ амьдралаа залгуулдаг байсан.

Тухайн үеийн нийгэм нь олон дутагдалтай байсан бөгөөд хөдөлмөр нь албадлагын шинжтэй, эдийн засаг нь үр ашиг багатай, үйлдвэрүүд нь алдагдалтай ажилладаг гэх мэт. Социализмын үед цалингаас өөр орлогогүй, тэр тусмаа бага цалинтай байсан олон хүн улс орон зах зээлд шилжихэд ядуусын эгнээнд шилжсэн.

Хоёр дахь шалтгаан: Манай улс зах зээлд шилжснээр олон үйлдвэрүүд хэвийн үйл ажиллагаа явуулах боломжгүй болж хаалгаа барьсантай холбоотой олон мянган ажилчид ажилгүйчүүдын цаашлаад ядуучуудын эгнээнд шилжсэн.

Эдийн засгийн ийм тааламжгүй нөхцөлд нийгмийн хүчтэй ялгарал явагдаж байгаа нь ядуурлыг өсгөж байгаа давхар шалтгаан юм. Мөн сүүлийн жилүүдэд хүн амын шилжих хөдөлгөөн ихэссэнтэй холбоотойгоор хот суурин газруудад хүн амын нягтрал ихэссэн, байгалийн гамшигт малчид, тариаланчид олноор өртөх болсон, ажлын байр хомсдсон, гэмт хэрэг, архидалт ихэссэн гэх мэт олон шалтгаанаас болж нийгэмд ядуусын тоо ихсэх болжээ.

Эдийн засгийн ийм тааламжгүй нөхцөлд нийгмийн хүчтэй ялгарал явагдаж байгаа нь ядуурлыг өсгөж байгаа давхар шалтгаан юм. Мөн сүүлийн жилүүдэд хүн амын шилжих хөдөлгөөн ихэссэнтэй холбоотойгоор хот суурин газруудад хүн амын нягтрал ихэссэн, байгалийн гамшигт малчид, тариаланчид олноор өртөх болсон, ажлын байр хомсдсон, гэмт хэрэг, архидалт ихэссэн гэх мэт олон шалтгаанаас болж нийгэмд ядуусын тоо ихсэх болжээ.

Амжиргааны доод түвшин гэдэг нь хувь хүн юмуу гэр бүл хоол хүн, хувцас, орон байртай байхад хүрэлцэх доод орлого гэж албан ёсоор тогтоосон мөнгөний хэмжээ юм.

Өөрөөр хэлбэл сард нэг хүнд оногдох доод орлогын тогтоосон хэмжээ юм. Амжиргааны доод түвшингийн 40%-иас доош орлого сард нэг хүнд ноогдож байвал үнэмлэхүй ядуу, харин 40%-иас дээш ноогдож байвал харьцангуй ядуу юм.

3. Улс төрийн тогтворгүй байдлаас нийгмийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдалд учирч байгаа хор уршиг

Олон улсын практикт, үндэсний аюулгүй байдлыг хангахад төрийн үүрэг тэргүүн зэргийн ач холбогдолтой байж ирсэн. Тэр дундаа, жижиг буурай улсын хувьд бүр ч чухал юм.

Улс төрийн нөлөөлөл – улс төрийн үйл ажиллагаа явуулж буй субъект бусдын үйл байдлыг өөрийнхөө санасан ёсоор болгон өөрчилж буй байдлыг илэрхийлнэ. Нөлөөллийг амжилттай хэрэгжүүлснээр бусдын санаа бодол, чиг баримжаа, итгэл үнэмшил, мөн шууд үйл байдлыг өөрчилж болдог байна.

Төр хариуцлагагүй, хаалттай, чадваргүй болоод ирэхийн цагт улс, үндэсний аюулгүй байдалд төр өөрөө аюул, занал болдог. Төрөөс гарч буй шийдвэр тэр дундаа, улс үндэсний аюулгүй байдал, хөгжил дэвшилтэй холбоотой шийдвэр, үйл ажиллагаа бүр эерэг, сөрөг үр дагавар дагуулдаг.

Гэтэл, сүүлийн үед төрийн албанд сонирхлын зөрчил газар авч, эрх ашгийн эрэмбэлэл алдагдсанаар хэсэг бүлэг хүнд тухайн цаг үедээ ашигтай ч хэтдээ улс-үндэсний аюулгүй байдалд хохиролтой, аюулт эрсдэл буй болгох хорлон саатуулах гэмт хэргийн шинжтэй үйлдлийн хүрээ өргөсч байгаа нь олон нийтийн аюулгүй байдалд заналхийллийг бий болгож байна.

Төрийн байгууллагуудын бүтэц үр өгөөж муутайгаар өргөжиж, төсөв зардал нэмэгдэх, улс төрийн томилгоо хүрээгээ хальж хүний нөөцийн бодлого үгүй болсноос төрийн мэргэшсэн, чадварлаг алба хаагчдын хүрээ хумигдаж, төрийн алба хаагчдын ёс зүй, ажил гүйцэтгэх чадамж доройтсон зэргээс иргэдийн төр, хууль ёсоо дээдлэх үзэл алдагдахад хүрч байна.

Иргэдээс төрийн үйлчилгээ авахдаа тэнд алба хаагчдын ёс зүй, харилцаа, чадварт нэн бухимдах, төр засгийн үйлчилгээний арга барилыг шүүмжлэх, төрийн алба хаагчдыг үл тоомсорлох хандлага хурцаар илрэх болсон.

Төр засагт үл итгэх, хэн нэгэн чин зоригт, ард олноо өмгөөлөн хамгаалах, шударга ёс тогтоогч шинэ Чингис хаан гарч ирэхийг хүсэмжлэх байдал нийгмийн

сэтгэл зүйд хүчтэй болсон нь улс төрийн нам, хүчин бодлого, үйл ажиллагаандаа эргэлтийн шинжтэй өөрчлөлт хийхийг нөхцөлдүүлж байна.

Шүүх засаглалд иргэд үл итгэх болж, эрх мэдэл, эд хөрөнгө, танил талтай нэгэнд үйлчилдэг болтлоо шүүх, прокурор, хууль хяналтын байгууллагуудын олон ажилтан ёс зүйн доройтолд орсныг олон нийт, тэр дундаа эрх ашиг нь хөндөгдсөн хэсэг хурцаар шүүмжлэх болсон нь шударга ёсыг хүсэх нийгмийн сэтгэл зүйд бухимдлын хүчин зүйл болж ирж байна.

Төрийн засаглах чадавхи суларснаас нийгэмд төрийн албаны нэр хүнд унаж хууль зөрчих нь ердийн үзэгдэл болох, гэмт хэргийн гаралт өсч, хүмүүс зохион байгуулалтад орж өөрсдийн зөв гэж үзсэн үйлдлийг хүч түрэмгийлэн хэрэгжүүлэх, нийгмийн дэг журмыг бүлэглэн зохион байгуулалттайгаар зөрчих хандлагатай болсон.

Сахилга хариуцлагагүй, хууль зөрчдөг, хувийн эрх ашгийг эрхэмлэдэг, үндэсний аюулгүй байдал, язгуур эрх ашгийн талаар төсөөлөлгүй, төрийн албанд бэлтгэгдээгүй хүмүүс олширсон нь төр засаг чадавхигүйдэх үндсэн шалтгаан болж ирсэн.

Нийгмийн энэ бухимдал, “хүчтэй төрийн эрэлд гарсан” эрэлт нь зохион байгуулалттай гэмт бүтцүүд бий болох, үйл ажиллагаагаа идэвхжүүлэх, улмаар төр засгийн хяналтыг орлох, нийгэмд хүчирхийлэл дэлгэрэх, хүлээн зөвшөөрөгдөх хөрс болдог.

Албан тушаалтан, улс төрчидтэй холбоотой олон гэмт хэрэг шийдвэрлэгдэлгүй замхрах, төрийн албан тушаалтнууд өөрсдөө хууль зөрчин байж улс үндэсний эрх ашгийн эсрэг шийдвэр гаргах, улс үндэсний эрх ашигтай холбоотой олон асуудлууд шийдвэрлэгдэхгүй цаг алдах зэрэгт иргэний нийгэм туйлын бухимдах болж, эсэргүүцлээ хурцаар илэрхийлж эхэллээ. Тухайлбал, “Онги гол хөдөлгөөн”, “Монголын гол нууруудын нэгдсэн холбоо”, “Даяар Монгол”, “Хөх Монгол”, “Хөх бүлгэм” зэргээс уул уурхайн зүй бус, хууль бус ашиглалтын эсрэг, байгаль орчноо хамгаалах зорилгоор хэрэгжүүлж буй үйл ажиллагаа нь нийгмийн сэтгэл зүйд хүчтэй нөлөөлж, түүнд тулгуурлан хүч түрэмгийлсэн зарим талаар хэт даварсан үйлдэл хийх эхний алхам, тандалт хийгдсэн гэж үзэж болно.

Нийгэмд асуудлыг хууль, эрх зүйн хүрээнд шийдвэрлэхээс илүүтэйгээр авлига, дарамт шахалт, хүчирхийллээр зохицуулах нь үр дүнтэй гэсэн хандлага хүрээгээ тэлж байна.

Иймээс төр, засгийн зүгээс онцгой нөхцөл байдал үүсэхэд нөлөөлж буй хүчин зүйлсийг нарийвчлан тодорхойлох чиглэлээр судалгааны цогц арга хэмжээ явуулж, шалтгаан нөхцлийг бууруулах, улмаар арилгах чиглэлээр бодлого боловсруулж, хэрэгжүүлэх ажил зохион байгуулах нь нэн шаардлагатай чухал ажлын нэг болоод байна.

МАЛ, АМЬТНЫ ГОЦ ХАЛДВАРТ ӨВЧИН, ТҮҮНЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗАРИМ АСУУДАЛ



Э.Рэгдэндагва

ХСИС-ийн ЦС-ийн ЦЭЗТ-ийн ахлах багш,
цагдаагийн дэд хурандаа, докторант

Байгалийн голомтот болон мал, амьтнаас хүнд халдварладаг өвчний тухай ойлголт, түүний төрөл, хэлбэр болон өвчний тархалтаас урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллаж байгаа Цагдаагийн байгууллагын Олон нийтийн аюулгүй байдлыг хангах газрын алба хаагчид энэ өвчний талаар болон хөл хорио цээрийн дэглэм сахиулах ажиллагааны чиглэлээрхи онол, практикийн мэдлэг дутмаг байдаг билээ. Тиймээс энэ сэдвийн хүрээнд дараах 2 асуудлыг хөндөн авч бичихийг зорилоо. Үүнд:

- Мал амьтны гоц халдварт өвчний тухай ойлголт, төрөл, хэлбэр
- Хорио цээрийн дэглэм сахиулах ажиллагааны талаар товч авч үзье.

Мал амьтны гоц халдварт өвчний тухай ойлголт /animal infectious diseases/

Мал амьтны гоц халдварт өвчний тухай ойлголт гэдэг тухай улс орны нийгэм эдийн засагт хор хохирол учруулдаг, тухайн улс орны хил хязгаараас хамааралгүйгээр тархан дэлгэрдэг өвчин байдаг. Энэ өвчний дотроос малын шүлхий өвчин юм.

Шүлхий нь олон улсын мал амьтны халдварт өвчний “А” ангилалд багтдаг, маш богино хугацаанд олон төрлийн мал, амьтан хамран сум, аймаг, улс, тив, дэлхийд дамжин тархах аюултай, эдийн засгийн ихээхэн хохирол учруулдаг, олон улсын худалдааны хорио цээрт өвчин юм. Туруутан тэжээвэр болон зэрлэг амьтад өвчилнө. Өвчний нууц үе 1-14 хоног. Шүлхий нь салаа туурайтай мал, амьтдыг өвчлүүлэн богино хугацаанд маш хурдан тархаж, үлэмж хэмжээний газар нутаг, улс орныг, олон улсыг хамран энзоот, эпизооти, панзооти гэсэн 3 хэлбэрээр гардаг онц аюултай гоц халдварт өвчин юм.

Хүн амын дунд халдварт өвчин дэлгэрэхийг эпидеми, мал амьтны дунд дэлгэрэхийг эпизооти гэж ялган нэрлэдэг билээ. Шинэ мянган эхэлснээс хойш малын шүлхий өвчний эпизооти, уг өвчний голомттой улс орон төдийгүй энэ өвчин огт гардаггүй буюу гарахаа болиод удаж байгаа улс орнуудад дэгдэн аюул учруулсаар ирсэн.

Шүлхий өвчний үүсгэгчийг 1898 онд Ф. Лефлер, П. Фрош нар нээснээр мал амьтанд өвчин үүсгэдэг вирусүүдийн дотроос шинжлэх ухаанд хамгийн анх нээгдсэн вирус болжээ. Шүлхийн вирус хэмжээгээрээ хамгийн жижигхэнд тооцогдох боловч мал амьтны эрүүл мэнд, улс орны эдийн засагт жинхэнэ гамшиг учруулдаг учраас амьд мал, амьтан болон амьтнаас бэлтгэсэн бүх төрлийн бүтээгдэхүүний олон улсын худалдаанд ноцтой бэрхшээл учруулдаг бичил биетэн мөн.

Шүлхийн вирус 100 гаруй зүйлийн амьтныг өвчлүүлж чаддаг бөгөөд дотроо А, О, С, CAT-1, CAT-2, CAT-3, Ази-1 гэсэн долоон хэв шинжид хуваагдана.

Эдгээр вирусээс А, О, С гурван хэвшинж нь дэлхийн янз бүрийн улсад тархсан байдаг бол CAT (Southern African Territories) хэвшинж нь Африк, Ойрх Дорнодын улс орнуудад, Ази-1 хэв шинж нь Ази тив, Ойрх болон Дундад Дорнодын орнуудад голлон оношлогддог. Гэхдээ сүүлийн жилүүдэд оношлогдож байгаа шүлхийн

вирусуудийн дотор, О хэв шинжээс үүсч, “Бүх Азийн омог” хэмээн нэрлэгдсэн аюултай вирус зонхилох хувийг эзлэн, тив дэлхийг алгасан тархаж байгаа юм. Энэ омгийн вирус 1998 онд Энэтхэгт анх тархаж эхэлснээ улмаар хөрш зэргэлдээх бараг бүх орнуудад нэвтэрсний дараа 1999 онд Хятад, Тайван, Мьянмар, Тайланд, Вьетнам, Лаос зэрэг улсад тархсан байна. Энэ вирус 2000 оны 3 дугаар сард Өмнөд Солонгос, Японд оношлогдож, 4 дүгээр сард нь Оросын Уссурск муж болон манай улсын Дорноговь аймгийн Улаанбадрах суманд дэгдэлт үүсгэж байсан. Дараа нь 2000 оны 9 дүгээр сард, уул нь 1957 оноос хойш шүлхий өвчин гараагүй байсан Өмнөд Африкт тархсан ба 2001 оны 2 дугаар сард Нэгдсэн Вант улс болон Умард Ирландад, 3 ба 4 дүгээр сард Ирланд, Франц, Недерланд зэрэг улсад оношлогдож, 2003 онд Афганистан, Балба, Пакистан зэрэгт тархжээ. Түүнээс хойш Бүх Азийн омог өөр газар хараахан оношлогдоогүй байна.

Шүлхийгээр өвдсөн мал амьтанд илэрдэг хамгийн онцлог шинж бол амны хөндийн салт бүрхэвч нь үрэвсэн цэврүүтсэнээс шүлс нь асгарч, туурай нь үрэвсэж өвчилдөг. Ийм учраас зарим улсад энэ өвчнийг “Туурай болон амны өвчин (*Foot and mouth disease*)” гэж нэрлэдэг. Шүлхийн вирус хоёр гол онцлог чанартай.

Нэгдүгээрт, салаа туурайтныг халдварлуулах чадвар туйлын сайтай. Өөрөөр хэлбэл, шүлхийгээр өвчилсөн ганцхан мал буюу амьтан байхад л хавь орчныхоо нутаг дэвсгэрийн дархлалгүй бүх малыг өвчлүүлж чадна. Ялангуяа үхэр, хонь, гахайн сүрэгт шүлхийн вирус түргэн хугацаанд тархаж өвчлүүлдэг учраас түүний аюулыг хуурай өвсөнд гарсан түймэртэй харьцуулсан баримт олонтаа тааралддаг.

Уг вирусийн хоёрдугаар гол онцлог чанар бол түүний гадаад орчинд удаан хугацаагаар амьдарч, хол зайд тархдаг чадвар юм. Тухайлбал, Францад нэг удаа шүлхийн эпизооти үүсгэсэн вирус агаараар дамжин явсаар Ла-Маншийн хоолойг гаталж, 90 гаруй километрийн зайтай орших, Англи улсын нэгэн аралд хүрч халдвар тарааж байсан нь шинжлэх ухаанд баталгаажин үлдсэн байдаг.

Мал, амьтан шүлхийгээр өвчлөөд эдгэрсэн ч вирус агуулагч болон үлддэг тул халдварын голомтын бүх малыг заазалж, шатааж устгах шаардлагатай байдаг. Жишээлбэл, 1997 онд Тайван улсад гахайн шүлхий өвчин дэгдэхэд 6000 гаруй ферм өртөж, 4 сая гаруй гахайг устган, 21 сая тун вакцин хэрэглэсэн бөгөөд эдгээр арга хэмжээнд 378,6 сая америк доллар зарцуулжээ. Эдийн засгийн хохирол үүгээр хязгаарлагдсангүй. Гадаадад экспортлох ёстой байсан гахайн махыг үйлдвэрлэж чадаагүйгээс 1,6 тэрбум долларын алдагдалд орж, гахайн аж ахуй болон үйлдвэрт ажиллаж байсан 65 000 гаруй хүн ажлын байраа алдсан байдаг.

Энэ жилийн хувьд Ховд аймгийн Булган суманд 2015 оны 2 дугаар сарын 25-ны өдөр сэжиг илрэн, 2015 оны 3 дугаар сарын 04-ны өдрийн лабораторийн шинжилгээгээр гоц халдварт шүлхий өвчин болох нь тогтоогдсоноос хойш уг аймгийн 2 (Булган, Үенч) сумдын 4 голомтонд нийт 922 мал өвчилсөн байна. Шүлхий өвчнөөр 2015 оны 03 дугаар сарын 14-ны өдрөөс хойш шинээр мал нэмж өвчлөөгүй тул уг өвчинтэй тэмцэх стратеги, зааврын дагуу 2015 оны 5 дугаар сарын 4-ны өдөр хорио цээрийн дэглэмийг бууруулан хязгаарлалтын дэглэмд шилжүүлсэн байна.¹⁶

Тарваган тахал

Тарваган тахал олон улсын дүрмээр зохицуулагддаг байгалийн голомтот хурц халдварт өвчин юм. Богино хугацаанд олон хүнийг хамран өвчлүүлж, эрт оношилж зөв эмчлээгүй тохиолдолд богино хугацаанд хүндрэн үхэлд хүргэх аюултай өвчин юм. Тарваган тахал нь мэрэгч амьтдаас хүнд халддаг гоц аюулт халдварт өвчин юм. Тарваган тахлаар тарвага, зурам, үхэр огодой, үлийн болон гэрийн цагаан оготно,

¹⁶ Гоц халдварт, халдварт өвчний 2015 оны нөхцөл байдлын тухай мэдээлэл

чичүүл зэрэг мэрэгчдээс гадна хүн өвчилдөг. Өвчин үүсгэгчийг мэрэгчдийн дунд бүүрэг дамжуулдаг. Өвчин үүсгэгч нь мэрэгчдийн арьсанд 23 хоног, хоол хүнсэнд 2-4 сар, өвчтний цэр, идээ, цусанд 4-165 хоног өвчин үүсгэх чадвартайгаар хадгалагдана.

Шалтгаан:

- Тарваган тахлын үүсгэгч *yersinia pestis* зууван хэлбэртэй. Тарваган тахлын нян 37 хэмийн дулаанд бүрээс үүсгэнэ.

- Тарваган тахлын нян бүүргийн ходоодонд 0-15 хэмд 396 хоног хүртэл, мэрэгчдийн нүх ноохой, газрын хөрс, хүйтэн, чийгтэй нөхцөлд олон сарын турш амьдрах чадвартай бөгөөд бусад бичил биетний нөлөө болон нарны гэрэл, химийн бодисын нөлөөнд тэсвэргүй.

Халдвар хэрхэн дамжих вэ?

- Шууд халдварын зам. Өвчтэй тарвага агнах, арьс өвчих, мах эвдэх зэрэг үйл ажиллагааны явцад арьс салстын бүтэн байдал алдагдсан үед болон өвчтөнийг асрах, сувилах, халдвартай эд, зүйлстэй хамгаалах өмсгөлгүйгээр харьцсанаас арьсны болон булчирхайн хэлбэрийн тахлаар өвчилнө.

- Дам халдварын зам. Мэрэгч амьтдын бөөс, бүүрэг, цус сорогч үе хөлтөнд хазуулах зэрэг тохиолдлуудад халдварлана.

- Агаар дуслын зам. Тарваган тахлын уушигны хэлбэрээр өвчилсөн хүн түүний нэгдүгээр замаар халдварлана. Лабораторид осол гарсан үед уушигны хэлбэрээр өвчилж болно. Нүх, ичээ ухах үед болон уушгины хэлбэрийн тахлаар, өвчилсөн хүнээс амьсгалын замаар халдвар дамжина.

- Хоол хүнсний зам. Тахлаар өвчилсөн тарваганы мах, махан бүтээгдэхүүнийг дутуу боловсруулан хэрэглэх явцад халдварлана. Илрэх шинж тэмдэг:

- Гэнэт өндөр халуурах
- Толгой хүчтэй өвдөх, эргэх
- Дотор муухайрах
- Бөөлжих,
- Тайван бус болж, нойргүйтэх

- Арьс салстаар халдвар авсан үед булчирхай томорч хүчтэй эмзэглэнэ. (булчирхай цочих)

- Амьсгалын замаар халдвар авсан тохиолдолд гэнэт өндөр халуурч цээжээр өвдөх, ханиалгах, цустай цэр гарах, амьсгаадах

- Хоол боловсруулах замаар халдвар авсан үед суулгах, заримдаа цусаар суулгах шинжүүд илэрнэ.

Тарваган тахлын дараах эмнэлзүйн хэлбэрүүд тохиолдоно.

- Арьсны хэлбэр
- Булчирхайн хэлбэр
- Уушигны хэлбэр
- Үжил хэлбэр
- Гэдэсний хэлбэр
- Залгиур хоолойн хэлбэр

1. Тарваган тахлын арьсны хэлбэр: нян орсон газар үрэвсэн улайж, толбо, гүвдрүү, үүсгэн, цусархаг шүүс бүхий цэврүү болж хувирдаг. Гэмтсэн хэсгийн өөхөн эслэг хавдах ба эмчилгээ эхлээгүй тохиолдолд үрэвсэл маш хурдан өвчин ихтэй хатги болж хувирна.

2. Тарваган тахлын булчирхайн хэлбэр нь:

- Гэмтсэн арьс салстаар нэвтрэн орсон тарваган тахлын нян үржиж, шингэний урсгалаар ойролцоох тунгалгийн зангилаанд хүрч цочмог үрэвслийг үүсгэнэ. Зонхилон суга, хүзүү, цавины булчирхай үрэвсдэг. Үрэвслийн процесс арьсан доорх

өөхөн эслэг, ойролцоох тунгалгийн зангилаануудыг үрэвсүүлэн, барьцалдсан бэрсүү буюу моомыг /бубон/ үүсгэнэ.

- Моом нь орчныхоо эдтэй барьцалдсан, голдоо хатуу, зах уруугаа зөөлөн, хөдөлгөөнгүй, маш их эмзэглэлтэй байдаг. Ийм учраас өвчтөн албадмал байрлалд ордог байна. Булчирхайн тахлыг эмнэлзүйн илрэлээр нь хөнгөн, дунд, хүнд гэж ангилдаг. Моом шимэгдэх, идээлж цоорох, хатуурч ур тогтохын аль нэгээр эдгэрнэ.

- Хүнд хэлбэрийн булчирхайн тахал эдгэрэх шатандаа уушигны хоёрдогч тахал, үжил, мөн мэнэнгээр хүндэрч болно.

Тарваган тахлын уушигны хэлбэр:

Тахлын нян агаар дуслын замаар амьсгалын дээд зам болон нүдний салстад нэвтэрсэн тохиолдолд уушигны хэлбэрийг үүсгэнэ. Уушигны анхдагч тахал тархвар зүйн аюул ихтэй хүнд хэлбэр юм. Гол шинж тэмдэг нь халдварын ерөнхий шинжээс гадна, өндөр халуурах, цээжээр хатгуулан өвдөх, ханиалгах ба цэр эхэн үед хөөсөрхөг, дараа нь шингэн цусархаг болдог.

Өвчний эхлэл үед уушганд ямар нэг эмгэг илрэхгүй. Цэр болон гадаад орчинд тахлын нян ихээр ялгарна. Өвчний 2 дахь өдрөөс уушигны тогшилтын чимээ бүдгэрч нойтон хэрчигнүүр сонсогдож эхэлдэг. Цээжний гялтан хальс үрэвсэж эхлэхэд өвдөлт илэрдэг. Өвчтөнд агаар дутагдсанаас өндийж суух, орноосоо босон харайх, гадаа агаар салхинд гарахыг эрмэлзэж хөөрлийн байдалд орно. Цаашид төв мэдрэлийн системийн эмгэг өөрчлөлтүүд гарч ирнэ. Өвчний төгсгөл үед эмнэлзүйн явц хүндэрч халдвар хордлогын шокод орно. Уушигны хэлбэр нь үжил хэлбэрээр хүндэрч болно.

4. Тарваган тахлын анхдагч үжил хэлбэр

- Тарваган тахлын үүсгэгч цусанд шууд орсноор шарх, моом, уушигны үрэвсэл зэрэг анхдагч голомтлог үрэвслийн шинжгүйгээр шууд эхэлдэг.

- Нууц үе хэдхэн цаг үргэлжилдэг. Өвчин маш хүнд явцтай, гэнэт хүчтэй чичрүүдэс хүрч, өндөр халуурч, толгой хүчтэй өвдөж, биеийн байдал богино хугацаанд хүндэрдэг. Зүрх судасны дутал зонхилж, халдвар хордлогын шокод ордог. Амьсгал өнгөц, хөөсөрхөг шингэн цэр гарна, өвчтөн цусархаг зүйлээр бөөлжих буюу суулгадаг. Өвчтөний өтгөн, шингэн ялгадсанд тахлын нян илэрдэг.

- Хүчтэй хордлогын улмаас ухаан алдаж, дэмийрэх, баримжаа алдах, хэл яриа ээдрэх, толгой хүчтэй өвдөх, эргэх зовиур илэрдэг. Өвчтөн удалгүй хөдөлгөөнгүй, эрс суларсан буюу оворгын байдалд ордог. Хожуу үед цусаар зөөгдөн хоёрдогч голомт үүсдэг. Суга, цавь, чацархай зэрэг олон булчирхайд моом үүсдэг. Арьсан дээр том, жижиг хэмжээтэй хар хөх өнгийн цусан хуралтууд гарна, өвчтөн 1-2 хоногт зүрх, судасны цочмог дутлын улмаас нас барна. \

5. Тарваган тахлын гэдэсний хэлбэр • өвчний энэ хэлбэр халдварын ерөнхий шинжээр илрэхээс гадна ходоод, гэдэсний талаас хүчтэй өөрчлөлт гардаг. Ходоод гэдэс өвдөж, цусархаг зүйлээр бөөлжиж, суулгана. Өвчтөний өтгөнөөр тахлын нян ялгардаг.

6. Тарваган тахлын залгиур хоолойн хэлбэр • энэ хэлбэрийн үед шинж тэмдэг илрэхгүй байж болох тул хөөмийн арчдасны шинжилгээгээр илрүүлнэ. Хамар залгиурын стрептококк болон вирусийн гаралтай үрэвсэлтэй шинж тэмдгийн хувьд адил байх боловч хүзүүний тунгалгийн зангилаанууд илүү том бөгөөд эмзэглэлтэй байдаг. Халдвар судлалын асуумж, сэжигтэй мэдүүлэггүй тохиолдолд оношны алдаа гарч болох тул лабораторийн шинжилгээгээр оношийг магадална.

Одоогийн байдлаар 17 аймгийн 137 суманд тарваган тахлын байгалийн голомт орших ба идэвхтэй голомт манай улсын нийт нутаг, дэвсгэрийн 28.3 хувийг эзэлдэг байна. Өнгөрсөн 10 жилийн хугацаанд Архангай, Баянхонгор, Баян-өлгий, Завхан,

Говь-Алтай зэрэг 11 аймгийн 25 суманд тарваган тахал өвчнөөр нийт 36 хүн өвчилж 10 хүн нас барсан байна.

Сэргийлэлт

1. Сэжиг бүхий үхсэн мэрэгч амьтдын сэг зэмтэй тааралдвал мэргэжлийн байгууллагад хандах

2. Нохой зууж ирсэн тарвагад хүрэхгүй байх, хөдөлгөөн нь удааширсан тарвагыг агнахгүй байх, арьс, махыг ашиглахгүй байх

3. Тарвагыг нохойгоор бариулах, хавхаар агнахыг цээрлэх

4. Өвчний шинж тэмдэг илэрсэн тохиолдолд эмнэлгийн байгууллагад мэдэгдэх гэхдээ өвчтөнтэй ойр байсан хүнээр хэл хүргүүлэхээс татгалзах, учир нь халдвар тархаж болзошгүй юм.

5. Сэжигтэй өвчтөн болон эд материалтай холилдсон хүнийг тусгаарлах

6. Сэжиг бүхий эд материал, өвчтөний хэрэглэж байсан зүйлсд онош тодрохоос нааш хүрэлцэхгүй байх

7. Тарвага агналтыг зөвшөөрсөн газарт, тогтоосон хугацаанд сэргийлэх тарилга хийлгэсэн хүн хийх

8. Тарвага зурам агнахыг хориглох, түүнтэй харьцахгүй байх, тарваганы ичээ, нүх ухаж, нүх дошны дэргэд сууж амрахгүй байх

9. Гэртээ тарвага өвчих, нойтон арьс хадгалах, боловсруулаагүй мах оруулахыг цээрлэх

10. Голомттой нутгийн анчид, арьсны наймаачид, тарваганы мах идэх дуртай хүмүүсийг сэргийлэх вакцинд хамруулах шаардлагатай юм.

Хорио цээр тогтоох үйл ажиллагаа

Хүн малын гоц халдварт өвчний хорио цээрийн хязгаарлалтын бүс тогтоох, уг бүсэд явуулах үйл ажиллагааг:

1. Хорио цээр, хязгаарлалт тогтоосон бүсэд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

2. Хорио цээрийн бүсийг тогтоох аргачлал

3. Хорио цээрийн дэглэмийн бүсийн бүдүүвч (загвар)

4. Хүн, мал, амьтны гоц халдварт өвчний үед хорио цээрийн дэглэмийг хэрэгжүүлэх зохион байгуулалт

Хорио цээр, хязгаарлалт тогтоосон бүсэд хэрэгжүүлэх үйл ажиллагаа хорио цээр, хязгаарлалт тогтоосон бүсэд гамшгаас хамгаалах тухай хуулийн 19.1-д заасан шуурхай бүлэг ажиллана¹⁷. Шуурхай бүлэг нь мал, амьтны гоц халдварт өвчний хорио цээр, хязгаарлалт тогтоосон бүсэд дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Мал, амьтны гоц халдварт өвчний улмаас халдварын голомтод учирсан хор уршгийг арилгах үйл ажиллагааг тухайн нутгийн захиргааны байгууллагатай хамтран шуурхай удирдан зохион байгуулах;

2. Хорио цээр, хязгаарлалт тогтоосон бүсэд халдварын голомтыг устгах, ажиллах хүч хэрэгслийг зохион байгуулах, мэргэжлийн анги болон нутгийн иргэдийг дайчлан ажиллуулах, нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

3. Өвчний цагийн байдлыг холбогдох мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор тогтмол үнэлж, шийдвэр гарган хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

4. Өвчний голомтыг устгах, тархалтыг таслан зогсоох, учирсан хохирлыг богино хугацаанд арилгахад шаардагдах халдваргүйжүүлэх бодис, техник хэрэгсэл, халдвар хамгааллын хувцас, ариутгалын тоног төхөөрөмж, бусад бараа,

¹⁷ Төрийн мэдээлэл сэтгүүл 2003 он №25

бүтээгдэхүүний тооцоог гаргаж тухайн нутгийн захиргааны байгууллага болон онцгой байдлын төв байгууллагад хүргүүлэх;

5. Шуурхай бүлэг, мэргэжлийн ангийн ажиллах байр болон голомтын бүсэд холбоо, мэдээллийн сүлжээ бий болгох ажлыг зохион байгуулах;

6. Хорио цээр, хязгаарлалт тогтоосон нутгийн зааг, бүсэд зорчигч, тээврийн хэрэгсэл орох, гарах, дамжин өнгөрөх цэг, зурвасыг гамшгийн болон мэргэжлийн хяналтын улсын байцаагч, мал эмнэлгийн болон нутгийн захиргааны байгууллагатай хамтран тогтоож, анхааруулсан тэмдэг тавиулах, харуул хамгаалалт ажиллуулах;

7. Гоц халдварт өвчний эх үүсвэр, гаралт, дэгдэлт, тархалтын шалтгааныг нарийвчлан тогтоох талаар холбогдох байгууллагад дэмжлэг үзүүлэх;

8. Халдварын голомтод байгаа байнгын оршин суугчдад хүнс, өргөн хэрэглээний бараа, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг нутгийн захиргааны байгууллагатай хамтран хүргэх;

9. Халдварын тархалтаас сэргийлэх, голомтыг устгах ажлын хэрэгжилтэд хяналт тавих;

10. Хорио цээрийн онцгой бүсээр дамжин өнгөрөх зорчигч, тээврийн хэрэгсэлд хяналт тавьж, нэвтрэх зөвшөөрөл олгох;

11. Зэрлэг ан, амьтдын хөдөлгөөнд хяналт тавих, шаардлагатай тохиолдолд өвчний тандан шинжилгээ хийх асуудлыг байгаль орчны байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

12. Хорио цээр, хязгаарлалтын бүсэд байгаа байнгын оршин суугч болон тэнд ажиллаж байгаа хүмүүсийг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах, хяналт тавих, халдвараас сэргийлэх талаар мэдээлэл хийж аюулгүй ажиллах нөхцөлөөр хангах.

13. Хорио цээр, хязгаарлалт тогтоосон бүсэд мал эмнэлгийн нарийн мэргэжлийн, хяналтын, устгалын, шалган нэвтрүүлэх болон зорчигч тээврийн хэрэгсэл халдваргүйжүүлэх, хэв журам сахиулах зэрэг мэргэжлийн анги ажиллана.

14. Мэргэжлийн ангийг гамшгаас хамгаалах тухай хуулийн 27.1.2-т заасны дагуу байгуулна.¹⁸ Үүнд:

1. Мал, амьтны гоц халдварт өвчин гарсан нутгийн мал, амьтанд үзлэг, тандалт хийж өвчний тархалтын зааг хязгаарыг тогтоож байх;

2. Өвчний халдварыг таслан зогсоох, голомтыг устгах арга хэмжээг зохион байгуулах үүрэгтэй мал эмнэлгийн удирдах болон үйлчилгээний нэгжүүдийн мэргэжилтэн оролцсон мэргэжлийн багийг байгуулан ажиллуулах;

3. Гоц халдварт өвчнөөр өвчилсөн, үхсэн, өвчний сэжигтэй мал, амьтнаас холбогдох стандарт, зааврын дагуу дээж авах, дээжийг аймаг, бүс, улсын лабораторид хүргүүлэх ажлыг зохион байгуулах;

4. Лабораторийн шинжилгээний дүнг үндэслэн өвчний тархалт, халдварын явц, байгаль орчин, хүн амын бөөгнөрөл, зам, тээврийн ачаалал зэрэг хүчин зүйлийг харгалзан дор дурдсан. -халдварын голомт -сэжигтэй -хамгаалалтын -эрүүл гэсэн 4 бүсийг тогтоох санал боловсруулах;

5. Гоц халдварт өвчний ил шинж тэмдэгтэй болон лабораторийн шинжилгээгээр эерэг урвалзүүлсэн мал, амьтныг богино хугацаанд ялган тусгаарлаж тухайн өвчинтэй тэмцэх зааврын дагуушаардлагатай арга хэмжээг шуурхай зохион байгуулах;

¹⁸ Төрийн мэдээлэл сэтгүүл 2003 он №25

6. Өвчний голомт дахь эрүүл мал, амьтанд үзлэг, тандалт хийж, уг өвчнөөс сэргийлэх вакцинхийх, устгалын цэг байгуулах, хашаа, хороо, уст цэг, малын тоног хэрэгслийг халдваргүйжүүлэх ажлыг зохион байгуулах;

7. Шаардагдах вакцин, халдваргүйжүүлэх бодис, бэлдмэл, техник хэрэгслийг захиалах, хуваарилах, өвчинтэй тэмцэх үйл ажиллагаанд мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийг татаноролцуулах;

8. Өвчтэй малыг устгах ажлыг холбогдох зааврын дагуу холбогдох мэргэжлийн ангитай хамтран зохион байгуулж, устгал, ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн тухай акт үйлдэх;

9. Өвчний цагийн байдлын талаархи мэдээ, мэдээллээр шуурхай бүлэг, нутгийн захиргааны байгууллагыг хангах;

10. Тээврийн хэрэгсэл, хувцас хэрэглэл халдваргүйжүүлэх цэгийг голомт болон сэжигтэй бүсийн хөдөлгөөний гол чиглэлүүдэд холбогдох мэргэжлийн ангиудтай хамтран байгуулах;

11. Өвчний эх үүсвэр, дэгдэлт, гаралт, тархалтын шалтгааныг нарийвчлан тогтоох тандалтын багийг зохион байгуулах.

Мэргэжлийн хяналтын байгууллага шуурхай бүлэг, нутгийн захиргааны байгууллагын удирдлага, дэмжлэгтэйгээр дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ: Үүнд:

1. Гамшгаас хамгаалах болон мэргэжлийн хяналтын улсын байцаагч нар холбогдох хууль тогтоомжийн дагуу гоц халдварт өвчний голомтыг устгах арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих;

2. Хорио цээр, хязгаарлалт тогтоосон бүс нутгаас халдвар алдагдах, улсын хилээр халдвар орохоос сэргийлэх зорилгоор байнгын болон хөдөлгөөнт эргүүл ажиллуулах;

3. Шуурхай бүлгээс олгосон зөвшөөрлийг үндэслэн хорио цээр, хязгаарлалтын бүсээр дамжин өнгөрөх зорчигч, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх, хорио цээр, хязгаарлалтын бүсийн хүн ам, мал, амьтны хөдөлгөөнд хяналт тавих;

4. Хорио цээрийн дэглэм зөрчсөн аж ахуйн нэгж, байгууллага, иргэн, албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага хүлээлгэж энэ тухай шуурхай бүлгийн даргад илтгэх.

Гоц халдварт өвчнөөр үхсэн мал, сэг, зэм устгах мал эмнэлэг, цагдаа, онцгой байдал, мэргэжлийн хяналтын байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн мэргэжлийн анги, шуурхай бүлэг, нутгийн захиргааны байгууллагын удирдлага, дэмжлэгтэйгээр дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1. Устгал хийх мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүний хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангах;

2. Устгал хийх ажиллагаанд хэрэглэгдэх техник хэрэгсэл, хамгаалах хувцас, химийн бодис, галт хэрэгсэл, устгал хийх нүхийг зааврын дагуу бэлтгэх;

3. Гоц халдварт өвчний ил шинж тэмдэгтэй болон лабораторийн шинжилгээгээр эерэг урвал үзүүлсэн мал, тэжээвэр амьтдыг малын эмчийн үйлдсэн актыг үндэслэн хүлээн авч зааврын дагуу устгах ажлыг гүйцэтгэх;

4. Устгасан мал, амьтдыг булшлах ажлыг гүйцэтгэж, орчныг халдваргүйжүүлэн хашаа хамгаалалт хийж, анхааруулах тэмдэг тавьж аймаг, сумын засаг захиргааны болон мэргэжлийн байгууллагад албан ёсоор хүлээлгэн өгөх;

5. Өвчтэй малыг устгасан ажлын гүйцэтгэлийн талаар шуурхай бүлэгт цаг тухайд нь илтгэх.

Шалган нэвтрүүлэх болон зорчигч, тээврийн хэрэгслийг халдваргүйжүүлэх мэргэжлийн анги нь шуурхай бүлэг, нутгийн захиргааны байгууллагын удирдлага, дэмжлэгтэйгээр дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1. Халдварын голомт бүхий газраар дамжин өнгөрөх зорчигч, тээврийн хэрэгслийг халдваргүйжүүлэх, шалганнэвтрүүлэх суурин болон явуулын байрыг орон нутгийн нөөц боломжид тулгуурлан байгуулах;

2. Халдваргүйтгэх бодис, бэлдмэлээс дээж авч лабораторийн шинжилгээнд илгээж баталгаа гаргуулах, тэдгээрийн нөөцийг бүрдүүлэх;

3. Хорио цээр, хязгаарлалтын бүсээр дамжин өнгөрөх зорчигч, тээврийн хэрэгсэлд шуурхай бүлгээс олгосонтусгай зөвшөөрлийн баримт бичгийг үндэслэн бүртгэл хөтөлж, зохих зааврын дагуу халдваргүйжүүлж нэвтрүүлэх;

4. Голомтын бүсэд оруулах хүнс, бараа, бусад зүйлийг тогтоосон цэгт тусгайлан бэлтгэсэн талбай /тавцан/-д буулгаж сэлгүүлэн хүргүүлэх ажлыг зохион байгуулах;

5. Голомтын бүсэд байгаа хүн ам, ердийн болон авто тээврийн хэрэгслийг нэг бүрчлэн бүртгэж тэдгээрийн хөдөлгөөнд хяналт тавих;

6. Хорио цээр, хязгаарлалтын дэглэм цуцлагдсан үед шалган нэвтрүүлэх байранд үүрэг гүйцэтгэсэн нийт биебүрэлдэхүүний хувцас, багаж хэрэгслийг халдваргүйтгэх.

Хэв журам сахиулах мэргэжлийн анги нь шуурхай бүлэг, нутгийн захиргааны байгууллагын удирдлага, дэмжлэгтэйгээр дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1. Хорио цээр, хязгаарлалт тогтоосон бүсэд холбогдох хууль тогтоомж, журмын дагуу харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэж зорчигч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавих;

2. Хорио цээр, хязгаарлалт тогтоосон бүсэд гэмт хэрэг, хэв журмын зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх;

3. Шалган нэвтрүүлэх болон зорчигч, тээврийн хэрэгслийг халдваргүйжүүлэх цэгүүдэд дэг журам сахиулах;

4. Хорио цээр, хязгаарлалтын бүсэд байгаа хүн амын дунд нийгмийн хэв журам сахиулах, гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах.

Хорио цээр, хязгаарлалт тогтоосон үед иргэн, хуулийн этгээдийн хүлээх үүрэг

1. Хорио цээр, хязгаарлалт тогтоосон үед холбогдох хууль тогтоомж, шийдвэрийг дагаж мөрдөх.

2. Мал эмнэлгийн үзлэг, сэргийлэх тарилгад мал, тэжээвэр амьтнаа бүрэн хамруулах, шаардагдах хашаа, байр, хүн хүчээр хангах, малыг байнгын хариулгатай байлгаж, арчилгаа, маллагааг сайжруулах.

Хорио цээр, хязгаарлалт тогтоосон нутаг дэвсгэрт хориглох зүйл

1. Зөвшөөрөгдсөнөөс бусад газраар хүн, мал, тэжээвэр амьтан, тээврийн хэрэгсэлорох, гарах, дамжин өнгөрөх;

2. Мэргэжлийн болон эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр бэлчээр, нутагсэлгэх, хүн, мал, тэжээвэр амьтан, тээврийн хэрэгслийн шилжилт, хөдөлгөөн хийх, нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулах, хүн, мал, амьтны бөөгнөрөл бий болгох;

3. Мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, малын тэжээл бэлтгэх, тээвэрлэх, ахуйн хэрэглээнд мал нядлах;

4. Өвчтэй мал, амьтны хашаа, байр, тоног төхөөрөмжийг халдваргүйжүүлэлгүйгээр хэрэглэх, малын хашаа, байранд мал эмнэлэг, хяналтын ажилтны зөвшөөрөлгүйгээр гадны хүн оруулах;

5. Халдварын голомтын болон сэжигтэй бүсэд мал, амьтныг нийлүүлэх;

6. Халдварын голомтын болон сэжигтэй бүсэд үйлчилдэг авто тээврийн хэрэгсэл, ердийн хөсгийг халдваргүйтэхгүйгээр тайван бүсэд тээвэр хийлгэх.

7. Голомтод ажилласан мэргэжлийн ангийн ажилтанд олгох цалин хөлс, нөхөн төлбөр

8. Олон улсын хөл хориот өвчний голомтод гэнэтийн дайчилгаагаар ажилласан эрүүл мэндийн ажилтаны цалин хөлсийг 3 дахин нэмэгдүүлж, дайчилгааг зохион байгуулсан газраас голомт цомхотгосноос хойш 1 сарын дотор олгоно.

9. Эрүүл мэндийн ажилтан олон улсын хөл хориот өвчний голомтод ажиллаж халдвар авсны улмаас болон өвчтөнд эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх үүргээ гүйцэтгэх үедээ гадны шалтгаанаар амь насаа алдвал ар гэрт нь түүний 3 жилийн цалин хөлстэй тэнцэх хэмжээний нөхөн төлбөрийг 1 удаа, хөдөлмөрийн чадвараа түр алдах буюу тахир дутуугийн зэрэг тогтоогдвол тэтгэмж, урьд авч байсан цалин хөлсний зөрүүг тэтгэмж авч байгаа хугацаанд ажил олгогч олгоно.

10. Энэ нь олон улсын хөл хориот өвчний голомтод болон эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх ажилд дайчлагдан ажилласан иргэнд мөн адил хамаарна. Харин дайчлагдан ажилласан иргэн нь тогтмол ажил эрхэлдэггүй бол цалин хөлсийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тогтооно.

11. Малын гоц халдварт өвчний голомтод дайчилгаагаар ажиллах малын эмч, мал зүйчийг хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэглэлээр хангах, тэдний томилолтын зардлыг ердийн үеийнхээс 3 дахин нэмэгдүүлж дайчилгааг зохион байгуулсан байгууллага олгоно.

12. Малын эмч, мал зүйч малын гац халдварт өвчний голомтод ажиллаж халдвар авсны улмаас буюу албан үүргээ гүйцэтгэх үедээ амь насаа алдвал түүний ар гэрт албан тушаалынх нь 3 жилийн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг ажил олгогч олгоно.

13. Голомтод ажилласан онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын албан хаагч болон иргэнд томилолтын зардлыг ердийн үеийнхээс гурав дахин өсгөж олгоно.

Хорио цээрийн бүсийг тогтоох аргачлал мал амьтны гоц халдварт өвчин гарсан үед хорио цээрийн дэглэм тогтоох бүийг мэргэжлийн байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн аймаг, орон нутгийн засаг даргын захирамжаар тогтооно. Хорио цээрийн дэглэм тогтоох нутаг дэвсгэрийг дараахь 4 бүсэд хуваана.

А. Халдварт өвчний голомтын бүс /голомт/. Гоц халдварт, халдварт өвчин анх гарсан нутаг дэвсгэрт бэлчээр, ус нэгтэй нэг ба хэд хэдэн хот айл, байран маллагааны цогцолборыг бусад хот айл, цогцолбороос тусгаарлан хамгаалалтанд авч хүн, мал, тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнийг бүрэн хориглосон бүсийг хэлнэ.

Б. Сэжигтэй бүс. Бэлчээр, ус тусгаар боловч халдварын голомттой хил залгаа оршдог, уг өвчний халдвар авсан байж болзошгүй хэдий ч өвчний ил шинж тэмдэг илрээгүй байгаа хот айлуудыг хамруулан хорио цээрийн онцгой дэглэм тогтоосон бүсийг хэлнэ. Тус бүсэд байнгын харуул, пост ажиллуулна. Сэжигтэй бүсийн өргөн 10 км-ээс доошгүй байх бөгөөд айлуудын байршил, тухайн бүс нутгийн онцлогоос хамаарч дээрх зай өөр өөр байдаг.

В. Хамгаалалтын дархлаажуулсан бүс өвчний халдвар эхэлсэнээс хойш голомтын ба сэжигтэй бүсээс хүн, мал тухайн нутаг дэвсгэрт орж ирээгүй байгаа хот айлуудыг хамруулан сэжигтэй бүсийн заагаас гадна талд тогтооно. Хамгаалалтын бүсийн өргөн сэжигтэй бүсээс 10 км зайд орших бөгөөд өдрийн цагаар хөдөлгөөнт эргүүл томилон ажиллуулна.

Г. Эрүүл бүс хамгаалалтын бүсийн заагаас гадна орших өвчний халдвар дамжин тархах эрсдэл бага боловч өвчний тархалтаас урьдчилан сэргийлж дархлаажуулсан эрүүл мал бүхий нутаг дэвсгэрийг хэлнэ. Нэг сумын нутаг дэвсгэр дээр хоорондоо зайтай хэд хэдэн голомт үүссэн нөхцөлд тус бүрд нь дээрхи бүсүүдийг тогтоох бөгөөд голомтууд ойртох тусам тэдгээрийг нэгтгэн нэг голомтод хамруулна.

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ЭРЭН СУРВАЛЖЛАХ АЖИЛЛАГААГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗАРИМ АСУУДАЛ

Д. Бямбахүү

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн
ЦЭЗТ-ийн багш, цагдаагийн хошууч

Эрэн сурвалжлах ажил нь цагдаагийн байгууллагын гол үүргийн нэг бөгөөд гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын чухал бүрэлдэхүүн хэсэг юм.

Цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлалт гэдэг нь: Шүүх, прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаалт, хорих газраас оргосон сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан, сураггүй алга болсон хүн, хэн болох нь тодорхойгүй цогцос, хулгайлагдсан болон алга болсон эд зүйлс, автомашин, галт зэвсэг, мансууруулах хордуулах бодис, оршин суух зөвшөөрөл нь дууссан боловч хяналтанд байхгүй байгаа гадаадын иргэн, интерполийн болон бусад цагдаагийн байгууллагын шугамаар зарлагдсан хүн, эд зүйл, олдож ирсэн бичиг баримт, мал, эд зүйлийн эзэмшигчийг олох зорилготой, хуулийн дагуу явуулж байгаа шуурхай үйл ажиллагаа гэж үзэж болно.

Эрэн сурвалжлах ажилд гэмт хэргийн мэдээ мэдээлэл, тоо бүртгэл нэн чухал. Энэ ажлын зорилго нь гэмт хэргийн гаралт, түүнийг үйлдсэн этгээд, гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хэргийн хөдөлгөөн, шийдвэрлэсэн байдлыг бодитой бүртгэж улмаар эрүүгийн нөхцөл байдал, гэмт хэргийн халдлагад дүн шинжилгээ хийх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд төр засаг, хууль хяналтын байгууллагад туслах, тэднийг шаардлагатай мэдээллээр хангахад чиглэгдэнэ.

Цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах ажлыг түргэн шуурхай тасралтгүй байлгах нэг хүчин зүйл бол цагдаагийн байгууллагын мэдээллийн сан юм. Цагдаагийн байгууллагын мэдээллийн сан хэдий чинээ боловсронгуй байх тусам гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа, түүний дотор эрэн сурвалжлах ажилд ахиц гарна.

Өнөө үед гэмт хэрэг, гэмт хэрэгтэнтэй тэмцэхэд шинжлэх ухаан, технологийн дэвшлийг өргөнөөр нэвтрүүлж ашиглах нь нэн тулгамдсан асуудал болоод байна. Гадаадын зарим улс орнууд гэмт хэрэгтнүүдийг мөрдөх, тэдний үйлдсэн гэмт хэргийг илрүүлэх нотлох, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсооход уламжлалт аргаас гадна шинжлэх ухаан, технологийн аргуудыг болон мэдээллийн төрөл бүрийн санг бий болгон өргөнөөр ашиглаж эхэлсэн нь үр дүнтэй байна¹⁹.

Өнөөдөр гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх үүрэг бүхий хэрэг бүртгэх, мөрдөн байцаах газар, эрүүгийн цагдаагийн газар, нийтмийн хэв журам хамгаалах газар, замын цагдаагийн газар, аймаг орон нутаг, дүүргүүдийн цагдаагийн газар, хэлтэс зэрэг олон алба гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, иргэдийн аюулгүй байдлыг хангах, үүрэг гүйцэтгэж байгаа ч үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчил бүрийг бүрэн дүүрэн илрүүлж чадахгүй байгаа нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд орчин үеийн техник технологи нэвтрүүлж ашиглах явдлыг тэргүүлэх чиглэл болгон тодорхойлж, гэмт хэрэгтэй тэмцэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, нийтийн хэв журам сахиулах үйл ажиллагаанд цагдаагийн байгууллагын мэдээллийн санг ашиглах явдлыг нэмэгдүүлэх, мэдээллийн сангийн үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай байна.

¹⁹Цагдаа судлал сэтгүүл 2013 №3. 47 дахь тал

Монгол улсын бүх төрийн байгууллагууд нь төрийн байгууллагын цахим сан ашиглаж байх хууль батлагдан гарсан бөгөөд одоогийн байдлаар энэхүү санг өргөнөөр ашиглаж байна.

Цагдаагийн байгууллага мэдээллийн сан үүсгэж ашиглах эрх зүйн зохицуулалтыг шинэчлэн найруулсан цагдаагийн албаны тухай хуулийн **16 дугаар зүйлийн 16.1.1-д** “Цагдаагийн байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх стандарт, дүрэм, журам, зааврыг боловсронгуй болгох, энэ зорилгоор хууль сахиулах үйл ажиллагаатай холбоотой сан бүрдүүлэх, дүн шинжилгээ хийх” гэж цагдаагийн албаны тухай хуульд заасан нь цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаандаа төрөл бүрийн мэдээ, мэдээллийн сан ашиглахаас гадна дээрхи хуульд заасан чиглэлээр болон бусад чиглэлээр судалгаа хийж сан бүрдүүлж ажиллах талаар зааж өгсөн байна.

Одоогийн байдлаар цагдаагийн байгууллага нь:

“Гэмт хэргийн мэдээллийн сан”, “Сэжигтний мэдээллийн сан”, “Сэжигтэн, яллагдагчийг баривчилсан, түүнд таслан сэргийлэх арга хэмжээ авсан, хүчингүй болгосон, өөрчилсөн тухай мэдээллийн сан”, “Статистикийн мэдээллийн сан” зэрэг хорь гаруй мэдээллийн санг төрөлжүүлэн ашиглаж байна.

Түүнээс гадна Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд гарын мөрний папилон сан, Галт зэвсгийн сумны хонгио, хошууны сан зэрэг сан үүсэж онц ноцтой гэмт хэргийг илрүүлэх, хэн болох нь тодорхойгүй цогцсийг тогтоох, эзэн холбогдогч нь тогтоогдоогүй гэмт хэргүүдийг нөхөн илрүүлэхэд ашиглаж байгаа ч өнөөгийн шаардлагыг бүрэн хангаж чадахгүй байна.

Тиймээс цагдаагийн байгууллагын мэдээллийн санг боловсронгуй болгох гэмт хэргийг илрүүлэхэд шинжлэх ухааны ололт амжилт, орчин үеийн техник технологи ашиглаж гэмт хэргийг шинжлэх ухааны үндэслэлтэй нотлох, гэмт хэрэг мөрдөн шалгах ажиллагаанд ашиглаж байгаа хуучинсаг арга барилыг халж, гэмт хэргийг нотлох ажиллагаанд ДНХ-ийн сан бүрдүүлэн энэхүү санг бусад сантай холбох нэгдсэн сан үүсгэж, түүнийгээ гэмт хэрэг илрүүлэхэд өргөнөөр ашиглах шаардлага тулгарч байгаа билээ.

Гадаадын зарим улс орнууд тухайлбал: Итали, Греки, Ирланд, Хятад, Өмнөд Солонгос, Тайланд, Энэтхэг, Япон, Малайз, Вьетнам, Шинэ Зеланд, Маврити, Өмнөд Африк, Нигери, Бразили, Чили, Аргентин зэрэг улс орнууд гэмт хэргийн холбогдсон хүмүүст ДНХ-ийн шинжилгээ хийж генетик мэдээллийн сан бүрдүүлэх тухай хууль батлуулах, хэрэгжүүлэх ажиллагааг эрчимтэй явуулах бодлого боловсруулан ажиллаж байгаа нь дэвшилттэй байна.²⁰

Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсад ДНХ-ийн шинжилгээний технологийг хамгийн үр дүнтэй хэрэглэж байгаа бөгөөд 6 сая гаруй хүний генийн мэдээллийг үндэснийхээ “Генетик мэдээллийн сан”-д оруулсны үр дүнд гэмт хэргийг илрүүлэх ажилд нь ихээхэн ахиц гарсан талаар мэдээлсэн байна.

АНУ-д 2006 оны байдлаар гэмт хэргийн холбогдолтой ДНХ-ийн шинжилгээ хийдэг 180 лаборатори ажилладаг бөгөөд гэмт хэрэгт холбоотой 3,6 сая гаруй хүний ДНХ-ийн мэдээлэл хадгалагдаж байгаа тухай мэдээлэл байдаг.

АНУ-ын Холбооны мөрдөх товчоо “Combined DNA Index System” (CODIS) үндэсний хэмжээний ДНХ-ийн мэдээллийн сан бий болгосноор давтан гэмт хэрэгтэнг танин тогтоох, эзэн холбогдогч нь тодорхойгүй хэргийг илрүүлэх нэн чухал боломжийг нээж өгснийг тэмдэглэжээ.

²⁰www.dnaresource.com

Монгол Улсын Ерөнхийлөгч 2010 оны УИХ-ын нэгдсэн хуралдаанд цаазаар авах ялтай холбогдуулж хэлсэн үгэндээ “Цаазтай хэргийн нотлох баримтад ДНХ-ийн шинжилгээг заавал оруулахыг шаарддаг зарим өндөр хөгжилтэй оронд уг хэрэгт холбогдон хоригдож байсан хүмүүс гэмт хэрэг үйлдээгүй нь нотлогдож хэдэн арваараа суллагдсан тохиолдол ч байдаг” гэж дурдсан байна. Энэ санааг Шүүхийн шинжилгээний үйл ажиллагааны нэг хэсэг болгон хөгжүүлэх материаллаг бааз, мэргэжилтэй боловсон хүчин сургах, бэлтгэх ажлыг эрчимжүүлэх, цаашид цаазтай хэрэгт Шүүх-ДНХ-ийн шинжилгээг заавал хийж байх нь нэн чухал гэж бид үзэж байна.

Орчин үед онц хүнд, ноцтой болон бусад гэмт хэргийн эзэн холбогдогчдыг гагцхүү шүүх-ДНХ-ийн шинжилгээний үр дүнгээр тогтоохоос өөр арга байхгүйг дэлхий нийтэд хүлээн зөвшөөрч байна.

Өндөр хөгжилтэй улс орнууд ДНХ-ээр гэмт хэргийн холбогдогчдыг адилтган харьцуулахын тулд тусгайлан гаргасан хуулиар эрх зүйн орчинг нь зохицуулж байна. Тухайлбал, Англи, АНУ-д 1994 оноос ДНХ-ээр адилтган харьцуулах хуулийг мөрдөж эхэлсэн ба сэжигтэн, яллагдагчдын ДНХ-ийн мэдээллийн нэгдсэн сантай болсон байна.

Германд 1998 оноос ДНХ-ээр адилтган харьцуулах хуулийг баталсан бөгөөд гэмт хэрэг үйлдсэн сэжигтэнд ДНХ-ийн шинжилгээ хийж үр дүнг “Генетик мэдээллийн сан”-г бий болгосон ба сүүлийн үеийн мэдээллээр нэг сая гаруй хүний генетик мэдээлэл энэ санд хадгалагдаж байна.

Франц улсад 1998 онд “Генийн тамга” нэртэй хуулийг гаргах шийдвэрийг гаргасан байдаг.

Оросын холбооны улс 2009 оноос “Генийн бүртгэл тухай”-ийн хуулийг батлан гаргаж одоо хэрэгжүүлэн ажиллаж байна.

Манай улс “Генетик мэдээллийн нэгдсэн сан”-г бий болгох эрх зүйн орчинг бий болгох зорилгоор 2012 онд ХЗДХ сайдын 16 тоот тушаалаар “Генетик мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, ашиглах журам” батлуулан ажиллаж байна.

Монгол Улсын ШШҮХ-ийн ДНХ-ийн лаборатори нь 2009 оноос хууль хяналтын байгууллагын тогтоол, захирамжийн аутосом хромосомын 15 локус буюу үзүүлэлтийг PowerPlex-16, AmpFlSTR® Identifier ДНХ оношлуур, Y-хромосомын 12-17 локусыг PowerPlex-Y, AmpFlSTR® Y-filer ДНХ оношлуур хэрэглэн ДНХ-ийн шинжилгээ хийх арга технологийг шинжилгээний практикт нэвтрүүлэн олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн арга, технологи, стандартаар хийж байна²¹.

Монгол Улсын Цагдаагийн байгууллага 2012 онд олон улсын шүүх-ДНХ-ийн шинжилгээний практикт нэвтрээд байгаа “Power Plex-Y23 systems” шинэ технологийг 2013 онд Монголын шүүхийн шинжилгээний практикт нэвтрүүлэн ажиллах зорилго тавин ажиллаж байна.

Үүнээс гадна Цагдаагийн байгууллага нь Интерполын тусгай сүлжээ I-24/7, цахим шуудан, телефон утас, факс, шуудангаар харилцаж “Интерполын гишүүн орнуудын интерполын төв товчоотой харилцаж “гарын мөрийн папилон сан, гэрэл зураг, цахим мэдээлэл, ДНХ-ийн мэдээлэлээс гадна Цагдаагийн байгууллагын мэдээллийн сүлжээ, сан, тоо бүртгэлийн мэдээллийг шууд авч ашиглаж байна.

Одоогийн байдлаар цагдаагийн байгууллага нь Интерполын хүсэлтээр дотоодын мэдээллийн сангаас дараах төрлийн мэдээллийг гарган өгч хамтран ажиллаж байна. Үүнд:

²¹www.dnaresource.com

- Эрэн сурвалжлагдаж байгаа болон сураггүй алга болсон хүн, хулгайлагдсан автомашин болон бусад эд хөрөнгийн талаарх мэдээ
- Ял шийтгэлийн, гарын мөрийн дардасны, гэрэл зураг, ял шийтгэл эдэлж байгаа ялтан, утасны дугаар эзэмшигч, автомашин эзэмшигчийн бүртгэл мэдээлэл
- Паспортын анкет, гэрэл зураг, компанийн бүртгэл, жолооны үнэмлэх, эрх эзэмшигчийн бүртгэл, татварын бүртгэлтэй холбоотой бичиг баримтуудын мэдээллийн сангийн мэдээллийг солилцож байна²².

Түүнчлэн Монгол улсын Засгийн газраас иргэний бүртгэл, мэдээлэл, хөдөлмөрийн нөөцийн тэнцлийн статистик, улсын төсөв, татвар, гааль, нийгмийн даатгал, хөрөнгийн бирж, төрийн өмчийн бүртгэлийн сан, хууль тогтоомжийн лавлагааны сан, байгаль орчны мэдээллийн сан зэрэг салбарын чиглэлтэй мэдээллийн төрөлжсөн сангууд байгуулах талаар зохих шийдвэр гарган хэрэгжүүлж ирснээр манай улсад зарим салбарт мэдээллийн олон арван сан бий болсон ч эдгээр мэдээллийн сангийн уялдаа холбоо маш хангалтгүй байна.

Монгол Улс Үндсэн хуулиараа эдийн засгийн эрх чөлөө, хувийн өмч, эд хөрөнгийн халдашгүй эрхийг тунхагласан боловч бодит амьдралд өмчийн албан ёсны бүртгэлийн тогтолцоо бүрэн гүйцэд төгөлдөршөөгүйгээс хөрөнгийн тоо хэмжээ, зах зээлийн үнэлэмж тодорхойгүй, хөрөнгийн арилжаа баталгаагүй байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл нь асар их мэдээлэл агуулж байдаг учраас эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн баазын даац хэтрэх, хандах хэрэглэгчийн тоо нэмэгдсэнээс мэдээлэл боловсруулах процессын үйлдлүүд удаашрах зэрэг бэрхшээл гарч байна.

Эдгээр цахим мэдээллийн сан нь тухайлбал: Иргэний бүртгэлийн, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн, төр, захиргаа, нийгмийн даатгал, гааль, татвар, цагдаа, хил хамгаалах албаны зэрэг бүртгэл, мэдээллийн сангууд нь салангид, хоорондоо хөрвөх боломжгүй, харилцан холбогдоогүй байгаа нь цагдаагийн байгууллага гэмт хэргийг түргэн шуурай илрүүлэх, гэмт хэргийн илрүүлэлтийн өсөлтийн хувийг нэмэгдүүлэхэд сөргөөр нөлөөлж байна.

Иймд даяарчлагдан хөгжиж байгаа өнөөгийн орчинд өөрийн орны хөгжлийг урьдчилан харсан бодлого, стратеги боловсруулж хэрэгжүүлэхэд нэгдсэн бүртгэл мэдээллийн бааз суурь дээр тулгуурласан мэдээллийн сан бий болгох явдал чухал.

Төрийн үйлчилгээний байгууллагууд мэдээллээ тус тусдаа бүрдүүлж, мэдээллийг харилцан уялдаагүй олон мэдээллийн санд хадгалж, үйлчилгээ үзүүлж байгаа явдлыг арилгаж, нэгдсэн нэг мэдээллийн санг бэхжүүлэх зорилгоор Монгол Улсад бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох үндэсний хөтөлбөрийг боловсруулан ажиллаж байна.

Дэлхийн хөгжингүй улс орнууд өөрийн Засгийн газрын үйл ажиллагааг оновчтой болгох, төрийн байгууллагуудын хоорондын уялдаа холбоог нягтруулах, иргэдэд төрийн зүгээс үзүүлэх үйлчилгээг сайжруулах зорилгоор бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэхдээ мэдээлэл, харилцаа холбооны технологийн ололтыг ашиглах нь чухал ач холбогдолтой гэж үзэж энэ чиглэлээр төрөл бүрийн бодлого, хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлж байна. Заримаас дурдахад, Австри улс 2001 оноос “Digitales Österreich”, БНСУ 1997 оноос “E-Government”, “U-Korea”, ХБНГУ 2003

оноос “Deutschland-Online” хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж ирснийг дурдхад таатай байна²³.

Манай улсад мэдээллийн технологид тулгуурласан мэдээллийн төрөлжсөн сан байгуулах ажил анх статистикийн албанд нийгэм, эдийн засаг, аймаг, орон нутгийн мэдээллийн сангууд бүрдэж эхэлсэн гэж үзэх үндэстэй ч стратегийн төлөвлөлт, шуурхай удирдлага, мониторинг хийх, мэдээлэл хайх зэрэг олон зорилготой мэдээллийн боловсруулалт хийх чадавхитай мэдээллийн автоматжуулсан сан бүрдээгүй байна гэсэн үг юм.

Цагдаагийн байгууллага болон төрийн захиргааны байгууллагууд нь хууль сахиулах үйл ажилагаанд ашиглах мэдээллээ хуримтлуулсан ч мэдээ мэдээлэлээ шуурхай солилцох нөхцөл бүрдүүлэхгүй байгаа явдал нь мэдээ, мэдээллийг өмчлөх, мониторинг, хяналт шинжилгээний гадна байлгах, мэдээллээр ноёрхох орчинг бий болгож байна.

Төрийн захиргааны бүх шатны байгууллага нь Цагдаагийн байгууллагын мэдээллийн сантай холбогдож мэдээллийн нэгдмэл сан бүрдүүлээгүйгээс мэдээлэл олж ашиглах, эрэл хайлтын ажил ихээхэн бэрхшээлтэй, анхдагч мэдээ зөрүүтэй байгаа нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хүндэл, бэрхшээл учруулж байна.

Тиймээс Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд шаардагдах мэдээлэл боловсруулах компьютерийн системүүдийг үйл ажиллагааны чиглэлээр нь дагнасан мэдээллийн төвүүдийг бий болгон зохион байгуулж, тэдгээрийн үйл ажиллагааны чиг үүрэг, харилцан ажиллах зарчмыг тодотгож, хоорондоо мэдээлэл солилцох техникийн нөхцөлүүдийг хангаж ажилвал бид зорилгодоо хүрнэ.

Иймээс Цагдаагийн байгууллагын мэдээллийн сангийн программ хангамж нь дараахь нөхцөлүүдийг хангасан байх ёстой. Үүнд:

- Орчны өөрчлөлтөд зохицон хөгжих бололцоотой байх
- Олон хэрэглэгчтэй харицах бололцоотой байх
- Олон төрлийн хуримтлагдсан мэдээллийн сантай шууд харилцдаг байх
- Гадаад орчинтой холбогдох бололцоотой байх
- Хэрэглэгчдийг мэдээллийн баазад хандах эрхээр нь ангилах боломжтой байх
- Эрх өгөгдсөн тохиолдолд системийн дурын дэд системээс мэдээллийн баазад хандах бололцоотой байх
- Мэдээллийг нууцлах боломжтой байх зэрэг болно.

Цагдаагийн байгууллагын мэдээллийн сангийн мэдээллийн сүлжээн нь дор дурьдсан шаардлага хангасан байх ёстой.

- Мэдээллийн технологийн хөгжлийн чиг хандлагад нийлэмжтэй бүтэцтэй, нээлттэй систем байх
- Цахилгаан холбооны болон компьютерийн техникийн олон улсын стандартыг хангасан байх
- Системийн найдвартай ажиллагаа, мэдээллийн нууцлалтын шаардлагыг хангасан байх
- Цагдаагийн байгууллагын болон бусад байгууллагуудын мэдээллийн сүлжээний тоног төхөөрөмж, программ хангамж нь хоорондоо уялдан зохицох ёстой бөгөөд энэ нь нөхцөл сүлжээний архитектороор хангагдсан байх

²³Засгийн газрын 2008 оны 78 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

- Сүлжээний цөм нь электрон шуудангийн толгой компьютер ба бусад төхөөрөмжүүд байх болно. Энэ нь мэдээллийн нууцлал, мэдээллийн сангийн удирдлага, түүнийг баяжуулах ажлыг хариуцах гэх мэт.

Дүгнэлт

Монгол Улсын хэмжээнд ашиглаж байгаа улсын бүртгэлийн, хуулийн этгээлийн, татварийн, гаалийн, нийгмийн даатгалын, хөрөнгийн биржийн, төрийн өмчийн бүртгэлийн сан, хууль тогтоомжийн лавлагааны, байгаль орчны гэх мэт салбарын чиглэлтэй мэдээллийн төрөлжсөн сангуудын уялдаа холбоог сайжруулж, Цагдаагийн байгууллага болон төрийн захиргааны байгууллагууд нь хууль сахиулах үйл ажилагаанд ашиглах мэдээллээ шуурхай солилцох нөхцлийг бүрдүүлж мэдээ, мэдээлэлд мониторинг, хяналт шинжилгээний хийх, мэдээллийг хүртээмжтэй шуурхай хүргэх орчинг бий болгох, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд шаардагдах мэдээлэл боловсруулах компьютерийн системүүдийг үйл ажиллагааны чиглэлээр нь дагнасан мэдээллийн төвүүдийг бий болгон зохион байгуулж, тэдгээрийн үйл ажиллагааны чиг үүрэг, харилцан ажиллах зарчмыг тодотгож, хоорондоо мэдээлэл солилцох техникийн нөхцөлүүдийг шийдвэрлэж, мэдээллийн сангаас боловсруулалт хийх чадавхитай мэдээллийн автоматжуулсан сан бүрдүүлэх шаардлагатай тулгараад байна.

Санал

- Цагдаагийн байгууллагын өргөн хэмжээний мэдээллийн санг бий болгох бодлого, стратеги боловсруулж хэрэгжүүлэх
- Нэгдсэн бүртгэл мэдээллийн бааз суурь дээр тулгуурласан мэдээллийн сан бий болгож, төрийн болон төрийн бус байгууллагуудын ашиглаж байгаа мэдээллийн санг Цагдаагийн байгууллагын мэдээллийн сантай холбож, сүлжээний тоног төхөөрөмж, программ хангамж нь хоорондоо уялдаа холбоотой ажиллах нөхцлийг бүрдүүлэх
- Хууль сахиулах байгууллагуудын салингид мэдээллийн сангуудад байршуулсан мэдээ мэдээллийг хоорондоо хөрвөх боломжтой болгож харилцан холбогдоогүй байгаа нь мэдээллийн сангуудыг гэмт хэргийг түргэн шуурай илрүүлэхэд өргөнөөр ашиглах
- Мэдээллийн сангийн нөхцөл сүлжээний техникийн нөхцлийг сайжруулж, сүлжээний аюулгүй байдлыг хангах бусад улс орнуудын тэргүүн туршлага, арга барилыг нэвтрүүлж ашиглах
- Санд байршуулсан мэдээллийг цагдаагийн алба хаагч бүр ашиглах боломжтой болгох зэрэг болно.

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТАЛААР ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГААС НИЙТИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ НЬ



Д.Булган

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн
цагдаагийн эрх зүйн тэнхимийн багш,
хууль зүйн магистр, цагдаагийн ахмад

Удиртгал. Манай улс социалист төвлөрсөн тогтолцооноос зах зээлийн харилцаанд шилжиж, сүүлийн жилүүдэд бий болсон амьдралын бэрхшээл, ажилгүйдэл, ядуурал хүмүүсийн амьдралд сөргөөр нөлөөлж, гэмт хэргийн гаралт нэмэгдэж, хүмүүсийн амьдрах нөхцөл, аюулгүй байдал, иргэдийн амгалан тайван байдалд, тухайлбал, замын хөдөлгөөний аюулгүй байдал, галын аюулгүй байдал, гэр бүлийн хүчирхийлэл, архидалт, хөдөлмөрийн аюулгүй байдал, байгалийн гамшиг, хүн малын гоц халдварт өвчин, тахал тархах, техникийн аюулгүй ажиллагааны сөрөг үр дагавар нийгэмд бий болж, өсөх хандлагатай байна. Жишээ татан үзвэл замын хөдөлгөөний аюулгүй байдал нилээд анхаарал татаж байгаа бөгөөд нөхцөл байдал хүндэрсэн гэж хэлэхэд хэлсдэхгүй болов уу.

Монгол Улсад замын хөдөлгөөний аюулгүй байдлын асуудал нү хамгийн их сэтгэл зовоосон асуудал болж байгаа сүүлийн жилүүдэд тээврийн хэрэгслийн тоо нэмэгдэхийн хэрээр зам тээврийн осол, хэргийн тоо өсч, хүний амь нас, эрүүл мэнд, эд баялагт учирах хохирол өссөөр байгааг Цагдаагийн ерөнхий газраас гаргасан 2015 оны зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлтээс харж болно. Тиймээс замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад анхаарал хандуулах нь өнөөгийн нийгэмд чухал болоод байна.

Эрх зүйн шинэчлэлийн хүрээнд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тухай хууль, хууль тогтоомж шинэчлэгдэн батлагдаж, дагаж мөрдөж буй өнөө үед хууль сахиулах байгууллага төдийгүй бусад захиргааны байгууллага, төрийн бус, аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн оролцоог сайжруулах, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, практикт тулгарч буй бэрхшээлийг шийдвэрлэх арга замын тодорхойлох шаардлага зүй ёсоор тулгарч байна.

Нэг. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын өнөөгийн нөхцөл байдал. Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, иргэд аюулгүй, амгалан амьдрах нөхцлийг хангах тодорхой ажлууд тусгагдсан бөгөөд түүнийг ажил хэрэг болгох нь зүйтэй.

Монгол Улсад иргэд айх аюулгүй, амар тайван амьдрах орчинг бүрдүүлэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлыг оновчтой, зөв арга хэлбэрээр зохион байгуулж, олон талт шинэлэг ажил, арга хэмжээ, санаачлагыг хэрэгжүүлэх бодит үр дүнг бий болгох нь чухал ач холбогдолтой.

Монгол Улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний стратегид замын хөдөлгөөний аюулгүй байдлын өнөөгийн нөхцлийг дурьдахдаа дэлхий дахинд зам тээврийн ослын улмаас жилд 1.2 сая гаруй хүн амь насаа алдаж, 50 сая гаруй хүн бэртэж, гэмтэн хөгжлийн бэрхшээлтэй болж байгаагийн зэрэгцээ 5-29 насны хүүхэд, залуучуудын үхлийн үндсэн шалтгаан нь зам тээврийн осол болж байна. Зам тээврийн осол нь зүрхний шигдээс, сэтгэлийн дарамтын дараа хүн амын нас баралтын гурав дахь гол шалтгаан болох төлөвтэй байгаа бөгөөд зам тээврийн ослоор нас барагсдын 90 гаруй хувь нь буурай болон хөгжиж байгаа улс оронд

ногдож, жилд нийт 65 тэрбум ам. долларын хохирол учирч байгааг НҮБ-аас онцлон тэмдэглэж, 2010 онд Ерөнхий Ассамблейн хуралдаанаас 2011-2020 оныг “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын жилүүд” болгон зарлаж 64/255 дугаар тогтоолыг гаргаж, зам тээврийн ослыг эрс багасгаж, нас баралтыг 50 хувиар бууруулах зорилтыг дэвшүүлсэн. Харин манай улсын хувьд зам тээврийн осол, зөрчлийн тоо жилээс жилд нэмэгдэж, түүнээс шалтгаалах нас баралт өсөх хандлагатай байна²⁴.

Ийнхүү 2013 онд ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Цагдаагийн эрх зүйн тэнхимээс зохион байгуулсан “Онцгой нөхцөл байдлын үеийн төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа”²⁵ сэдэвт эрдэм шинжилгээний хуралд онцгой нөхцөл байдлын үед хууль сахиулах байгууллагуудын хоорондын хамтын ажиллагааг сайжруулах, чиг үүргийг тодорхой болгох, тулгамдаж байгаа асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх арга замыг эрэлхийлж хууль сахиулах байгууллагуудын алба хаагч, судлаач, эрдэмтэд, багш нар оролцож энэхүү онол, практикийн хурал зохион байгуулагдав.

2014 онд “Нийслэл хотын аюулгүй байдлыг хангахад нийслэлийн төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа” сэдэвт зөвлөгөөн болсон ба энэхүү зөвлөгөөнд иргэдийн аюулгүй байдлыг хангах, амар тайван байдлын төлөө төрийн байгууллагуудын зүгээс өөр хоорондын хамтын үйл ажиллагааг нэмэгдүүлэх, өргөжүүлэх, хамтран ажиллах талаар хэлэлцжээ²⁶.

Мөн 2015 онд “Хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаа” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурал Хөвсгөл аймагт зохион байгуулагдсан бөгөөд энэхүү эрдэм шинжилгээний хурлаар хууль сахиулах байгууллагын практик үйл ажиллагаа, хамтын ажиллагаа, тулгамдаж буй асуудлыг хөндөж, шийдвэрлэх арга замын талаар судлаачдын байр суурь, саналыг сонсож тэдгээрт үндэслэн зөвлөмж гаргах, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын мэдээ мэдээллийг харилцан сонсох, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх зорилготой хийгдсэн.

Ийнхүү аюулгүй байдлыг хангах ажиллагаа болон хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаа нь өнөөгийн тулгамдаж буй асуудал, сэдэв болж байгаа нь тэдгээрийн эрэлт хэрэгцээгээр тодорхойлогдож байгаа нь харагдана. Гэхдээ эдгээр эрдэм шинжилгээний эдгээр хурлаар замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааны талаар хөндөгдөгдсөнгүй.

Тиймээс судлаач бид замын хөдөлгөөний аюулгүй байдлын өнөөгийн нөхцөл, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах албаны чиг үүрэг, замын цагдаагийн алба хаагчдын гүйцэтгэж буй үүрэг, үйл ажиллагааг судлаж, нөхцөл байдлыг тодорхойлохыг хичээлээ.

Манай улсад тээврийн хэрэгслийн тоо жилээс жилд эрчимтэй өсч байгааг 86 жилийн тоон үзүүлэлтээс харж болно. 1929 онд 20 автомашин хөдөлгөөнд оролцож байсан бол 85 жилийн дараа буюу 2014 оны байдлаар 674869 машин болон өсчээ²⁷.

1997 онд 114823 тээврийн хэрэгсэл тоологдож байсан бол 2011 онд 349465 болж сүүлийн 15 жилд 2 дахин өссөн үзүүлэлт гарч байна. Тоон үзүүлэлтээс харахад Монгол Улсад тээврийн хэрэгслийн өсөлт жилд дунджаар 7-10 хувиар, харин 2009

²⁴ Засгийн газрын 2012 оны 146 дугаар тогтоол. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний стратеги (2012-2020 он)

²⁵ “Онцгой нөхцөл байдлын үеийн төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа” онол, практикийн бага хурлын эмхэтгэл. –УБ, 2013.,

²⁶ “Нийслэл хотын аюулгүй байдлыг хангахад нийслэлийн төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа” сэдэвт зөвлөгөөний илтгэлийн эмхэтгэл. –УБ, 2014.

²⁷ Монгол Улс дахь зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлтийн эмхэтгэл. Цагдаагийн Ерөнхий газар. –УБ, 2015 он, 6 дахь тал.

онд 23,1 хувиар, 2010 онд 7,1 хувиар, 2011 онд 22,4 хувиар өссөн буюу импортоор орж байгаа автомашины тоо ихээхэн өсч байгаа нь харагдаж байна.

Мөн зам тээврийн осол, гэмт хэрэг сүүлийн үед нэмэгдэж байгааг тоон үзүүлэлтээс харж болно. 1972 онд зам тээврийн 33222 зам тээврийн гэмт хэргийн улмаас 41747 хүн зам тээврийн осолд өртөж 10706 хүн амь насаа алдаж, 31041 хүн гэмтэж бэртсэн тоон үзүүлэлт гарч байна. Харин зам тээврийн осол 1997 онд улсын хэмжээнд 3259 бүртгэгдсэн байхад 15 жилийн дараа буюу 2011 онд 19440 болж 5,3 дахин өсчээ²⁸.

2014 оны байдлаар зам тээврийн ослын холбогдолтой дуудлага 107727-г хүлээн авсан ба 31585 зам тээврийн осол бүртгэн шалгасан. 2014 оны абсолют өсөлт бууралтыг тооцож үзэхэд зам тээврийн ослын холбогдолтой дуудлага 17456 пунктээр, бүртгэгдсэн зам тээврийн осол 13188 пунктээр тус тус өссөн үзүүлэлтэй байна.

Одоогийн байдлаар зам тээврийн осол гарсан шалтгаан нөхцлийг дараахь байдлаар ангилан авч үздэг.

- Жолоочийн буруутай үйлдлээс
- Явган зорчигчийн буруутай үйлдлээс
- Замын нөхцлөөс
- Техникийн гэмтлээс гарсан зам тээврийн осол гэж ангилах бөгөөд эдгээр нь замын хөдөлгөөний аюулгүй байдалд шууд нөлөөлдөг байна.

Зам тээврийн шалтгаан нөхцөл нь нийт осолд эзлэх хувийг тодорхойлбол жолоочийн буруугаас 2013 онд 17848 буюу 97 хувь, 2014 онд 30110 буюу 95.3, замын нөхцөлөөс 2013 онд 44 буюу 0.2 хувь, 2013 онд 31 буюу 0.1 хувь, явган зорчигчийн буруугаас 475 буюу 2.6 хувь, 2014 онд 1444 буюу 4.6 хувиар өссөн үзүүлэлт гарчээ.

Жолоочийн буруутай үйлдэл нь хажуу хоорондын зай тохируулаагүй, анхаарал болгоомжгүйгээс, улзвар гарц нэвтрэх журам зөрчсөн, хурд хэтрүүлсэн, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоосон зэрэг үйлдлүүд зонхилох байртай байна.

Явган зорчигчийн буруутай үйлдлээс гарсан зам тээврийн осол нь дотроо гарцын шугам, гарамгүй газраар зам хөндлөн гарах, ойртож яваа тээврийн хэрэгслийн урдуур хөндлөн гүйх, замын зорчих хэсгийн захаар дагаж явах, согтууруулах ундааны зүйл хэрэглэж биеэ авч явах чадваргүй үедээ замын зорих хэсэг дээгүүр явах, замын хөдөлгөөнд оролцохдоо анхаарал, болгоомжгүй оролцох зэргээс авто машинд дайрагдаж, мөргөгдөж зам тээврийн осолд өртөх нь их байна.

Ийнхүү статистик судлагаанаас харахад зам тээврийн осолд өртөх, гэмтэх явдал их байгааг албан ёсны статистикийн мэдээ, хүн амын дунд хийсэн судалгаа харуулж байна. Тухайлбал 15-64 насны иргэдийн 4 хувь нь сүүлийн 12 сарын дотор зам тээврийн осолд өртаж, зам тээврийн осол, гэмтэл үүсэхэд нөлөөлж байгаа гол хүчин зүйл нь хурд хэтрүүлэх, согтууруулах ундаа хэрэглэх зөрчил, хот төлөвлөлт өнөөгийн шаардлага хангахгүй, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг зохицуулж байгаа хууль, дүрэм, журам, стандартын биелэлт хангалтгүй, тээврийн хэрэгслийн парк хэт хуучирсан, хөдөлгөөнд оролцогчдын соёл, боловсрол дутмаг, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах байгууллагуудын ажлын уялдаа хангалтгүй зэрэг олон шалтгааныг дурьджээ²⁹.

Хоёр. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаарх эрх зүйн зохицуулалтын шинэчлэлийн зарим асуудал. Монгол Улсад хууль, хууль

²⁸ Монгол Улс дахь зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлтийн эмхэтгэл. Цагдаагийн Ерөнхий газар. –УБ, 2012 он, 6-9 дахь тал.

²⁹ Засгийн газрын 2012 оны 146 дугаар тогтоол. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний стратеги (2012-2020 он)

тогтоомж сүүлийн 25 гаруй жилийн хугацаанд шинэчлэгдэж, хууль сахиулах байгууллагын үүргээ биелүүлэх ажиллагааг зөв хэрэгжүүлэх, эрх зүйн зохицуулалтыг оновчтой тайлбарлаж, түүнийг шинжлэн судалж, үйл ажиллагаагаа шинэчлэх нь чухал ач холбогдолтой юм.

Монгол Улсын нийгэм улс төр, хүн амын аюулгүй байдал, иргэдийн амьдралын тогтвортой нөхцлийг хангах, олон нийтийн аюулгүй байдлыг хамгаалах, аж төрөх, гэмт явдлаас урьдчилан сэргийлэх, хэргийг бууруулах, зохистой арга хэмжээ авах нь өнөөгийн тулгамдсан асуудлын нэг юм.

УИХ-аас батлагдсан 1998 онд эрх зүйн шинэчлэлийн стратеги бодлогын баримт бичиг батлагдаад нэлээд олон жил өнгөрч, энэ хугацаанд манай улс нийгмийн хөгжлөөсөө хамаараад эрх зүйн зарим шинэтгэл хийгдсэн ч бүрэн хангалттай биш бөгөөд энэхүү баримт бичгийг шинэчлэх шаардлагатайг нийгэм бэлээхэн харуулж байна.

Монгол Улсын хууль зүйн нэгдсэн бодлого нь ямар байх, ялангуяа хууль сахиулах салбарт шинэтгэл явагдаж байгаа энэ үед шинэтгэлийг “аюулгүй байдал”-ын хүрээнд хууль тогтоомжийн ямар тогтолцоо, систем, механизмтай байх ёстой вэ гэдэг нь чухал болж байна.

Хууль зүйн салбарын шинэтгэлийн хүрээнд цагдаагийн албаны тухай, тахарын албаны тухай, гэрч хохирогчийг хамгаалах тухай, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, галт зэвсгийн тухай хууль батлагдаж, хууль сахиулах үйл ажиллагааны тухай, гэмт хэргийн тухай, архидан согтуурахтай тэмцэх тухай, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн төсөл хэрэгжин, ажиллаж байна.

2015 онд “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тухай хууль” шинэчлэн батлагдсан нь замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, олон улсын жишигт нийцүүлэх, замын хөдөлгөөний зохион байгуулалт, хөдөлгөөний аюулгүй байдлыг хагахад чиглэсэн төрийн бодлого, зохицуулалтыг шинэ түвшинд хүргэх, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, осол, хэрэг, зөрчлийн тоог бууруулах, иргэдийн амь нас, эрүүл мэнд, эрх ашгийг хамгаалахад чиглэсэн үзэл баримтлалын томоохон өөрчлөлт, шинэчлэл, зохицуулалтуудыг тусгажээ.

Энэхүү хуулийн зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэрт замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах эрх зүйн үндсийг тодорхойлж, холбогдох харилцааг зохицуулахаар заасан.

Шинэчилсэн хуулиар дээр дурьдсан замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, шийдвэрлэх, хууль эрх зүйн орчинг сайжруулах зорилгоор хуулийн агуулгыг өргөжүүлж, 7 бүлэг бүхий системтэйгээр, иж бүрэн авч үзэж, зам, орчин, хүн гэсэн асуудлыг бүхэлд нь тусгаж, зохицуулсан нь харагдана.

Мөн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад төрийн байгууллагуудын эрх, үүргийг нарийвчлан зааж, хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах талаарх зохицуулалтыг тусгажээ.

Замын хөдөлгөөнд оролцогч бүрийн эрх, үүргийг тодорхой болгосон нь хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлж буй хүчин зүйлсийг багасгахад чиглэгдсэн бөгөөд оролцогч гэдэгт жолооч, тээврийн хэрэгслээр зорчигч, явган зорчигчийг ойлгох учир иргэн бүрийн үүрэг хариуцлага, эрхийг тодорхойлсон.

Механикжсан тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх асуудал нь хүний өдөр тутмын хэрэгцээнд чиглэхээс гадна мэргэжлийн чиглэлээр ажиллах боломжийг бүрдүүлж байгаа юм. Жолооч бэлтгэх тогтолцоог мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу Хөдөлмөрийн яам мэргэжлийн сургалтыг удирдлага зохицуулалтаар хангаж, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэхээр зохицуулсан болно.

Иргэний жолооны үнэмлэх авах, хэрэглэх хугацаа, олон улсын үнэмлэхийг эзэмших, эрх нь цуцлагдах зэрэг, цуцлагдсан эрхээ шууд сэргээх зэрэг олон зохицуулалтыг тусгаж өгсөн нь нилээдгүй шинэлэг гэж хэлж болно.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад техникийн ерөнхий шаардлага хангах нь нэн тэргүүний чухал ач холбогдолтой. Зам, замын байгууламжийг төлөвлөх, барих, өргөтгөх, засварлах, арчлан хамгаалах, замын хөдөлгөөнийг зохион байгуулах, тээврийн хэрэгсэл, түүний хийцийн бүрэлдэхүүн хэсэг, нэмэлт тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг үйлдвэрлэх, угсрах, импортлох, тээврийн хэрэгслийг ашиглах, Тээврийн хэрэгсэлд техникийн үйлчилгээ, засвар хийх, тээврийн хэрэгсэлд тусгай дуут болон гэрлэн дохио тавьж замын хөдөлгөөнд оролцох шаардлагууд нь стандартаар баталгаажиж, стандартын хэрэгжилтийг, хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагууд хянахаар зохицуулсан.

Мөн нилээдгүй шинэлэг зүйлийг тусгасан зохицуулалтууд бол захиргааны хариуцлага хүлээлгэхээр заасан бүлэг зургаадугаар бүлэг бөгөөд хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагын асуудал юм.

1992 онд батлагдсан “захиргааны хариуцлагын тухай хууль”-иар торгох шийтгэлийн ерөнхий хэмжээ бага байсантай холбоотой хариуцлагын үр дүн төдийлөн харагдахгүй байсан ба шинэчилсэн хуулиар зөрчлийн хэв шинжийн хүрээг өргөтгөн авч үзэж, торгуулийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний өөрчлөлттэй уялдуулан жишиг байдлаар зохицуулах уян хатан зохицуулалтыг тусгажээ.

Ийнхүү замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажиллагааг сайжруулахаар хуулийг шинэчлэн батласан бөгөөд замын хөдөлгөөний дүрмийг шинэчлэхээр ажиллаж байна.

Гурав. Цагдаагийн байгууллагаас замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажиллагаа. Цагдаагийн байгууллагаас аюулгүй байдлыг хангахад нийтийн захиргааны болон хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллах талаар хууль тогтоомж, зүйн зохицуулалтанд зааж өгсөн.

Цагдаагийн байгууллагын замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаар “Цагдаагийн байгууллагын тухай хууль”³⁰-ийн 18 дугаар зүйлд “хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах” гэсэн заалт байсан бөгөөд “цагдаагийн албаны тухай хууль”-д энэ талаар нарийвчлан зааж өгөөгүй.

1993 оны “Цагдаагийн байгууллагын хууль”-д зааснаар цагдаагийн байгууллага нь чиг үүргийн хувьд цагдаагийн байгууллагын гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагааныхаа онцлогтой уялдуулан гэмт хэрэг илрүүлэх, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, түүнчлэн хэв журмын, харуул хамгаалалтын, хүүхдийн зэрэг салбар албад, мэдээлэл, дүн шинжилгээ, жижүүрийн зэрэг ерөнхий удирдлагын чиг үүргийн албад, хүн хүч, санхүү, үйлчилгээ, аж ахуйн зэрэг хангах албад ажиллаж байв.

Харин “замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тухай хууль”-ийн 8 дугаар зүйлд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад цагдаагийн байгууллага дараах үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

1. замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтэд хяналт тавих;
2. замын хөдөлгөөнд оролцогчийн хэвийн, аюулгүй зорчих нөхцөлийг хангах зорилгоор замын хөдөлгөөнийг зохицуулна.

³⁰ Цагдаагийн албаны тухай хууль 2013 оны 7 сарын 5-нд батлагдсан бөгөөд 2014 оны 1 дүгээр сарын 1-нээс цагдаагийн байгууллагын тухай хууль хүчингүй болсон.

“Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль”-д “замын хөдөлгөөн” гэдэг нь “нийтийн хэрэгцээний зам дээр явганаар болон тээврийн хэрэгслээр хүн, ачаа шилжих үйл ажиллагааг;”-г хэлнэ³¹.

“Замын хөдөлгөөний аюулгүй байдал” гэж замын хөдөлгөөнд оролцогчийг зам тээврийн осол, түүнээс үүдэн гарах хор уршгаас хамгаалсан байдлыг...”, “замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах” гэж зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, ослоос үүдэн гарах хохирлыг багасгахад чиглэсэн үйл ажиллагааг хэлнэ гэжээ.

Эдгээр өөр хоорондоо харилцан хамаарал бүхий хүчин зүйлсийн аль нэгэнд гажилт үүсэхэд зам тээврийн осол, хэрэг үүсэх нөхцөл бүрддэг.

“Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах” гэдэг нь зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх, ослоос учирч болох хохирлыг багасгахад чиглэгдсэн ажиллагаа гэж ойлгож болно.

Судлаач Р.Мөнхбаяр 2013 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тулгамдсан асуудлууд” сэдэвт хэлэлцүүлэгт тавьсан илтгэлдээ “Замын хөдөлгөөний аюулгүй байдал нь “Хүн-Тээврийн хэрэгсэл-Зам-Орчин” гэсэн харилцан уялдаа бүхий цогц асуудал” гэж тодорхойлоод зам тээврийн осол гарсан шалтгаан нөхцөлийг судалж авч үзээд “замын хөдөлгөөний аюулгүй байдал” гэдэгт “хүн -тээврийн хэрэгсэл-зам-хүрээлэн байгаа орчин” гэсэн өөр хоорондоо харилцан уялдаа холбоо шүтэлцээ бүхий элементүүдийн харилцан хамаарал гэж тодорхойлжээ.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах алба нь замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах салбарт зам тээврийн осол, гэмт хэрэг, захиргааны зөрчлийг хянан шалгах, хянах, зөвшөөрөх чиг үүргийг хэрэгжүүлэгч төрийн байгууллага. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр гэмт хэрэг, осол, захиргааны зөрчлөөс урьдчилан сэргийлж, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон хууль стандарт, хуулийн дэд актын биелэлтэнд тавих улсын хяналтыг хэрэгжүүлэх үүрэг бүхий ЦЕГ-ын болон нутаг дэвсгэрийн нэгж байгууллага юм.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах алба нь Засгийн газрын бодлого, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах Үндэсний стратеги, цагдаагийн байгууллагаас дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх, ажлын хүрээнд байгууллага, алба хаагчийн ажил үйлчилгээг ард, иргэдэд хурдан шуурхай, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, ил тод нээлттэй байх зарчмыг удирдлага болгон замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн хүний амь нас, эрүүл мэндийг зам тээврийн осол, гэмт хэргээс хамгаалах, урьдчилан сэргийлэх, хууль дүрэм журам, стандартын хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах албаны үндсэн зорилт нь

- Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаархи хууль, эрх зүйн хэм хэмжээний акт, стандарт, техникийн горим журмыг Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, аж ахуйн нэгж, албан тушаалтан чанд сахин биелүүлэхэд хяналт тавих
- Хүний амь нас, эрүүл мэндэд хөрөнгө, хууль ёсны ашиг сонирхолыг хамгаалах зорилготой зам тээврийн гэмт хэрэг, осол, замын хөдөлгөөний дүрмийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг цаг алдалгүй, үр ашигтай хэрэгжүүлэх, учирч болзошгүй хор уршгийг зайлуулах, багасгах.

³¹ Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль.2015 он., 3 дугаар зүйлийн 1.5.
<http://www.legalinfo.mn/law/details/11224?lawid=11224>.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажиллагаа нь дараах чиглэлтэй байна.

1. Техник, замын хяналт, хөдөлгөөн зохион байгуулалт
2. Замын хөдөлгөөнд хяналт, зохицуулалт
3. Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, зөрчил, ослоос урьдчилан сэргийлэх
4. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг мөрдөн шалгах
5. Зам тээврийн осол, зөрчил хянан шийдвэрлэх ажиллагаа гэх мэтээр ангилж болно.

Монгол Улс “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх Үндэсний хөтөлбөр”-ийг Засгийн газрын тогтоолоор батлан тус бүр 5 жилийн хугацаагаар 2 удаа /2002-2007, 2007-2010/ онд хэрэгжүүлж ажлыг зохион байгуулсан бөгөөд эдгээр хөтөлбөрүүд нь ихэвчлэн Замын цагдаа, хөдөлгөөнд оролцогч нарт хандаж байсан гэж үзэж болохоор байна.

Мөн 2012 онд “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний стратеги, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Засгийн газрын 146 дугаар тогтоолоор баталсан.

Монгол Улсын Засгийн газраас “Цагдаагийн байгууллагын зарим ажил, үйлчилгээ, хангалтын жишиг норматив” тогтоох 2011 оны 05 сарын 11-ний өдрийн № 153 тогтоолоор цагдаагийн байгууллага, алба хаагчаас иргэдэд чанартай, жигд, хүртээмжтэй, шуурхай үйлчлэх, алба хаагчийн хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх, эдийн засгийн үр ашигтай нөхцөлийг бий болгохоор тогтоосон байна.

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны № 153 тогтоолд Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий алба хаагч 350 тээврийн хэрэгсэл тутамд нэгээс доошгүй байна гэж заасан боловч энэ нь практикт хэрэгжихгүй байна.

Дөрөв. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаар нийтийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах нь. “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль”-ийн 2 дугаар бүлэгт замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажиллагааны тулгамдаж буй асуудлын нэг төрийн байгууллагуудын үүргийг нарийвчлан тодорхойлж, тэдгээрийн уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулахаар эрх зүйн зохицуулалтын шинэчлэл чиглэгдэж байна.

Монгол Улсын Их Хурал хуульд заасан нийтлэг үүргээс гадна тухайн чиглэлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг жил бүрийн нэгдүгээр улиралд холбогдох байнгын хороогоор хэлэлцэж, санал дүгнэлт гаргах, холбогдох байгууллага, албан тушаалтанд үүрэг болгохоор хуулийн 5 дугаар зүйлийн 1.3-т заажээ.

Засгийн газар гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын хувьд, Ерөнхий сайдын дэргэд байгуулагдсан орон тооны ажлын алба бүхий Үндэсний зөвлөлөөрөө дамжуулан чиг үүргээ хэрэгжүүлэх боломжтой юм.

Үндэсний зөвлөл нь замын хөдөлгөөний аюулгүй байдлын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг нэгтгэх, дүн шинжилгээ хийх, чиг үүрэг өгөх, тайлан мэдээ гаргах үүргийг хүлээсэн бөгөөд хуульд зааснаар дараах эрх, үүргийг хэрэгжүүлэхээр заажээ.

1. замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний стратеги, хөтөлбөр, холбогдох дүрэм, журмын төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах;
2. замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн хамтын ажиллагааг уялдуулан зохион байгуулах;
3. замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, замын хөдөлгөөний зохион байгуулалтыг оновчтой болгоход чиглэсэн үйл ажиллагаанд шинжлэх

ухааны ололт дэвшил, дэвшилтэт техник, технологи, мэдээллийн сүлжээг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж байгаа эсэхэд хяналт тавих;

4. замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаар үүрэг, чиглэл өгөх, зөвлөмж гаргах, ажлын хэсэг байгуулах;
5. замын хөдөлгөөний аюулгүй байдлын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг нэгтгэх, дүн шинжилгээ хийх, чиглэл өгөх, тайлан мэдээ гаргах;
6. замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаарх мэдлэг олгох сургалтыг сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын үндсэн хөтөлбөрт тусгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;
7. замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон хууль тогтоомж, захиргааны шийдвэр, стандарт, зөвлөмжийн хэрэгжилтийг хянах, шаардлага тавих;
8. байгууллага, албан тушаалтнаас замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон мэдээлэл, судалгаа, тайлбар, тодорхойлолт, бусад баримт бичгийг үнэ төлбөргүйгээр гаргуулан авах, танилцах, мэргэжлийн дүгнэлт, магадлагаа гаргуулах;
9. иргэдэд замын хөдөлгөөнд аюулгүй оролцохыг сурталчлах, бүх төрлийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр санамж, зөвлөгөө үнэ төлбөргүй нийтлэх, нэвтрүүлэх, түгээхийг үүрэг болгох, хэрэгжилтэд хяналт тавих гэх мэт.

Цагдаагийн байгууллага нь нийтээр дагаж мөрдөх дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт тавих, замын хөдөлгөөнд оролцогчдын хэвийн, аюулгүй зорчих нөхцөлийг хангах зорилгоор замын хөдөлгөөнийг зохицуулах үүрэг гүйцэтгэж, орон нутгийн удирдлагатай ажлаа уялдуулан ажиллана.

Иргэдийн амь нас, эрүүл мэндэд эд материалын хохирлын эсрэг замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын эрх, үүргийг тодорхойлж, орон нутагт замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах урт, богино хугацааны хөтөлбөр хэрэгжих, санхүүжилтийг шийдвэрлэх, холбогдох сургалт сурталчилгааны ажлыг эрхлэхээр заасан.

Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын ажил эмнэлгийн тусламж үйлчилгээг яаралтай, чанартай үзүүлэхээс гадна урьдчилан сэргийлэх, сургалт сурталчилгааны хөтөлбөр хэрэгжүүлэхэд мөн ажлаа чиглүүлэх нь зүйтэй гэж үзсэн. Зам тээврийн осолд өртсөн хүнд эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх эмнэлэг, анхны тусламжийн цэг, харьяалагдах нутаг дэвсгэрийг тодорхойлох, ажиллах нөхцөл боломжоор хангахыг тухайн байгууллагын үүрэг гэж үзсэн.

Эцэст нь дүгнэн хэлэхэд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажиллагааг практикт үр нөлөөг дээшлүүлэх гол хүчин зүйл нь хууль сахиулах байгууллага болон нийтийн захиргааны бусад байгууллагын хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах ба ерөнхий сайдын дэргэдэх Үндэсний Зөвлөлийн үйл ажиллагаа нь чухал үүрэгтэй оролцоно.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад замын хөдөлгөөнд оролцогч буюу явган зорчигч, жолооч нарын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, замын хөдөлгөөний соёлыг төлөвшүүлэх нь анхаарал хандуулах асуудлын нэг бөгөөд энэ тал дээр төрийн байгууллагуудын үүрэг, оролцоог нэмэгдүүлэх нь хэрэгтэй байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад цагдаагийн байгууллагын үүрэг оролцоо чухал бөгөөд тэдгээрийн үйл ажиллагааг сайжруулахад цагдаагийн алба хаагчийн хөдөлмөрлөх нөхцлийг дээшлүүлэх, ажлын зохион байгуулалтыг боловсронгуй болгох, техник тенологийн дэвшлийг ашиглаж, хөдөлмөрийг хөнгөвчлөх нь зүйтэй юм.

ГАЛЫН БЭЛТГЭЛ ХИЧЭЭЛИЙН ДАДЛАГА ХИЙХ ОРЧИН ҮЕИЙН ЭЛЕКТРОН ТИР АШИГЛАХ АСУУДАЛ



Д.Мөнхжаргал

ХСИС-ийн ЦС-ийн Мөрдөх ажиллагааны онол,
тактикийн тэнхимийн багш, цагдаагийн ахмад

Дэлхийн улс гүрнүүдийн цэрэг, цагдаагийн албадууд мэргэжлийн алба хаагчдаа бэлдэх, сургаж дадлагжуулахад өнөөгийн хатуу эдийн засгийн үед стратегийн чухал ач холбогдол бүхий түүхий эд, хүн хүч, цаг хугацааг хэмнэх үүднээс галын бэлтгэл хичээлийг байлдааны галт зэвсэгээр галт сум болон бусад сум хэрэглэхгүйгээр бодит нөхцөл байдал бүхий орчинг хиймлээр яг таг дууриан дүрслэн хийж сургалт дадлаг хийх болсоноор багагүй хугацааг өнгөрчээ.

Улмаар дээрх дээрх электрон төхөөрөмж улам хөгжиж боловсрогуй болж 2D-ээс 3D, 3D-ээс 4D, 5D хүртэл зохион бүтээж өнөөгийн өндөр хөгжилтэй цэрэг, цагдаагийн үйл ажиллагаа хөгжсөн улсууд мэргэшсэн алба хаагчдаа өндөр ур чадвартайгаар олноор бэлдэж байна.

Тус сургуулийн Цагдаагийн сургуулийн Галт зэвсэг тусгай тактикийн тэнхимийн сургалтын хэрэглэгдэхүүн болох буудлагын шагайварын дасгал, дадлага хийх зориулалт бүхий компьютерийн электрон тиртэй болох зорилгоор сүүлийн жилүүдэд дэлхийн улс орнуудад өргөн хэрэглэж байгаа Герман улсын AGSHP систем, ОХУ-ын “Аркада интератив” систем, Хятад улсын “XI'AN LIBA” хувьцаат компани “FA-HD”-уудын буудлагын цахим төхөөрөмжүүдийгүнэ, чанар, өргөн хэрэглээ, хэрэглээний зардал хамгийн баг байхаар тус тус судалсныг хүлээн авч танилцан уу.


Үүнд: 1. Холбооны Бүгд Найрамдах Герман улсын /Бундэсвер/ үйлдвэрлэсэн AGSHP /Буудлагын цахим төхөөрөмж/

Холбооны Бүгд Найрамдах Герман улсын АГСХП систем нь 1998 онд бүтээсэн бөгөөд ХБНГУ-ын /Бундэсвер/ арми болон Цагдаагийн алба хаагчдыг буудлагын зэвсэглэлээр буудах дадлагыг хийхэд зориулан бүтээгдсэн юм.

АГСХП систем нь 2 төрөл байдагба эхнийх нь цагдаагийн алба хаагчдад зориулсан, дараах нь батлан хамгаалах салбарт өргөн хэрэглэгддэг. Зах зээл дээр лазерийн системтэй цогцолбор гэж танигдсан.

Анх тасгай хүчиний мэргэн буудагчдийг бэлтгэх зориулалтайгаар хийгдсэн бөгөөд нэгэн зэрэг дөрвөн цагдаагийн алба хаагчбуудлага үйлдэх зориулалттай бүтээгдсэн. Зардал мөнгө, цаг хугацааг маш их хэмнэн, нөгөө талаас хөдөлгөөнт байг буудахад төвөг учруулах нь бага байдаг. Ялангуяа Цагдаагийн байгууллагын алба хаагчид их хэрэглэдэг.

Холбооны улсаас гадна бусад олон улсад хэрэглэгддэг.



Энэхүү буудлагын системийн давуу тал нь бүх буудаж буй цагдаагийн алба хаагчийн зэвсэг нь байлдааны зэвсэг байдаг бөгөөд системтэй холбож газны хоолойгоор залгагдаж буудлагын тийрэлтийг байлдааны зэвсэглэлтэй ижил хэмжээний болгож чадсан байдаг бөгөөд гадаад дотоод балисстикийг бүх үйл явцыг яг жинхэнэ юм шиг тооцоолж оруулж өгсөн ба дуу чимээний эфигт мөн буудлагын алсын хараа бүгдийг нь тооцоолох яг бодит байдлыг дүрсэлэн галт зэвсэгтэй харьцах, ямарч хуурамч зүйл байхгүй, буудлагын барилтийн алдааг багш дэлгэцээр харж хянан буудсаны дараа дүрс бичлэгээр гарын чичэрхийлэл хөдөлгөөн зэргийг давтан харуулж буудагчын алдааг засдаг, хэдийгээр дотор талд буудаж байгаа боловч тактикийн дадлага сургалт хийхэд 3D бодитойгоор хийх боломжтой байна.


Видео дээр хийх боломжтой нэгэн зэрэг олон төрлийн гар зэвсэглэлээр багаар буудах боломжтой. Бүхий л дуу чимээг стерео гаралтаар бодитоор сонсогдоно. Бүх бууны техник өгөгдөхүүний дагуу буудлагын хэрэгслийн техник өгдөхүүний онцлог яг бодитоор мэдрүүлнэ.

Өнөө үед Косово, Афганистан гэх зэрэг хямралт газруудад цэргүүдийг бэлдэхэд ашиглаж байна. Дэлхий дээрх стандарт бүхий л буугаар хууль сахиулах бүх алба хаагчид болон спортын зориулалтаар ашиглаж болно. Хамгийн гол зорилго нь буудагчид бодит байдлыг бий болгох мөн сумны зардлыг маш их хэмнэн, буудлагын талбай руу явах зардал, цаг хугацаа, хөдөлмөр хэмнэнэ. Одоогоор 170 гаруйг Герман улсад хэрэглэж байна.

Ерөнхий бүтцийн зураглал /Ком иж бүрдэл систем/

Энэ төхөөрөмжийн эзлэх талбай нь 8 харьцах нь 10 метр квадрат өндөр нь 2.5 метр байна. Гол удирдлага нь процессор тусгалын самбар буудагч 2-н хооронд 2 м байх ёстой. Үүнд:

- Тольт дэлгэц
- Проектор
- Лазер мэдрэгч бүхий камер
- Тооцоолох төхөөрөмж
- Буудлагыг зохицуулах систем
- Хийн төхөөрөмж /компрессор/
- Стерео өсгөгч төхөөрөмж
- Хийн болон лазер төхөөрөмж бүхий уян кабель
- Сонсгол болон ярих хэрэгсэл
- Сургалтын галт зэвсэг /энэ нь байлдааны галт зэвсэг автомат АКМ, гар буу ПМ, Грантмөнт RPG-7, пулемёт - ПК/ гэх мэт.



АГСХП системд 380 гаруй төрлийн цагийн байдлийн бичлэг дээр, буудлагын дасгалыг бүх төрлийн байлдааны гар зэвсэглэлтэйгээр хослуулан ганцаарчилсан болон бүлгийн буудлагыг буудаж болдогоороо бусад буудлагын системээс илүү давуу талтай байдаг байна.

Тухайлбал: анхан шатны буудлагын дасгал болох 25 метрт нэг болон хоёр гараар оноотой байг 3 ба 5 сумаар буудах. Энэ анхан шатны буудлагын сургалтад багш буудагчийг зөв системтээгээр зааж сургах, галт зэвсэгтэй 100 хувь аюулгүй харьцах арга барилд бүрэн дүүрэн сургаж дадлагажуулахад ихээхэн ач холбогдолтой.

Дараа дараагийн цагийн байдал, өгөгдлийг хийхийн тулд, өмнөх дасглыг амжилттай сурцаж ур чадвар эзэмшсэн байх зэрэгээр илэрнэ.




Дээрх зураг дээр Холбооны Бүгд Найрамдах Герман улсын армийн явган цэргийн үндсэн зэвсэг болох Н&К үйлдвэрийн G36 автомат зэвсэгээр АГСХП системд холбож хэрэглэх кабель, 30 сумны болон дамран дайзны хамт байна.

Кабель нь үндсэн 4 хэсэгээс бүрдэх ба эдгээрт төв компьютерт холбогдох кабель, хийн төхөөрөмж /компрессор/-т холобогдох кабель, зэвсгийн төрөлд зохьцуулагч систем бүхий хайрцаг, зэвсэгт зохьцуулагч системийн хайрцагаасхолбогдох хийн хоолой зэрэгээс бүрдэнэ.

Мөн хямралт газар болон цэрэг, цагдаагийн хээрийн сургалтын баазад тусгайлан бэлдэж тонголсон чингэлэгт алба хаагчдыг бэлтгэл сургалтыг бүрэн хангах зориулалт бүхий зөөврийн байдлаар ашиглаж болно.

Доорх зурагт 2 чингэлэгт байрлуулсан АГСХП системд хэргэн байрлуулж ашиглаж байгааг харуулсан байна.



Гох дарахаас эхлээд дуусах хүртэл бүхий л мэдээлэл компьютерээр дамжин багшид хүрнэ. Магазин солих, буруу шагайх зэрэг ажиллагааг хянах, засан зааварлах боломжтой багшын байр бий түүнээс бүхийл зүйлийг удирдана.



Хэвтээ, суугаа, босоо, нуувчнаас буудаж болно.

2. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын XI'AN LIBA ХХКҮйлдвэрлэсэн
FA-HD Загварын буудлагын видео систем юм.

Энэ загвар FA-HD-г кино байдлаар харилцаж галт зэвсгээр сургалт, дадлагад ашиглах систем юм. Хамгийн том онцлог нь харилцан тэмцэх, байдлааны сумаар буудах дасгал хийх боломжтой. Энэ нь зорилгод хүрч болох, терроризмын эсрэг урьдчилан сэргийлэх сургалт, туршилтын ур чадвар, зураг авалтын үр дүнтэй арга болон Виртуал зураг авалт үзэгдлүүдийн болон буудлагын бай болох хувилбараар нь бүрэн 3D загварчлал ашигладаг.

Галт зэвсгийг сургалтын хэсэг нь проектор, мультимедиа компьютер, хяналтын машин, байрлал олох систем, унших систем, сургалтын програм хангамж, принтер, аудио тоног төхөөрөмж, дэлгэц зэрэгээс бүрдэнэ. Энэ систем нь Бүгд Найрамдах Хятад Ард Улсын дотоодын тэргүүлэх байр суурьтай байна. Олон улсын стандартын системтэй адил төстэй бүтээгдэхүүн болж, террористын эсрэг цэрэг, цагдаагийн сургалт хийх тоног төхөөрөмж болж байна.

Системийн үйл ажиллагааны шинж чанар:

Энэ нь хүмүүст зориулсан лазер, дуурайх буудлагын сургалтын болгон ашиглаж болох бөгөөд нэг хүний бодит галлах буудлагын сургалтын болгон ашиглаж болно. Үзэгдэх ба үл үзэгдэх, цаг, дадлагын түвшин нь өөр өөр суралцагчдад тааруулж болох ба янз бүрийн буудлагын хичээлийн дагуу буудлагын цаг гэх мэт үзүүлэлтүүдийг тохируулж болно.

Цаг тухайд нь автоматаар шалгах, шалгалтын үр дүн, оноо дэлгэцэн дээр гарч ирнэ. Буудлагын оноо, үнэлгээ нь автоматаар компьютер дээр хадгалагдах ба хэвлэж болно.

Техникийн мэдээлэл:

Ашиглах буу: Цэрэг, Цагдаагийн бүх төрлийн буу тохиромжтой

Сургалтын гишүүн: 1-3 хүн

Тохиромжтой буудлагын зай: 7м - 12м

Дэлгэцийн талбай: 3м x 4 м

Нарийвчлалын байдал: дэлгэцийн хэмжээ 0.1%

Тасралтгүй үйл ажиллагаа явуулах цаг: 8 цаг

Эрчим хүчний чадал: 1000W


Хүчдэл: 220W / 50Гц

Бай, танхимийн гэрэл: өдрийн

Температур: 0 Чанарын ~ 40 ° C

Чийглэг: 85

Манай улсын хувьд сум, галт хэрэглэл маш их хязгаарлагдмал учир энэ хүү буудлагын электрон систем нь тийм ч өргөн ашиглах боломжгүй бөгөөд өнөөгийн байдлаар дээрхийг шийдвэрлэхэд эдийн засгийн томоохон асуудалтай шууд тулгараад байна.



3. Оросын Холбооны Улсын Arcada компани үйлдвэрлэсэн.

Загвар А24-12 буудлагын видео систем юм.

Arcada компани нь 2003 оноос хойш мультимедиа интерактив буудлагын системд зориулсан тоног төхөөрөмж, программ хангамж үйлдвэрлэж эхэлсэн.

ARCADA® интерактив амьд гал систем нь ОХУ-ын Төв банк (Санкт-Петербург, ОХУ) сэргээн босголт, хөгжлийн банкны Уралын, аюулгүй байдлын үйлчилгээ (Екатеринбург, ОХУ) Дотоод яамны цэргийн нэгж Төв буудлагын клуб ROSTO (Москва, ОХУ), хотын буудлагын төв ROSTO (Санкт-Петербург, ОХУ), Холбооны улсын нэгдмэл аж ахуйн нэгж "Харилцаа холбооны - Аюулгүй байдал" Москва, (Москва, ОХУ) Тусгай үйл ажиллагаа отряд "Vityaz" -ийн, сургалт байгууламж (ОХУ), Үндсэн дотоод хэргийн удирдах сургалт байгууламж (Москва, ОХУ), Үндсэн дотоод хэргийн удирдах сургалт байгууламж Челябинск (Челябинск, ОХУ), Тусгай цагдаагийн хүч (Оренбург, ОХУ), төрийн бус боловсролын газар "Динамо" (ОХУ), төрийн бус боловсролын газар "мэргэн буудагч" (Санкт-Петербург, ОХУ), хувийн аюулгүй байдлын агентлаг (Уфа, ОХУ), хувийн аюулгүй байдлын агентлаг (ОХУ, Новосибирск хот), хувийн аюулгүй байдлын агентлаг (Ханты-Мансийск, ОХУ), аж ахуйн нэгжийн аюулгүй байдал Екатеринбург (ОХУ) нь төмөр замын захиргаа, Спортинг клуб (Казань, ОХУ), Цагдаагийн академийн (Дубай, Арабын Нэгдсэн Эмират Улс), Буудлагын клуб (Стамбул, Турк)-үүдүйл ажиллагаа явуулдаг байна.



Буудлагын системийн давуу тал:

- *Олон төрлийн цагийн байдал үүсгэнэ
- *Дууны эффекттэй
- *Нэгэн зэрэг 4 буудагч буудах боломжтой
- *Багаар ажиллах боломжтой
- *Бай солих, засварлах зардал байхгүй
- *Бага талбай эзэлнэ

Сургалтын үйл явцыг бүхэлд нь харж зураг авалт үр дүнгийн талаар мэдээллийг хянан үзэх замаар мэдрэгчтэй дэлгэц дээр,

эсвэл компьютерийн дэлгэцэн дээр хянадаг.

Интерактив буудлагын систем ARCADА® олон төрөл байдаг бөгөөд үүнээс
Загвар: - А24-12 -техникийн тодорхойлолтыг танилцуулж байна.

Дэлгэцийн зураг авалтын ерөнхий хэмжээ, мм-ийн: - 2418x1218x23

Дэлгэцийн хэмжээ, мм-ийн: - 2400x1200мм

Буудлагын дэлгэцийнматериал: - Duraluminium хайлшин, EN AW 2024, DIN
AlCuMg2, ISO AlCu4Mg1

Дэлгэцийн мэдрэмжийн хэмжээ, мм-ээс: - 4

Буудлагын дэлгэц жин: - 40кг

Буулагын хурд, минутанд буудалт: - 800

Хамгийн бага буудлагын зайн (шалан дээр прожектор), метр: - 5

Хамгийн бага буудлагын зайн (тааз дээр прожектор), метрийн: - 4

Буудлагын систем суулгахын тулд хамгийн бага зай, метрийн:- 2,6x5,5

Үйл ажиллагааны температур ° C: -+5 .. + 35

Үйл ажиллагааны чийгшил %: - 30.90

Хит илрүүлэх систем нэрлэсэн хүчдэл V: - 5

Хит илрүүлэх системийн эрчим хүчний хэрэглээ W:- 0.2

Буудлагын системийн хэвийн хүчдэл, V : - 220-240

Буудлагын системийн хангамжийн хүчдэлийн давтамж, Гц: - 50/60

Буудлагын системийн эрчим хүчний хэрэглээ: - 1,2 кВт-ын

Airsoft / airgun буудлагын хязгаар.

Ашиглахыг зөвшөөрсөн сумны төрөл:

Airgun зэвсэг.

Буудлагын эрчим хүч 3-7 Ж.

Анхны сум хурд 70-130 м/с.

Хар тугалга сум 4.5mm (.177) калибрын.

Airsoft зэвсэг.

Анхны сум хурд 70-140 м/с.

Хуванцар бөмбөг (диаметр нь - 6mm, жин - 0.12-0.25г).

Ашиглахыг хориглохсумны төрөл:

Ган, ган зэсээр хийсэн үрэл сум 4.5mm (.177) калибрын.

ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН АЖЛЫН ҮНЭЛГЭЭ БА ӨӨРИЙГӨӨ ХӨГЖҮҮЛЭХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА



Д.Идэрмөнх

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн, ЦЭЗТ-ийн
ахлах багш, цагдаагийн дэд хурандаа

Хүн төрөлхтөн XX зууны эхэн үеэс оюуны хөдөлмөрийг үнэлэх болсноор тухайн нийгмийн оюуны хөдөлмөр эрхлэгч хүмүүс манлайлах болов. Тэд цагаан цамц өмсөн, зангиа зүүж алба хашдаг байсан учир түүхэнд “цагаан цамцтан” (white collar) гэж нэрлэдэг байжээ. XXI зууныг манлайлагчид нь өндөр мэдлэг боловсролтой байгаад зогсохгүй сэтгэлийн тэнхээ, тэсвэр хатуужлаар шалгарсан “шаргал цамцтан” (алтан шаргал өнгөтэй зүйрлэн хэлж байна) байх болно” хэмээн үзэж байна.

Хүний мөн чанарыг илэрхийлдэг үндсэн 3 шинж бол бие махбодь, сэтгэл санаа, оюун ухаан бөгөөд эдгээрийг хооронд нь ялгаж салгаж болохгүй. Харин ч харилцан шүтэлцээнд нь нэгэн зэрэг тэтгэн хөгжүүлэх ёстой. Чухам үүнд л хүнийг


хөгжүүлэх боловсролын зорилго оршно. Орчин үеийн хүнд бүх талын боловсрол олгоход дээрхи шинжүүдээс гадна амьдралаа зөв авч явах, бусадтай харилцах чадварыг төлөвшүүлэн хөгжүүлэх зорилготой юм.

Дээрх шинжүүдийг хадгалсан хүнийг үнэт алмазтай зүйрлүүлэн “Даймонд Калла хүн” (Diamond collar) гэж нэрлэдэг байна. Ийм хүн нь эрдэм мэдлэгтэй, үнэнч шударга ёсыг эрхэмлэдэг, бусдыг хайрлан хүндэтгэдэг, асар их тэсвэр хатуужилтай, аливаа муу зүйлээс бие болоод сэтгэлээ хамгаалж чаддаг, ариун мөртэй, эрүүл чийрэг бие бялдартай нэгэн байх болно. Чухам ийм л хүмүүс тэмцэл өрсөлдөөний XXI зууныг манлайлан авч явж чадна. Одоо үед хүнийг хөгжүүлэх бүх талын боловсрол олгох сургалт нь оюуны чадвар, бие бялдар, сэтгэлийн тэнхээ, амьдралаа зөв авч явах чадвар, бусадтай харилцах чадвар гэсэн 5 үндсэн чиглэлээр өв тэгш хүнийг бэлтгэн гаргах зорилготой юм.

Эндээс байгууллагынхөгжлийн асуудал яригдах ба түүний цаана хүний хөгжил. Байгууллага бүр өөрийн гэсэн эрхэм зорилготой, түүндээ хүрэх зорилго, зорилтуудыг өмнөө тавин ажилладаг. Бусдаасаа ялгарч онцгойрох нь тухайн байгууллагын хэр зэрэг цаг үе, орчноо мэдэрч, гарч буй сөрөг хүчин зүйлүүдэд хэрхэн уян хатан, хөрвөх чадвартай хандаж байгаагаас шууд хамаарна. Тэгвэл ямар ч байгууллага энэхүү үйл явцын үр дүнг ашигтайгаар эргүүлэх нэг арга нь хүн хүчний асуудлаа зөвөөр удирдан хөгжүүлэх явдал байдаг.

Байгууллага нь орчны болон технологийн дэвшилтэт өөрчлөлтөд амархан зохицож, мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэхийн тулд алба хаагч, хувь хүнийг байнга сургаж хөгжүүлэх нь зүйтэй байдаг.

Үүний тулд хүнийг хөгжүүлэх дараах чиглэлүүд байдаг. Үүнд:



Зураг 1. Байгууллагын зүгээс хүнийг хөгжүүлэх үндсэн чиглэл

Хүн ажил мэргэжлээрээ хөгжин сурч боловсроход нэг талаас байгууллага нөгөө талаас хувь хүн өөрөө өөрийгөө дайчлан ажиллах нь үүнээс харагдаж байна.

Цагдаагийн байгууллага нь орчны болон технологийн өөрчлөлт, дэвшилд амархан зохицож өрсөлдөх чадвараа дээшлүүлэхийн тулд алба хаагчдаа байнга сургаж, хөгжүүлж байх шаардлага гарч байна. Мөн байгууллага өөрийн өөрчлөлт хөгжлийн бодлогоо хэрэгжүүлэхийн тулднийгэм, улс төр, эдийн засгийн, олон улсын хүчин зүйлээс хамааран иргэд олон нийтийн эрэлт хэрэгцээ шаардлагыг хангаж, тэдэнд хүрсэн сэтгэл ханамжтай төрийн үйлчилгээ үзүүлэхийн тулд маш их мэдрэмжтэй хандах явдал чухал шаардлага болоод байна.³²

³² Цэнд.Н, Шуурав. Я, Батхүлэг.Г, “ Менежмент”–УБ 2013, 297 дахь

Байгууллага дээр хүний нөөцийг хөгжүүлэх ажлыг дараах үе шатаар хийж болно.

- Байгууллагаас ажилтанд тавих шаардлагыг нарийвчлан тодорхойлох.
- Ажилтны ур чадварыг үнэлж дүгнэн, ур чадварыг нь ахиулах чиглэлийг тодорхойлох.
- Ажилтны ур чадварыг ахиулах ажлын түүний дотор сургалтын төлөвлөгөө /карьерын төлөвлөгөө/ боловсруулах
- Төлөвлөгөөний дагуу давтан, мэргэшүүлэх сургалтыг чанартай зохион байгуулах

Төрийн тусгай албаны хэрэгцээ, шаардлага, ажлын онцлогтой холбон албан хаагчдын ур чадвар болон мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэн, тухайн хүн цаашид өсөх найдвартай эсэхийг тодорхойлох явдал хүний нөөцийг хөгжүүлэх ажлыг зохион байгуулах урьдчилсан нөхцөл болно.

Байгууллагын зүгээс ажилтан бүр өөрт ногдсон үүрэг даалгавраа хэрхэн биелүүлж ямар үр дүнд хүрч байгаа нь түүний ур чадвар мэргэшлийн бэлтгэл, ажлын ачаалал ямар байгааг дүгнэх үйл явц юм³³.

Төрийн тусгай алба болох Цагдаагийн байгууллагад ажилтнуудыг тэдний шууд харъяалах дарга үр дүнгийн гэрээ байгуулан үнэлдэг бөгөөд учир нь тэд ажил үүрэг хуваарилж, гүйцэтгэлийг нь тогтмол хянаж байдгийн хувьд үнэлгээ өгөх хамгийн тохиромжтой байршилд байгаа хүмүүс юм.

Иймд төрийн тусгай алба хаагчийн үйл ажиллагаа мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журамд шууд харъяалах дарга үнэлэх, дүгнэх хэлбэрийг илүү тохиромжтой хэмээн сонгон авч түүнийг дараагийн шатны дарга хянан баталдаг байхаар тусгасан. Үнэлгээ нь байнга явагдаж байснаар:

- ✓ Ажилтан ажил үүргээ ямар түвшинд гүйцэтгэж байгаа талаар удирдлага ба ажилтнууд бодитой мэдээлэлтэй болох
- ✓ Сургах хөгжүүлэх хэрэгцээ шаардлага, боломжийг тодорхойлох хэрэгжүүлэх
- ✓ Цалин хөлс болон нэмэлт шагнал урамшуулал олгох, шийтгэл ногдуулах бодит үндэслэлийг тогтоох
- ✓ Гүйцэтгэлийг сайжруулах зэрэг арга хэмжээг авахад дөхөм болно.

Төрийн тусгай албан хаагчийн үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг хагас жил, жилээр дүгнэдэг.

Энэ нь үйл ажиллагааны зорилт, төлөвлөгөөний биелэлтийн явцыг байнга хянаж, шаардлагатай үед дэмжиж туслах, ажлын шаардлагад нийцүүлэн төлөвлөгөөг тодотгох боломж олгох бөгөөд жилийн эцэст ажилтны үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэн зөв үнэлж дүгнэхэд чухал үндэслэл болох юм.

Үнэлгээ нь дарга ажилтны хувьд аль алинд нь ашигтай байдаг. Үнэлгээ нь ажилтны давуу ба сул талыг илрүүлж, давуу талыг нь улам сайн ашиглах, сул талыг нь аль болох багасгах арга замыг тодорхойлж өгдгөөрөө ажилтны ажлын гүйцэтгэл, бүтээмж, үр дүнг сайжруулахын зэрэгцээ албан тушаал дэвших ахих боломжийг гаргадаг бөгөөд тэдний хөдөлмөрийг илүү үр өгөөжтэй болгоход тусална. Үнэлгээ нь санаа бодол, хүсэн хүлээж буй зүйлээ удирдлагадаа илэрхийлж ойлгуулах боломжийг ажилтанд олгодог.

Үнэлгээний дүнг үндэслэн авч хэрэгжүүлэх арга хэмжээ:

Үнэлгээний үр дүнг дараах зорилгод ашиглана: Үүнд

- Шагнаж урамшуулах


³³ Ц.Цэцэгмаа “Хүнийн нөөцийн менежмент” 1996 он, 173 дахь тал

- Гүйцэтгэлийг сайжруулах
- Хариу мэдээлэл авах
- Дэвшүүлэх
- Сургах
- Таарч тохирох ажилд шилжүүлэх
- Төрийн албанд эргэж орох эрхтэйгээр халах
- Хүний нөөцөө судлах
- Ажлын байрны төлөвлөгөө боловсруулах

Төрийн тусгай албан хаагчийн үйл ажиллагаа, мэргэшлийн түвшний үнэлгээг:

- Албан тушаал дэвшүүлэх
- Зохих шатны сургалтад хамруулах
- Зэрэг дэв олгох
- Цалин хөлсийг өөрчлөх
- Албан тушаал бууруулах тухай асуудлыг шийдвэрлэхэд ашиглана.

Үнэлгээ нь гүйцэтгэлийг сайжруулж идэвхийг өрнүүлэн, ажилдаа сэтгэл ханамжтай болгоход чиглэгдсэн хөшүүрэг болж өгдөг. Гэхдээ шагнал урамшууллын оновчтой тогтолцоо бүрдүүлж, түүнийг үнэлгээний үр дүнтэй холбож чадвал үнэхээр чухал хөшүүрэг болох нь дамжиггүй юм. Хүний нөөцийг хөгжүүлэх үйл ажиллагааг харуулбал:



Зураг 2. Байгууллага дахь хүний нөөцийн хөгжүүлэх үйл ажиллагаа

Цалин, урамшуулал Байгууллагын удирдлага ажилтан нэг бүрийн цалингийн хэмжээг ажлын гүйцэтгэлийн түвшинтэй нь уялдуулж ялгавартай байдлаар уян хатан тогтоох боломжтой байх нь чухал. Гэхдээ нэгэнт тогтоосон цалин хөлсийг өөрчлөхийн тулд бодитой үндэслэл шалтгаан зайлшгүй хэрэгтэй бөгөөд эс тэгвээс ажилтнууд дургүйцэж сэтгэл санаа нь тогтворгүй болж болзошгүй. Тийм үндэслэлийг үнэлгээний тогтолцоо бүрдүүлж өгдөг.

Цалин хөлс нь:

- үндсэн
- хувьсах
- нэмэгдэл хөлс
- нэмэгдэл гэсэн хэсгүүдээс бүрдэнэ.

Үндсэн цалин гэдэг нь тухайн ажилтны албан тушаал, хариуцлагын түвшин, ур чадвар, туршлагаас хамааран өгч буй хөлс юм. Үндсэн буюу суурь цалин хөлс нь хувь хүний үнэлэмжийн өртгийг гэхээсээ илүү тухайн ажлын үнэ цэнийг тусгадаг.

Хувьсах цалин гэдэг нь хувь хүний ажлын гүйцэтгэлийн тоо хэмжээ, ур чадвараас ихээхэн шалтгаалдаг. Хувьсах цалинг нэмэгдэл хөлс гэж ч нэрлэдэг.

Нэмэгдэл хөлс нь:

- Сар, улирал, жилийн ажлын үр дүнгийн
- Мэргэжил, албан тушаал хавсран ажилласны
- Ажлын байр тодорхойлолтод заагаагүй ажил үүргийг гүйцэтгэсний

- Илүү цагаар ажилласны
- Албаны
- Цолны гэсэн нэмэгдэл хөлс гэж байдаг.

Нэмэгдэл хөлсийг ажилтны үндсэн цалингаас хуулинд заасан тодорхой хувиар тооцон олгодог. Харин нэмэгдэл:

- мэргэшлийн зэргийн болон хөдөлмөрийн нөхцөл, амьжиргааны тэтгэмжийн зардал
- гэр бүлд үзүүлэх тэтгэмж
- орон байрны тэтгэмж
- тээврийн зардлын болон хоол хүнсний тэтгэмж багтна.

Ярилцлага. Төр аж ахуй олон нийтийн ямарч байгууллагын удирдлага, алба хаагчдын хамтын ажиллагааны нэг хэлбэр нь ярилцлага байдаг. Хүний нөөцтэй ажиллах үед ярилцлагыг янз бүрийн хэлбэрээр зохион явуулж болдог. Ярилцлага нь байгууллагын удирдлага ажилтнуудтайгаа хамтран ажиллах арга, албан байгууллагад ажил явуулах арга хэрэгсэл болж байдаг бөгөөд харилцан мэдээлэл солилцож, хоёр талын аль алинд нь шийдвэр гаргахад нь дэмжлэг үзүүлж байдаг.

Ингэж ярилцлага хийхийн өмнө ярилцлагын гол зорилгыг тодруулах нь чухал. Ярилцлага нь хүний нөөцийг сонгон шалгаруулах, ажлын байрыг шинжилж үнэлгээ өгөх, маргаан шийдвэрлэх, зорилгоо тодорхойлох, ажил төрлийн чанартай мэдээлэл солилцох, удирдлагандаа байгаа албан тушаалтнаа мэдэж авах, хүний нөөцөө хөгжүүлэх чиглэлийг тохиролцох зэрэг зорилгоор хийгддэг.

Ярилцлагыг хийхийн өмнө бэлтгэл хангасан байхаас гадна ямар ч тохиолдолд нийтлэг зохицуулалт хийх шаардлагатай. Тухайлбал:

- ярилцлага хийх цагийг товлж тохирсон байх
- ярилцлага хийх өрөө нь тав тухтай байхын зэрэгцээ анхаарал сарниулах зүйл багатай байх
- ярилцлагыг үр дүнтэй явуулахын тулд биеэ барьсан байдал гаргуулахгүй байх үүднээс албархаг бус харьцааг бий болгох нь зүйтэй байдаг.

Албан тушаал дэвшүүлэх буюу төлөвлөх. Ажилтны давуу болон сул талын тухай дүгнэлт мэдээлэл нь байгууллагын доторхи сул орон тоог оновчтой хуваарилахад чухал шаардлагатай байдаг. Туршлагатай ажилтнуудыг илүү хариуцлагатай албан тушаалд дэвшүүлж болох бөгөөд зарим ажилтан таарч тохирох өөрийн сонирхсон албан тушаалд шилжин ажиллах хүсэлтэй байж болно.

Албан тушаал ахих төлөвлөлт нь байгууллагын хүний нөөцийн хөгжлийн нэг бүрэлдэхүүн хэсэг юм³⁴. Албан тушаал ахих төлөвлөлт нь байгууллага дахь зөвхөн мэргэжлийн үйл ажиллагааг тусгадгаараа бусад төлөвлөлтүүдээс ялгаатай. Энэ төлөвлөлт нь хүнээ тухайн алба хаагчийг сайн судалсны үндсэн дээр хийгддэг.

Мэргэжлийн болон байгууллага дотор гэсэн хоёр үндсэн албан тушаал ахих төрөл байдаг.

Мэргэжлийн албан тушаал ахих нь тодорхой нэг ажилтан өөрийн хөдөлмөрийн үйл явцад хөгжлийн олон үе шатаар тодорхойлогддог. Тухайлбал: суралцах, өөрийгөө хөгжүүлэх, ажилд орох, шинэ санаа санаачлага гаргах, мэргэжил, мэргэшил, үр чадварын өсөлт, эцэст нь тэтгэвэрт гарах болно.

³⁴Ц.Цэцэгмаа “Хүнийн нөөцийн менежмент”1996 он, 231 дахь тал

Байгууллага дотрох албан тушаал ахих нь нэг байгууллагад ажилтан тодорхой албан тушаал дэвших байдлаар тодорхойлогдоно.³⁵ Энэ нь босоо ба хөндлөн гэж 2 ангилагдана.

Босоо- бүтцийн шатлалын өндөр түвшний албан тушаалд дэвших

Хөндлөн- байгууллагын үйл ажиллагааны нэг салбар, нэгж төрлөөс нөгөөд шилжих явдал юм.

Албан тушаал ахих төлөвлөлтийг хэдийгээр цаг хугацаа, хөрөнгө мөнгө зарцуулдаг ч энэ нь байгууллага болон хувь хүмүүсийн хэрэгцээг хангахад чухал ач холбогдолтой. Иймд бид байгууллага болон хувь хүнд карьерын төлөвлөлт ямар ач холбогдолтой талаар авч үзье.

➤ Байгууллагын хувьд

Үр ашигтай албан тушаал ахих төлөвлөлт гэдэг нь: байгууллага хүний нөөцөө оновчтой ашиглаж, ажиллах тэгш боломжийг ажилтнуудад олгож байна гэсэн үг. Энэ 2 зүйл хоёулаа байгууллагад чухал байдаг. Хэрвээ хүмүүс байгууллагын хамгийн чухал хөрөнгө мөн л юм бол тэдний ур чадвар, нөөцийг ямар нэгэн байдлаар хангалтгүй ашиглах нь хөрөнгөө үр дүнгүй хий хоосон зүйлд зарцуулсантай нэг утгатай болно. Иймээс албан тушаал ахиулан тухайн хүний мэдлэг чадвар, амьдралын туршлагыг ашиглах нь зүйтэй.

➤ Хувь хүний хувьд

Албан тушаал ахих нь хувь хүний хувьд ямар нэгэн хэрэгцээ хангах, тэр тусмаа эрх мэдлийн, нэр хүндийн, болон санхүүгийн гэсэн хэрэгцээг нэгэн зэрэг хангах боломжийг олгодог байна. Ийм учраас ямар ч хүн албан тушаалд дургүй байдаггүй. Албан тушаал ахиснаар хариуцлага ч нэмэгдэнэ гэдгийг тухайн алба хаагч ухамсарлах нь зүйтэй юм.

Дээрхи сэдвээс дараах асуудлыг дэвшүүлэн тавьж байгаа юм. Үүнд:

1. Төрийн тусгай албан хаагчдыг өнөөгийн нөхцөлд нийцүүлэн тухайн албан тушаалын шаардлагын дагуу тасралтгүй сургаж, хөгжүүлэх
2. Албан хаагчдын цалин хөлс урамшууллыг ажлынгүйцэтгэл эцсийн үр дүнгээр нь дүгнэж, ажилдаа шинэ санаачлага, шинэ арга нэвтрүүлсэн ажилтныг урамшуулах аргаар идэвхжүүлэн хөгжүүлэх
3. Төрийн алба иргэдэд түшиглэн төрийн үйлчилгээгээ ойртуулах арга хэлбэрээ боловсронгуй болгох
4. Төрийн тусгай алба хаагчдыг батлагдсан хууль дүрмийн хүрээнд ажиллах, ажиллуулах дагаж мөрдөж байх дадал хэвшилтэй болгох. Ингэхийн тулд төрийн тусгай байгууллага нь байгууллагынхаа дотоод журамд нэмэлт өөрчлөлтүүдийг тусгах
5. Төрийн албанд бие бялдар сэтгэлзүй, ур чадвар, мэдлэг боловсрол зэрэг тусгай шаардлага нөхцлийг хангасан иргэдээс зохих сонгон шалгаруулалт явуулсны үр дүнд авч ажиллуулж байх
6. Төрийн албаны тухай хуулийн 33.6.1-д зааснаар төрийн албан хаагчдын сургалтын тодорхой хөтөлбөр төлөвлөгөөний дагуу тасралтгүй сургах, давтан сургах, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулж байх
7. Төрийн үйлчилгээний ажлын чанарыг сайжруулах, тэнд ажиллагсдын ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор гадаад орны тэргүүн туршлагыг судлах, алба хаагчдыг тогтмол туршлага судлуулан, үйл ажиллагаандаа нэвтрүүлж байх

³⁵ Б.Мөнхжаргал, Б.Амаржаргал “Менежмент” 2008 он, 183 дахь тал

8. Цагдаагийн алба хаагчийн ажлыг үнэлэх үнэлгээний загварчлал, шалгуур үзүүлэлтүүдийг харахад алба хаагч өөрийн хийсэн ажлаа бодитойгоор үнэлэх арга зүйд сургах, өөрийгөө хөтлөн жолоодоход чиглүүлэх, тусалж дэмжих, эрчимжүүлэхэд байгууллагын удирдлагын үүрэг нэн чухал болох нь харагдаж байгаа юм.

ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ

ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ХҮҮХДИЙН ЭРХ



О.Отгонтуяа

Хууль сахиулахын их сургуулийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Эрх зүйн онолын тэнхимийн ахлах багш, хууль зүйн магистр

Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлын гол тулгуур нь Монгол Улсын баялаг болсон Монгол хүн билээ.

Монгол Улсын Үндэсний аюулгүй Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд үндэсний аюулгүй байдал: “Үндэсний аюулгүй байдал” Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсан байдлыг ойлгох бөгөөд “Үндэсний язгуур ашиг сонирхол”-д Монгол Улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, Монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, үндэсний эв нэгдэл, хүний эрх, эрх чөлөө баталгаатай хангагдсан байдал, эдийн засгийн тогтвортой, экологийн тэнцвэрт хөгжил багтана хэмээн хуульчлан тогтоосон.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэгт:

- Монгол Улсын аюулгүй оршин тогтнохын аюулгүй байдал
- **Хүн амын удмын сангийн аюулгүй байдал**
- Эдийн засгийн аюулгүй байдал
- Нийгэм төрийн аюулгүй байдал
- Хүний эрх, эрх чөлөөний аюулгүй байдал
- Монголын соёл, иргэншлийн аюулгүй байдал
- Шинжлэх ухаан, технологийн аюулгүй байдал
- Мэдээллийн аюулгүй байдал багтах ба уг бүрэлдэхүүн хэсгийн нэг нь

алдагдахад үндэсний аюулгүй байдлын тухай цогц бодлого гарна.

Монгол Улсын хүний удмын сангийн аюулгүй байдалд хамаарахуйц хүүхэд, түүний эрх зүйн байдал хэрхэн тусгагдсан тэр дундаа Гэр бүлийн хууль тогтоомжоор хүүхэд үрчлэх асуудлыг хэрхэн зохицуулж ирсэн, цаашид энэ талаарх хууль тогтоомжийн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудлын санал, дүгнэлт гаргахыг зорилоо.

Монгол Улсын хүүхдийн эрхийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох үүднээс Үндсэн хуулийн үзэл баримтлал, зарчимд нийцсэн олон хууль тогтоомж батлагдан хэрэгжиж байгаа билээ.

НҮБ-аас 1989 онд баталсан “Хүүхдийн эрхийг хамгаалах тухай конвенц”-д манай улс нэгдэн орж, УИХ-аас 1996 онд Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийг батлан хүүхдийн эрхийг хамгаалах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн бөгөөд 1999 онд батлагдсан Гэр бүлийн тухай хууль нь бүрэлдэхүүн хэсэгт нь мөн багтана.

Гэр бүлийн тухай хуулиар гэрлэгчид, гэр бүлийн гишүүний эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн харилцааны эрх зүйн үндсийнх бүрдүүлсэн бөгөөд хүнд нөхцөлд байгаа бүтэн өнчин, хараа, хяналтгүй хүүхдийг эрх, ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулж байна.

Хүүхэд үрчлэх, гэр бүлдээ асарч хүмүүжүүлэхийг хүссэн иргэнд гэрээний үндсэн дээр хүүхдийг асран хүмүүжүүлэхээр шилжүүлэх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоохтой холбогдсон харилцааг ч дээрх хуулиар нарийвчлан зохицуулж байна.

Манай улс 2007 онд 2378, 2014 онд 6158³⁶ хүүхдийг Монгол Улсын иргэнд, 1999-2014 онд хүртэл 15 улсын иргэнд 386³⁷ хүүхдийг үрчлүүлсэн байна.

Хүүхэд үрчлэх асуудлыг бодил амьдрал дээр хүүхэд өргөж авах гэж ярьдаг бөгөөд уг зүйн талаас нь Монгол хэлний тайлбар тольд³⁸ “**хүүхэд үрчлэх** гэдэг нь бусдыг өөрийн болгон тэжээх, үрчлүүлэх нь үрчлэхийн үйлдүүлэх хэв” гэж харин эрх зүйн талаас нь Хууль зүйн тайлбар тольд³⁹ “**үрчлэлт** гэдэг нь бусдын хүүхдийг өөрийн хүүхэд болгон тэжээх явцад үрчлүүлэгч, үрчлэгдэгч, үрчлэгчийн хооронд эд хөрөнгийн бус амины шинжийг агуулсан эрх зүйн тодорхой төрлийн харилцаа буюу үрчлэлтийн харилцаа үүсэх, энэ нь гэр бүлийн эрх зүйн нэгэн институт болно” гэж тодорхойлсон билээ.

Хүүхэд үрчлэх нь тодорхой зорилготой, эрх зүйн онцлог, үр дагаварыг агуулж байдаг өвөрмөц төрлийн харилцаа юм. Уг харилцааг тодорхойлон авч үзвэл:

1. Хүүхэд үрчлэх нь ямар нэгэн шалтгаанаар эцэг, эхийн асрамж, халамжгүй үлдсэн хүүхдийг гэр бүлд өсгөн хүмүүжүүлэх хэлбэр юм.

Хүүхдийн эрхийн тухай конвенцид “хүүхэд нь гэр бүлийнхээ дотор аз жаргалтай, хайр халамжтай, бие биеэ ойлгодог нөхцөлд өсч бойжиж бүрэн төгс, өв тэгш хөгжиж чадна гэдгийг заасан байдаг. Мөн түүнчлэн хүүхэд өөрийн гэр бүлээсээ түр буюу бүрмөсөн хагацсан эсвэл гэр бүлийнхээ дотор цаашдаа байвал язгуур эрх ашигт нь аюултай болбол тухайн хүүхэд онцгой асрамжуулах, тусламж авах эрхтэй байх, ингэж асрамжлах явдалд хүүхдийг үрчлүүлэх зүйл хамаарна” гэжээ. Гэр бүл нь хүүхдийн зан байдал төлөвших, хүний хүмүүжлийн суурь орчин байдаг ба бүтэн өнчин хүүхэд, эцэг, эх нь хоёулаа иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжгүй гэж тооцогдсон, эцэг, эх байх эрхээ хасуулсан этгээдийн хүүхдийг хүүхдийн эрх, ашиг сонирхолд нийцсэн гэр бүлд хүмүүжүүлэхийг зорьдог.

2. Хүүхдийн эрх, ашгийг хамгаалах үүднээс тэдний бусдад үрчлүүлнэ. Хүүхэд үрчлэх нь хүнд нөхцөлд байгаа эцэг, эхгүй, бүтэн өнчин хүүхдийн эрх, ашгийг хамгаалж хэвийн амьдрах эрхийг хэрэгжүүлж байгаа нэгэн хэлбэр бөгөөд үрчлэлтийн асуудлыг шийдвэрлэснээр хүүхдийн суурь эрхүүд бий болох боломж бүрдэх юм. Түүнээс хүүхэд үрчлэх нь ашиг, хонжоо олох, хөдөлмөрийг нь үнэлэх зэрэг хүүхдийн хувьд сөрөг хүчин зүйл бий болох үйл ажиллагаа биш юм.

3. Хүүхэд үрчлэх нь гэр бүлийн эрх зүйн системд бие даасан нэг институт бөгөөд үрчлэлттэй холбогдсон үүссэн эд хөрөнгийн бус амины ба эд хөрөнгийн харилцааг зохицуулж буй хэм хэмжээний нийлбэр юм хэмээн ойлгож болно. Гэр бүлийн эрх зүйн нэг үндсэн чиг үүрэг нь хүүхэд үрчлэх нөхцөл, журам, үрчлэгч, үрчлүүлэгчийн эрх, үүрэг, үрчлэлтийг хүчингүйд тооцох, Монгол Улсын харьяат хүүхдийг гадаадын иргэнд үрчлүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан хэм

³⁶Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвөөс авсан статистик

³⁷Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албанаас авсан статистик

³⁸Я.Цэвэл “Монгол хэлний тайлбар толь” 623 дах тал

³⁹Хууль зүйн тайлбар толь, 288 дах тал

хэмжээг агуулдаг. Хүүхэд үрчлэлт нь зөвхөн хүчин төгөлдөр хууль тогтоомжид заасан үндэслэл журмын дагуу явагдах үйл ажиллагаа юм.

4. Хүүхэд үрчлэх нь эрх зүйн харилцааг үүсгэх, дуусгавар болгоход чиглэсэн хууль зүйн факт юм. Үрчлэлтийн харилцаанд нэг талаас үрчлэгч ба түүний төрөл садан, нөгөө талаас үрчлэгдсэн хүүхдийн хооронд эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх, үүрэг үүснэ. Мөн үрчлэгдсэн хүүхэд, төрүүлсэн эцэг, эхийн хооронд эрх, үүрэг дуусгавар болж, үрчлэгч, үрчлүүлэгчийн хооронд төрсн эцэг, эхийн хооронд үүсдэг эрх, үүрэг бий болдог учир хүүхэд үрчлэхийг хууль зүйн факт гэнэ.

5. Гэрлэгчид хүүхэдтэй болох нэг арга нь хүүхэд үрчлэх юм. Гэрлэгчид нь хүүхэд төрүүлээгүй, төрүүлэх боломжгүй, эсвэл төрүүлсэн хүүхэдтэй боловч бусдын хүүхдийг асрамжиндаа авч өөрийн хүүхдийн адил хайрлан халамжилж болно. Энэ тохиолдолд гэрлэгчид буюу эхнэр, нөхөр нь хүүхэдл үрчлэх талаар харилцан зөвшөөрөлцсөн байх ба энэ тухай хүсэлтээ хамтран эрх бүхий байгууллагад гаргасан байхыг шаардана.

Энэ бүгдээс үзвэл **хүүхэд үрчлэх** гэдэг нь хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу бусдын хүүхдийг тэдний ашиг сонирхлын үүднээс гэр бүлдээ хүмүүжүүлэхээр авч, үрчлэгдсэн хүүхэд, үрчлэгчийн хооронд төрсөн эцэг, эх, хүүхдийн нэгэн адил харилцааг үүсгэж байгаа үйл ажиллагаа юм.

Хүүхэд үрчлэхтэй холбогдсон харилцааг Гэр бүлийн хууль тогтоомжийн хүрээд авч үзвэл:

1926 оны Иргэний хуулийн “Гэр бүлийн эрх, үүргийн тухай” 3 дугаар бүлэг	1956 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр АИХТ-ийн зарлигаар БНМАУ-ын Гэрлэх ба гэр бүл, асрамж, тэтгэмжийн тухай хууль	1973 оны АИХТ-ийн 159 тоот зарлигаар БНМАУ-ын Гэр бүлийн хууль	1999оны 6 дугаар сарын 11-ний өдөр УИХ-аас баталсан Гэр бүлийн тухай хууль
Аливаа эх нялхас буюу насанд хүрээгүй багачуудыг үрчлэхэд эрх биш тэдний эрх, ашгийг урьтал болговоос зохино хэмээн үрчлэлтийн зорилгыг тодорхойлсон. Бусдын хүүхдийг үрчлэн авч болохгүй хүмүүст: • 70 насанд хүрсэн өвгөд, эмгэд • Хэргийн учир шүүн таслах газраас эрх хасагдсан хүмүүс • Асрамжлан хамгаалах этгээд лүгээ аливаа ажил ба	Уг хуулийн 3 дугаар бүлэг “Хүүхэд өргөж авах тухай” хэмээн нэрлэж, хүүхэд үрчлэхтэй холбогдсон харилцааг зохицуулж байжээ. Энэ хуулийн 46 дугаар зүйлд хүүхэд өргөж авч үл болох хүмүүсийг тодорхой тогтоожээ. • Шүүхээс сонгуулийн эрхээ хасуулсан • Өргүүлэх	Уг хуулийн 7 дугаар бүлэгт хүүхэд үрчлэн авах журам, үрчилсэнд тооцох тохиолдол, үрчлүүлэх хүүхдийн нас, хүүхэд үрчлэн авахад харшлах шалтгаан, үрчилснийг хүчингүйд тооцох, үрчлүүлсэн хүүхдийн тэтгэвэр, тэтгэмж авах эрхтэй холбогдсон харилцааг зохицуулж байсан. Хүүхэд үрчүүлж болохгүй хүн: • Сэтгэл мэдрэлийн өвчтэй • Согтууруулах	Уг хуулийн 7 дугаар бүлгээр зохицуулдаг. Өмнөх хуульд байгаагүй шинэ зохицуулалт: • Үрчлэгч, үрчлүүлэгч гэрлэвэл гэрлэхэд харшлах шалтгаанд тооцож гэрлэлтийг хүчингүйд тооцох • Хүүхдийг гадаадын иргэнд үрчлүүлж болох • Хүүхдээ үрчлүүлэх эцэг, эхийн зөвшөөрөл болон хүүхэд үрчлэн авах

хөрөнгийн холбогдол буй бөгөөд эцэстээ үл тохирох зүйл гаргах нь болзошгүй буюу завсаргаа • Эв найрамдал -гүй хүмүүс 10 насад хүрсэн хүүхдийг үрчлэхэд зөвшөөрлийг нь авах, үрчлэгдсэн хүүхэд үрчилсэн этгээдийг овгийг хэрэглэх, тэдний хооронд төрсөн хүүхэдтэй нэгэн адил эрх, үүрэг үүсэх үндсийг баталгаажуулсан. Үрчлэлтийн асуудлыг орон нутгийн захиргааны байгууллага Засгийн газрын дэргэдэх хэрэг эрхлэх газрын хяналтын дор гүйцэтгэж байсан байна Үрчлэлтийн асуудлыг захиргааны журмаар шийдвэрлэдэг, тодорхой насанд хүрсэн хүүхдийг үрчлэхэд өөрсдийнх нь саналыг авдаг зохицуулалт өнөөг хүртэл уламжлагдан үйлчилж байна.	хүүхдэд өшөө хонзонтой • Хүүхдийн ашиг тусад нь харш • Насанд хүрээгүй • Өнгөний өвчтэй буюу халдварт сүрьеэтэй хүмүүс Хүүхэд өргүүлсний дараа эд хөрөнгийн эрх, үүргийг төрсөн хүүхдийн хэмжээнд адилтган авч үзвэл зохино гэж заасан байна.	ундааны зүйл хэт хэрэглэдэг • Эрүүгийн хэрэгт удаа дараа шийтгүүлсэн буюу ял эдэлж байгаа • Эцэг, эх байх эрхээ хасуулж байсан • Үрчлүүлсэн хүүхдээ өөрийн буруугаас буцаан өгүүлэхэд хүргэсэн • Насанд хүрээгүй • Гэрлэлтээ цуцлуулж байгаа гэрлэгчид 9 насанд хүрсэн хүүхдийн өөрийнх нь саналыг, 3 нас хүрээгүй бол Эрүүлийг хамгаалах байгууллагын зөвшөөрлийг авсны үндсэн дээр хүүхэд үрчлүүлдэг байсан. Үрчлэлт нь зөвхөн 16 насанд хүрээгүй хүүхдэд хамаарч, нэг нас хүрээгүй хүүхдийг онцгойлон тогтоосон нөхцөлд бусдад үрчлүүлдэг журам үйлчилж байсан. Гэрлэлтээ бүртгүүлэх үед нэгнийхээ дагавар хүүхдийг нөгөө нь төрсөн хүүхдийн адил асрн хүмүүжүүлэхээр зөвшөөрсөн, ач зээгээ үрчлэн авахаар эцэг, эхтэй нь хэрэв эцэг, эхгүй бол асран хамгаалах байгууллагатай тохиролцсон бол хүүхэд үрчлэгдсэнд тооцож, хүүхдийг төрсөн хүүхлийн	тухай хүсэлтийг бичгээр гаргаж, нотариатаар гэрчлүүлсэн байх • Эцэг, эх байх эрхээ хасуулсан хүний хүүхлийг энэ тухай шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш 6 сарын дотор үрчлүүлж болох • Сум, дүүргийн Засаг дарга хүүхэд үрчлэн авах хүсэлтийг 20 хоногийн дотор багтаан хянан шийдвэрлэх гэх мэт Хүүхэд үрчүүлж болохгүй хүн: • Ганцбие • бусдынасрамжидб айгаа 60-аас дээшнастайтөрөл, саданбусМонголУлс ыниргэн • 60-аас дээшнастайгадаады ниргэн • эцэг, эхбайхэрхээхязгаар луулсан, хасуулсанбуюухязга арлуулж, хасуулжбайсан • урьдньүрчлэнавса нхүүхдээөөрийнбур уугаасбуцаанөгсөн • ашигхонжоолохз орилготой • шүүхийншийдвэр ээриргэнийэрхзүйнэ рхийнбүрэнчадамжг үйбуюухязгаарлагд малчадамжтайгэжто оцогдсон • сүрьеэ, сэтгэцийнөвчтэй, согтууруулахундаа,
---	---	---	---

		адил өсгөн хүмүүжүүлэх, тэжээн тэтгэх зэрэг эцэг, эх, хүүхдийн хоорондын бүхий л харилцааг нарийн зохицуулсан. Үрчлэлтийг хариуцан шийдвэрлэдэг байгууллага нь Ардын депутатын хурлын гүйцэтгэх захиргаа байсан.	мансууруулах бодис байнга хэрэглэдэг • эрүүгийн хэрэгтуд аадараа шийтгүүлсэ н болон хорих ял дэл ж байгаа хүнд 7 насанд хүрсэн хүүхдийн өөрийн зөвшөөрлийг авсны үндсэн дээр үрчлүүлж байхаар заасан.
--	--	--	---

Хүүхдийн эрхийн хамгаалах төрийн бодлогын хүрээнд хүүхэд үрчлэлтийн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийг улам боловсронгуй болгох нь өнөөгийн нийгэмд олноор бий болсон хүнд нөхцөлд байгаа хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалаад зогсохгүй, эцэг, эхийн асрамжид байгаа хүүхдийн эрх, ашгийг нэгэн адил хамгаалахад чухал ач холбогдолтой дурдаад дараах саналыг дэвшүүлж байна.

1. Гэр бүлийн тухай хуулийн “Хүүхэд үрчлэх” гэсэн бүлэгт үрчлэгдэх хүүхдийн насыг тодорхой заах нь зүйтэй болов уу.

Учир нь үрчлэгдэх хүүхдийн насыг тодорхой заалгүй “хүүхэд” гэж ерөнхийлөн нэрлэснээр хүүхэд гэж хэнийг хэлэх вэ гэдгийг тодорхойлсон Хүүхдийн эрхийн конвенцийн нэгдүгээр хэсгийн нэгдүгээрт “18 нас хүрээгүй хүн бүрийг хүүхэд гэнэ” гэсэн заалт, Монгол Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хүүлийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “хүүхдийн эрхийг төрсөн цагаас нь эхлэн 18 насанд хүртэл хамгаалахад энэ хууль үйлчилнэ” гэсэн заалтуудыг удирдлага болгон 18 насанд хүрээгүй бол ямар ч насны хүүхдийг үрчлүүлж болох зохицуулалт гарч ирж байна. Энэ нь практикт ялангуяа иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн үйл ажиллагаанд нилээд хүндрэл учруулж байгаа юм. Ямар ч насны хүүхдийг үрчилсэн тохиолдолд иргэний бүртгэлийн ажилтан үрчлэлтийн бүртгэлтийг үйлдэх бөгөөд хүүхдээ үрчлүүлсэн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид хүүхэд үрчлүүлсний гэрчилгээ, үрчлэн авсан эцэг, эхэд хүүхдийн төрсний гэрчилгээг шинээр бичиж олгодог журамтай.

Гэтэл 16 насанд хүрсэн иргэнд тус улсын иргэн мөн болохыг батлан гэрчлэх баримт бичиг болох иргэний үнэмлэхийг олгож, 16-аас дээш насны бүх хүн иргэний үнэмлэхтэй байх ёстой учраас 16 насанд хүрсэн хүүхдийг үрчлэхэд иргэний үнэмлэхэд бичигдсэн эцэг, болон эхийн нэрийг өөрчлөх зайлшгүй шаардлага давхар гарч байна. Энэ нэг удаа өөрчлөх л зохицуулалттай. Хэрэв ганц бие эмэгтэй 16 насанд хүрсэн хүүхдийг үрчлэн авах хүсэлт гаргалаа гэж үзвэл хүүхдийн эхийн нэрийг өөрчлөх боломжгүй мэт. Нөгөөтэйгүүр 16 настай хүүхдийн төрсний гэрчилгээг үрчилсэн эцэг, эхэд шинээр бичиж олгох боломжгүй бөгөөд учир хүүхэд иргэний үнэмлэх авчихсан байдаг.

Нөгөөтэйгүүр 16 насанд хүрсэн хүүхэд нь Иргэний хуульд зааснаар иргэний эрх зүйн бүрэн бус чадамжтэй этгээд бөгөөд өөрийн үйлдлээр тодорхой эрхүүдийг хэрэгжүүлэх боломжтой байдаг. Тухайлбал, хөдөлмөр эрхлэх, хөдөлмөрийн хөлсөө захиран зарцуулах, зарим төрлийн хэлцэл хийх эрхтэй байдаг өөрөөр хэлбэл эцэг, эх харгалзан дэмжигчийн дэмжлэг, тусламжаас тодорхой хэмжээнд чөлөөлөгдсөн байдаг учраас 1973 оны Гэр бүлийн хуулийн хуучин заалтыг өвлөн авч 16 хүртэлх насны хүүхдийг бусдад үрчлүүлж болох талаар хуульд тусгах нь зүйтэй юм.

2. Үрчлэгч, үрчлүүлэгчийн хооронд насны тодорхой зөрүү байхаар хуульд тусгаж өгөх нь зүйтэй юм. Одоо мөрдөгдөж байгаа Гэр бүлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд үрчлэгч, үрчлүүлэгч хоёр гэрлэхийг хориглосон заалтыг шинээр тусгаж өгсөн. Гэтэл 18 насанд хүрсэн иргэн 18 насанд хүрээгүй хүүхдийг тэжээн тэтгэж, өсгөн хүмүүжүүлэх боломжтой л бол үрчилж авч болохоор хуулийн зохицуулалт үйлчилж байна.

Ялангуяа ганц бие, гэрлээгүй, хүн эсрэг хүйсийн хүүхдийг үрчилж авах тохиолдолд тодорхой насны зөрүү зайлшгүй байх шаардлагатай юм. Гадаадын хууль тогтоомжийн хүрээнд авч үзвэл энэ асуудлыг тодорхой шийдсэн улс орон байна. Тухайлбал Оросын Холбооны Улсын Гэр бүлийн тухай хуулийн 128 дугаар зүйлд зааснаар дээрх насны зөрүүг гэрлээгүй хүмүүсийн хувьд 16 байхаар тогтоосон ба хэрэв хүүхдийг хойт эцэг, эх нь, эсхүл гэрлэсэн эхнэр нөхөр хоёр үрчилж байгаа тохиолдолд насны зөрүүтэй байхыг шаарддаггүй байна.

3. Гэр бүлийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 3 дах хэсэгт “Дагавар хүүхэд хойт эцэг, хойт эхийн хооронд эцэг, эх хүүхдийн эрх үүрэг үүснэ” гэж заасан нь ямар үндэслэлээр энэ харилцаа тодорхойлогдох вэ гэдэг нь тодорхой бус байна. Өөрөөр хэлбэл дагавар хүүхдийг үрчилснээр үү? хойт эцэг, эх гэрлэлтээ бүртгүүлснээр үү? Үрчлэлтийн үндсэн дээр тэдний хооронд эцэг, эх, хүүхдийн харилцаа үүснэ гэж үзвэл хуульд зааснаар хүүхдийг төрүүлсэн эцэг, эхийн зөвшөөрөл зайлшгүй шаардлагатайгаас гадна үрчүүлэгч нь хэн байх вэ? гэдэг асуудал гарч ирнэ.

Хэрэв хойт эцэг, эх гэрлэлтээ бүртгүүлсэн тэдэнтэй хамт амьдарч байгаа л бол хүүхэд хойт эцэг хойт, эхийн нэрийг шууд авах зохицуулал тэднийт манай хууль тогтоомжид үгүй юм. Гэтэл хойт эцэг, эх нь дагавар хүүхэдтэйгээ хамт амьдарч байгаа тохиолдолд хүүхдийг хүмүүжүүлэх, тэжээн тэтгэхэд төрсөн хүүхдийн нэгэн адил үүрэг хүлээдэг учраас тэдний хооронд эцэг, эх хүүхдийн хооронд үүсдэг эрх үүрэг үүсэх нь ойлгомжтой.

Тийм учраас гэрлэснээ бүртгүүлэх үед нэгнийхээ дагавар хүүхдийг нөгөө нь төрсөн хүүхдийн адил өсгөж хүмүүжүүлэхээр зөвшөөрсөн бол хүүхдийн эсхүл хүүхдийн эрх ашгийг хамгаалах байгууллагын саналыг харгалзан энэ асуудлыг шийдвэрлэх боломжтой юм.

1973 оны Гэр бүлийн тухай хуульд “Хүүхдийн эрх ашигт харшлахгүй бол дагавар хүүхдээ асарч хүмүүжүүлэхээр зөвшөөрсөн, энэ тухайгаа бичгээр гаргасан бол хүүхдийг үрчилсэнд тооцож болно” гэсэн зохицуулалт байсныг одоогийн хуульд тусгаж хэрэглэх боломжтой мэт.

4. Үрчлэгч нь үрчилж авсан хүүхдээ тодорхой нөхцөл шалтгаангүйгээр бусдад үрчлүүлэхийг хориглосон заалтыг ч хуульд тусгаж өгөх нь зүйтэй юм.

5. Монгол улсын харъяат хүүхдийг гадаадын иргэн үрчлэн авахыг хүсвэл үрчлүүлж болох зохицуулалт хуульд шинээр тусгагдсан хэрэгжиж байна.

Манай улсын нэгдэн орсон Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 20, 21 дүгээр зүйл, Хүүхдийг хамгаалах ба улс хооронд эрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай Гаагийн конвенцид зааснаар хүүхдийн дээд ашиг сонирхолын дагуу, тэдний эрхийн хүрээнд улс хооронд үрчлүүлж болох эрх зүйн зохицуулалтын үндэс тавигдсан.

Одоо мөрдөгдөж байгаа Гэр бүлийн тухай хуулийн 58 дугаар зүйл, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Нийгэм хамгаалал, хөдөлмөрийн сайдын хамтарсан 2001 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 100/32 тоот тушаалаар батлагдсан “Гадаадын иргэнд Монгол Улсын харъяат хүүхдийг үрчлүүлэх журам”-ын хүрээнд хүүхдийг Гадаадын иргэнд үрчлүүлж байгаа.

Хууль болон журмын зохицуулалтаас харахад хүүхдийг таваас доошгүй жил хамт амьдарсан гэр бүлд эсхүл ганц бие гадаадын иргэн – эмэгтэйд үрчүүлж байх журамтай. Гэтэл Монгол Улсад үйл ажиллагаагаа явуулдаг ашгийн төлөө бус,

хүүхдийн эрх ашгийг хамгаалахын төлөө ажилладаг байгууллага хүүхэд үрчлэх тусгай зөвшөөрлийг авсны үндсэн дээр гадаадын иргэнд Монгол улсын харьяат хүүхдийг үрчлүүлдэг байх юм.

“Small world”, “Hold international”, “Lutern social service” хэмээх эдгээр байгууллагуудын үрчилсэн хүүхдийн тоо ч байна.

Ямар хууль тогтоомжийн хүрээнд дээрх байгууллагуудад хэн тусгай зөвшөөрөл олгосон нь сонирхол татаж байна.

Манай улсын хувьд 2004 онд Улсын Их Хурлаас “Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого”⁴⁰-ыг баталсан бөгөөд цөөн хүн амтай, уудам нутагтай, хүн амын нягтрал багатай орон гэдгийг тодорхойлоод хүн амын жилийн дундаж өсөлт сүүлийн жилүүдэд байнга буурч байгаа үзүүлэлтийг дурдаад төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогын зүйл нь **хүн амын тогтвортой өсөлтийг хангахад** чиглэгдэнэ гэдгийг ч тодорхойлсон байдаг.

Гэтэл хүүхдийг гадаадын иргэнд тэр тусмаа хууль тогтоомжинд тусгагдаагүй субъект болох байгууллагаар дамжуулан гадаадад үрчлэх шаардлага байна уу? Хүүхдийг оюун ухаан, бие бялдарын хувьд өв тэгш, өсгөн хүмүүжүүлэх, эрүүл чийрэг, сайн сайхан амьдрах орчин нөхцлийг төрөөс хэрэгжүүлж байгаа бодлогын хүрээнд тэдний эцэг, эх асран хамгаалагч харгалзан дэмжигч нь бүрдүүлэх үүрэгтэй. Хүүхэд үнэхээр хүнд нөхцөлд байгаа бол төр онцгой анхааралдаа авч эрх ашгийг нь хамгаалах шаардлагатай байгаа юм.

Эдгээр хүүхдийн эрх ашгийг хэрхэн хамгаалах талаарх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох үүднээс олон хуулийг батлан мөрдүүлж байгаа төдийгүй, хүүхдийг гэр бүлдээ асарч хүмүүжүүлэхийг хүссэн иргэнд хүүхдийг гэрээний үндсэн дээр шилжүүлж гэр бүлд асарч хүмүүжүүлэх зохицуулалтыг шинээр хуульд тусгаж өгсөн нь ач холбогдолтой юм. Монголын хүүхэд монгол эх орондоо амьдрах эрхтэй, тэднийг харийн хүнд өгмөөргүй байна. Гадаадын улс орнуудын гэр бүлийн хууль тогтоомжийн зохицуулалтаас үзэхэд хүүхэд үрчлэх асуудлыг ихэнх улсад шүүх иргэний журмаар хянан шийдвэрлэдэг байна. Харин АНУ-ын ихэнх муж улсуудад үрчлэлтийн асуудлыг хариуцсан тусгай эрхийн зөвшөөрөл бүхий агентлаг /байгууллага/-аар дамжуулж хүүхэд үрчлэх боломжтой байдаг. Манай улсын хувьд ч гэсэн гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэх нь зүйтэй гэж үзвэл энэхүү асуудлыг шүүх харьяалан шийдвэрлэж, харин үрчлэгдсэн хүүхдэд хяналт тавих үүргийг одоогийн мөрдөж байгаа хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэж байх нь зүйтэй юм.

⁴⁰“Төрийн мэдээлэл” сэтгүүлийн 2004 он, № 20

**ХУУЛЬ ЁСНЫ ЭРХЭЭ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТӨРӨЛ, АНГИЛАЛТ**



Б.Хишигтогтох

ХСИС-ийн, Цагдаагийн сургуулийн, Мөрдөх ажиллагааны онол тактикийн тэнхимийн ахлах багш, докторант, цагдаагийн дэд хурандаа

Хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх нь гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдал мөн болохын хувьд түүний ерөнхий ангилалт, төрлүүдийг нарийвчлан судлан тогтоох нь зайлшгүй болохын дээр ингэснээрээ уг асуудлын эрүүгийн эрх зүйн онол-арга зүйн жинхэнэ шинжлэх ухааны түвшинг улам нэмэгдүүлэх нь тодорхой бөгөөд ер нь аливаа судлагдахууны ангилалт, түүний шалгуур болон түүнд хамаарах шинж тэмдгүүдийг нь нарийвчлан гаргах нь арга зүйн хувьд зайлшгүй тавигддаг шаардлага юм.

Гэвч ангилалтын үндэслэл, шалгуур нь янз бүр байх нь тодорхой боловч түүнд хамаарах үндсэн нөхцөл байдлууд гэж заавал байдаг бөгөөд тухайлбал хохирлын объект, өөрийнхөө эрхийг хэрэгжүүлж байгаа субъект зэрэг олон хүчин зүйл нөлөөлдөг. Энэ тухай Г.К.Рахимжанова бичихдээ: “Хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг судлагдахууных нь хувьд арга зүйн талаас нь ерөнхий буюу дэлгэрэнгүй хэмжээнд мөн нарийвчилсан хүрээнд авч үзэх шаардлагатай. Тухайлбал: Уг ойлголт нь хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа аливаа ажиллагааг хийж буй тухайн этгээдийн юуны өмнө субъектив эрхэд хамаарах үйлдлүүд байдаг.

Энэ нь янз бүрийн үйлдлүүд байж болох талтай тул тэр болгоныг тоочих боломжгүй боловч уг ажиллагаа нь мөн чанарын хувьд нийгэмд ашигтай бөгөөд уг үйлдлийг хийж буй этгээдэд хууль ёсоор олгосон эрх үүрэгтэй нь шууд холбоотой байдгаараа онцлогтой”⁴¹ гэсэн нь хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа аливаа ажиллагааг өргөн хүрээнд авч үзэхийг харуулж байгаа боловч тэр үйлдэл нь гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдал болохын хувьд юуны өмнө эрүүгийн хуульд урьдчилан тодорхойлон заасан байх ёстой.

Иймд уг асуудлыг нилээд өргөн утгаар нь биш харин чухамхүү нарийвчилсан буюу бүр төрөлжүүлсэн хүрээнд нь авч үзэх шаардлагатай юм. Яагаад гэвэл хууль ёсны эрхээ хэрэгжүүлж буй үйл ажиллагаа нь гол төлөв тусгай үүрэг буюу төрөлжүүлсэн алба, түүнд холбогдох тодорхой хууль, дүрэм, журамтай шууд холбоотой байдаг.

Гэвч хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны ерөнхий ба тусгай төрлүүд түүний үндэслэлүүдийг зайлшгүй ангилан тодорхойлох шаардлагатай билээ.

Иймд хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны ерөнхий төрөлд нэг талаас иргэн бүрт хамааралтай зарим ерөнхий эрхийн дагуу хийж байгаа үйлдлүүдийг оруулж болно. Жишээлбэл: Тухайн хүн нийгэм-эрх зүйн байдлаасаа үл хамаарч улс төрийн орогнолын эрхийг эдэлдэг (эдлэх ёстой) тул түүнтэй холбоотой

⁴¹ Рахимжанова Г.К.Осуществление лицом своего права как обстоятельство, исключяющее \ преступность деяния.,М 1994, 117-р тал

үйл ажиллагаа нь мөн чанарын хувьд хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйлдэлд тооцогдох нь зүйн хэрэг.

Тэгвэл хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны тусгай төрөлд иргэн нэг бүрийн биш харин тодорхой, тухайлсан хүний хийсэн үйл ажиллагаа хамаарах юм. Жишээлбэл: Эхнэр нөхөр буюу ойрын төрөл садныхаа үйлдсэн гэмт хэргийг үл мэдээлэх эрх нь үндсэн хуулийн эх сурвалжтай тул түүнийг манайхаас бусад нилээд гадаад орны эрүүгийн хуулинд тусгайлсан бие даасан зүйл болгож баталгаажуулсан байдаг.

Ийнхүү эрүүгийн хуулиар хамгаалагдсан нийгмийн харилцаанд хохирол учруулсан үйл ажиллагаа нь мөн чанарын хувьд хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйлдэлд хамаарах бөгөөд түүнийг 3 төрөлд хувааж болно. Үүнд:

1. Үндсэн хуулинд заасан буюу эрүүгийн хуулиар давхар баталгаажсан эрх.
2. Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан буюу уг хуулиар зохицуулагддаг эрх.
3. Бусад эрх зүйн салбар буюу холбогдох хуулинд нь заасан боловч эрүүгийн хуулиар давхар баталгаажуулсан эрх эдгээр болно.

Үүнээс үзвэл Монгол улсын Үндсэн хуулийн 2-р бүлэг “Хүний эрх, эрх чөлөө” гэсэн хэсгийг буюу 16-р зүйлийн 14-т заасан “...өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх” эрх нь нилээд онцлогтой бөгөөд манай Монгол улсын хувьд энэ эрхийг тус улсын Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хуулинд давхар баталгаажуулан заахдаа тун тодорхой бус, бараг “бүрхэг” төдий заалт оруулсан нь нилээд учир дутагдалтай мэт санагддаг.

Тодруулбал: Монгол улсын Эрүүгийн хуулийн тухайн зарчим нь хэдүйбээр Үндсэн хуулийн эх сурвалжтай боловч чухамхүү Үндсэн хуулийн 2-р бүлэг 16-р зүйлийн 14-т заасан агуулгыг тодорхой заагаагүйн дээр, цаашилбал Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 35.2, 36.3-р зүйлд сэжигтэн, яллагдагчийн эрх үүргийг тодорхойлохдоо Үндсэн хуулийн дээрх зарчмыг огтхон ч тусгаагүй бөгөөд зөвхөн 45-р зүйлийн 7-д “Тэрч нь гэр бүлийн гишүүн, эцэг эх, үр хүүхэд, төрөл садангийн хүний эсрэг мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхтэй” гэсэн нь бодит байдалд Үндсэн хуулийн дээрхи заалтын хууль цаазын давхар баталгаа болж чадахгүй байна.

Гэтэл ОХУ-ын Эрүүгийн хуулийн 308-р зүйлд “Эхнэр, нөхөр, үр хүүхэд, төрөл төрөгсдийнхөө эсрэг мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхтэй” гэж шууд, бие даасан эрх болгож заасан байдаг. Тэрч байтугай ОХУ-ын эрүүгийн эрх зүйн сурах бичиг, дагнасан ном-зохиолд харьцангуй утгаар нь томъёолбол “дуугүй байх эрх” (право за молчания) гэсэн бие даасан эрх буюу эрүүгийн хуулийн хэм хэмжээг юуны өмнө эрүүгийн хуульд улмаар холбогдох бусад салбар эрх (иргэний эрх, захиргааны эрх), хуульд тусган оруулах талаар тодорхой санал-дүгнэлт дэвшүүлж байгааг манай хууль тогтоогч-судлаач, эрдэмтэд анхаарах цаг нэгэнтээ болсон байна гэж үзэв.

Дээр дурьдсан эрхийн төрлүүд дотроос 2 дахь хэсэгт заасан буюу эрүүгийн хуулийн тусгай ангид урьдчилан заасан, түүний холбогдох хэм хэмжээгээр зохицуулагддаг эрх нь манай улсын хувьд одоогийн байдлаар огтхон ч байхгүй, шинэ зүйл юм.

Харин ОХУ-ын Эрүүгийн хуулийн 316-р зүйл нь “Эхнэр, нөхөр, буюу ойрын төрөл төрөгсдийнхөө үйлдсэн гэмт хэргийг урьдчилан тохирохгүйгээр нуун дарагдуулсан этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй.” гэсэн томъёололтой бие даасан хэм хэмжээ байгаа нь үнэн чанартаа “дуугүй байх эрх”-ийг давхар баталгаажуулж байгаагийн тод илрэл болж байна.

Дурьдсан төрлийн 3 дахь хэсэгт заасан “Бусад эрх зүйн салбар буюу холбогдох хуульд нь заасан боловч эрүүгийн хуулиар давхар баталгаажуулаагүй эрх” нь нилээд өргөн хүрээтэй асуудал бөгөөд энэ нь юуны өмнө Монгол улсын Хилийн

тухай, Хилийн дэглэмийн тухай хууль тэдгээрт хамаарах төрөл бүрийн тушаал, дүрэм, журам, заавартай холбогдсон үйл ажиллагаануудыг зохицуулдаг.

Хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанаас болж гарсан хор хохирол нь хэдийгээр янз бүр, олон талтай байж болох боловч эрүүгийн эрх зүйн онол-арга зүйн үүднээс авч үзвэл тэдгээр хохиролын мөн чанарыг үндэслэж тодорхой ангилан авч үзэх нь нилээд сонирхол татаж буй асуудал юм.

Энэ тухай Ю.В.Баулин бичихдээ: “Уг ажиллагаанд өртөж байгаа (өртөх байсан) объектын үнэлэмж, түүнийг тухайн субъект хэрхэн төсөөлж байгаа шинжийг үндэслэж төрөлжүүлж үзэх нь уг ангилалтын гол үндэслэл болох ёстой. Тухайлбал хуулиар хамгаалагдсан объект нь тэрхүү үйл ажиллагааны ердийн зохицуулалтын үндэс болсон төрөлжсөн хууль-дүрэм биш харин чухамхүү эрүүгийн эрх зүйн хэм хэмжээгээр хамгаалагдсан объект онцолбол хүний амь нас, эрүүл мэнд хохирсон байвал түүний үнэлэмж нь төдий чинээ нэмэгдэх бөгөөд уг болсон үйл явдлыг гэмт хэргийг үгүйсгэгч нөхцөл байдалд тооцох үндэслэл төдий чинээ бодитой болох ба харин эрүүгийн хуулиар хамгаалаагүй харилцаанд хохирол учруулсан үйл явдал нь гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдалд тооцогдохгүй байж болох талтай”⁴² гэжээ.

Иймд эрүүгийн хууль тогтоомжоор хамгаалагдаагүй эрх ашигт хохирол учруулаагүй тохиолдолд гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдалд тооцох тухай яриа байхгүй бөгөөд эрүүгийн хуулиар хамгаалагдсан объект нь түүнийг хамгаалах зорилгоор хийсэн үйл ажиллагаатай мөн чанарын хувьд шууд хамааралтай, бодит хэлхээ холбоотой байх нь тодорхой.

Энэ нь эрх зүйн мөн чанарыг материаллаг буюу бодит болон материаллаг бус субьектив эрх зүй гэж хуваадаг ерөнхий арга зүйн үндэслэлтэй салшгүй холбоотой тул тухайн үйл ажиллагааны үр дүнд буй болсон хохирлыг мөн бодит буюу материаллаг хохирол тухайлбал хүний амь нас хохирсон, эрүүл мэндэд нь гэмтэл учирсан, түүнчлэн эд хөрөнгийн хохирлууд нь бүгд бодит хохиролд хамаарна. Тэгвэл зан суртахууны, үзэл суртлын, удирдлага-зохион байгуулалтын шинж чанартай хохирлууд нь бодит бус хохиролд хамаарах бөгөөд тэдгээрийн (бодит бус хохиролыг) хохирлын ерөнхий болон төрөлжсөн шинж тэмдгийг тодорхойлох, хэмжих, бэхжүүлж авах зэрэг нь тун нарийн төвөгтэй байдгаар үл барам тодорхой тохиолдолд бараг боломжгүй байдаг.

Иймд хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны явцад учирдаг хохирлыг ч гэсэн мөн бодит буюу бодит бус гэсэн ерөнхий төрөлд хувааж үзэж болох талтай. Бидний явуулсан судалгаанаас үзэхэд хууль эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны явцад учирч буй хохирлын дийлэнх нь (64% нь) бодит бус хохирол байна. Энэхүү хохирлын туйлын ихэнх нь буюу 81%-ийг нь өөрийнхөө ойр төрлийн хүмүүсийн эсрэг гэрчлэх буюу мэдүүлэг өгөхөөс татгалзсан үйлдлүүд эзэлж байна. Үүнээс үзвэл хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг дотор нь:

1. Ерөнхий буюу тусгай төрлийн үйл ажиллагаа гэсэн үндсэн 2 төрөлд хувааж үзэх боломжтой бөгөөд ерөнхий төрлийн үйл ажиллагаа гэдэг нь иргэн нэг бүрт хамаарч болох талтай. Харин тусгай төрлийн үйл ажиллагаа гэдэг нь тодорхой хүмүүст хамаарах юм.

2. Хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг түүний мөн чанар, эрх зүйн зохицуулалтыг нь харгалзан үндсэн хуулийн эрх зүй, иргэний эрх зүйн болон мэргэжлийн үйл ажиллагааны тусгайлсан хэлбэртэй нь холбогдуулж янз бүрийн төрөлд хувааж үзэж болох талтайн дээр уг үйл ажиллагаанд хамаарч байгаа

⁴² Баулин.Ю.В , Обстоятельства исключения преступность деяния / Ю.В.Баулин , 175-р тал./


тодорхой этгээдүүдийн хэрэгжүүлж байгаа ажиллагааг хамаарах хүрээнээс нь шалтгаалж:

- Хүн бүрт хамаарах эрхээ хэрэгжүүлж байгаа ажиллагаа;
- Тусгайлсан эрхээ хэрэгжүүлж байгаа тодорхой хүмүүсийн үйл ажиллагаа;
- Уг үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн мөн чанарыг нь үндэслэж

Үндсэн хуулийн зохицуулалтын шинжтэй буюу түүнийг нь эрүүгийн хуулинд давхар тусгаж баталгаажуулсан үйл ажиллагаа гэж ангилж болох талтай байна.

КРИМИНОЛОГИЙН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ

СОГТУУРСАН, МАНСУУРСАН ЭТГЭЭДИЙГ ЭРҮҮЛЖҮҮЛЭХ, АЛБАДАН СААТУУЛАХ АЖИЛЛАГААНЫ ҮЕД ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ НЬ



С.Хасбаатар

ЭЗНУС-ийн БХБТ-ийн эрхлэгч,
цагдаагийн хошууч, хууль зүйн магистр

(ЦЕГ, ХСИС-ийн хамтарсан “Согтуурсан, мансуурсан хүнийг цагдаагийн алба хаагч албадан саатуулахад учирч буй хүндрэл, эрүүлжүүлэх үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудал” судалгааны ажлын дэд тайлангийн хэсгээс.

Цагдаагийн байгууллага нь Захиргааны хариуцлагын тухай хууль, Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хууль, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам, /код-626/ бусад эрх зүйн актыг баримтлан согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг эрүүлжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Өөрийн үйлдлийг удирдан хянах чадваргүй болтлоо согтсон, хаана байгаа, очих газраа мэдэхгүй болсон, гудамж талбай олон нийтийн газар ухаангүй унасан, энэ байдлаасаа болж гэмт хэрэг, зөрчилд өртөж болзошгүй хүмүүсийг цагдаагийн байгууллага хяналтанд авч, албадан саатуулж эрүүлжүүлэх үйл ажиллагааг явуулдаг байна.

2013 оны 07 дугаар сарын 05-ны өдөр өөрчлөлт орсон “Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хууль”-ийн 5 дугаар зүйлийн 5.1-д: “Өөрийн үйлдлийг удирдан хянах чадваргүй болтлоо согтсоны улмаас хаана байгаагаа болон очих газраа мэдэхгүй болсон, гудамж талбай олон нийтийн газар ухаангүй унасан, энэ байдлаас болж өөрөө осол гэмтэл, гэмт хэрэг, зөрчилд өртөж болзошгүй болсныг үндэслэл болгон цагдаагийн алба хаагч тухайн этгээдийг хамгаалах, тусламж үзүүлэх зорилгоор эрүүлжүүлэх байранд хүлээлгэн өгнө” гэж заажээ.

Одоогийн байдлаар 40 эрүүлжүүлэх байр улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаагаас нийслэлийн 9 дүүрэг болон Төмөр замын цагдаагийн хэлтсийн эрүүлжүүлэх байранд эмэгтэйчүүдийг хүлээн авч нийт 10, хөдөө орон нутагт 30 эрүүлжүүлэх байр үйл ажиллагаа явуулж байна. Улсын хэмжээнд сүүлийн 3 жилд эрүүлжүүлэгдсэн иргэдийн байдлыг авч үзвэл согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсний улмаас гэмт хэрэг, захиргааны зөрчилд холбогдсон болон холбогдож болзошгүй 356.833 хүнийг эрүүлжүүлжээ. Эрүүлжүүлэгдсэн шалтгааныг авч үзвэл 80632 буюу 65.3 хувь нь согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ бусдын амгалан

тайван байдлыг алдагдуулсан, **8160 буюу 6.6 хувь нь** согтууруулах ундаа хэрэглэсний улмаас хаана байгаагаа болон очих газраа мэдэхгүй болсон, **1605 буюу 1.3 хувь нь** гудамж талбай, олон нийтийн газар ухаангүй унасан, 12769 буюу 10.3 хувь нь согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож гэмт хэрэг, захиргааны зөрчилд холбогдсон, 15293 буюу 12.3 хувь нь согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, **4995 буюу 4.2 хувь нь** гэмт хэрэг зөрчилд холбогдож болзошгүй зэрэг шалтгаанаар эрүүлжүүлэгдсэн байна.

Эрүүлжүүлэгдсэн газраар нь авч үзвэл 51725 буюу 41.8 хувь нь гудамж талбайгаас, 58310 буюу 47.2 хувь нь гэр, орон сууцнаас, 4563 буюу 3.6 хувь нь байгууллага, аж ахуйн нэгжээс, 583 буюу 0.9 хувь нь үзвэр үйлчилгээний газраас, 4150 буюу 3.3 хувь нь баарнаас, 1823 буюу 1.4 хувь нь зочид буудлаас, 2300 буюу 1.8 хувь нь бусад газраас тус тус эрүүлжүүлэгджээ.

Батлагдсан орон тоогоор төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн эрүүлжүүлэх байранд нийтдээ эрүүлжүүлэх байрны дарга, эмч 16, эмч 109, цагдаа 209, жолооч цагдаа 26, үйлчлэгч 13 ажиллахаас орон тооны хувьд байнга дутуу үйл ажиллагаа явуулж иржээ.

Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуульд “Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг цагдаагийн байгууллагын хяналтад авч, эмнэлгийн үйлчилгээ үзүүлж, албадан эрүүлжүүлэх” гэж заасан боловч согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг эмнэлгийн бус нөхцөлд, эмчилгээ үйлчилгээ үзүүлэлгүй, ууж согтуурсных нь төлөө эрхийг нь хязгаарлан албадан эрүүлжүүлж байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.6 дах хэсэгт заасан “Монгол Улсын иргэн нь эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй” гэсэн заалтыг зөрчиж байна.

Хуулиар согтууруулах ундаа хэрэглэсэн этгээдийн өөрийн үйлдлээ удирдан хянах чадварыг сэргээх үйл ажиллагааг эрүүлжүүлэх гэж тодорхойлсон боловч цагдаагийн байгууллага хуулиар хүлээсэн чиг үүрэг, мэргэжлийн зүгээс дээрх хуулийн заалтыг хэрэгжүүлэх, хордлого тайлах эмнэлгийн үйлчилгээг зохих ёсоор үзүүлэх, эмчлэх боломжгүй юм. Харин согтуурсаны улмаас гэмт хэрэг зөрчилд холбогдсон, хохирсон, агсан тавьж бусдын амгалан тайван байдлыг алагдуулсан зэрэг нөхцөл байдал үүссэн үед тусгай байранд эмч болон цагдаагийн ажилтны хяналтан доор албадан эрүүлжүүлэх зайлшгүй шаардлага гарч байна.

“Эрүүлжүүлнэ” гэсэн ойлголт нь эрүүл болох, эрүүлших гэсэн утга санааг илэрхийлдэг бөгөөд нэр томъёоны утга агуулга, хүнд үзүүлэх үйлчилгээний талаасаа цагдаагийн байгууллагын гүйцэтгэх үүрэг бус, эрүүл мэндийн байгууллага наркологийн болон хордлогын төвийн нарийн мэргэжлийн эмч, ажилтнуудын хяналт дор хэрэгжих ёстой гэж шинжлэх ухааны үүднээс үздэг.

Дэлхийн нийтийн жишигт “эрүүлжүүлэх” гэдэг ойлголт байдаггүй бөгөөд “Архины хордлого тайлах” /**Detox**/ гэсэн нэр томъёог хэрэглэдэг байна.

Судалгаанаас харахад сүүлийн 3 жилийн байдлаар нийт эрүүлжүүлэгдсэн хүмүүсээс согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож гэмт хэрэг, захиргааны зөрчилд холбогдсон 12769 буюу 10.3 хувь, согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ гэмт хэрэг, зөрчилд холбогдсон 15293 буюу 12.3 хувь, гэмт хэрэг зөрчилд холбогдож болзошгүй **4995 буюу 4.2 хувийг** эзэлж нийт эрүүлжүүлэгдсэн хүмүүсээс 33057 хүн буюу 26.8 хувь нь ямар нэгэн байдлаар гэмт хэрэг, зөрчилд холбогдож эрүүлжүүлэх байранд ирдэгээс цагдаагийн алба хаагчийн тавьсан шаардлагыг биелүүлэхгүй байх улмаар тэдэнд хүч хэрэглэх нөхцөлийг бий болгодог байна.

Архидан согтуурах явдалтай тэмцэх тухай хуулийн зарим заалтыг тайлбарласан УШД-ын 2000 оны 5-р сарын 8-ний өдрийн 151-р тогтоолд: Өөрийн үйлдлийг удирдан жолоодох чадваргүй этгээд гэж “Согтууруулах ундааг тохируулан хэрэглээгүйн улмаас биеэ авч явах чадваргүй болж гудамж талбай олон нийтийн газарт ухаангүй унасан эсвэл хаана байгаагаар болон очих газраа мэдэхгүй болсон, бусдын амгалан тайван байдлыг алдагдуулж гэмт хэрэг үйлдэж болзошгүй болсон эсвэл өөрөө осол гэмтэл, гэмт хэрэгт өртөж болзошгүй хүнийг хэлнэ” гэж тайлбарлажээ.

Харин Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуулийн 5-р зүйлд согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг эрүүлжүүлэх байранд хүргэх үндэслэлийг “Өөрийн үйлдлийг удирдан хянах чадваргүй болтлоо согтсоны улмаас гэр бүлийн буюу бусдын амгалан тайван байдлыг алдагдуулсан, хаана байгаагаар болон очих газраа мэдэхгүй болсон, гудамж талбай, олон нийтийн газар ухаангүй унасан, энэ байдлаас болж гэмт хэрэг үйлдэх, захиргааны зөрчил гаргах, мөн өөрөө осол гэмтэл, гэмт хэрэг, зөрчилд өртөж болзошгүй болсныг үндэслэл болгон цагдаагийн алба хаагч тухайн этгээдийг хамгаалах, тусламж үзүүлэх зорилгоор эрүүлжүүлэх байранд хүргэнэ” гэж заасан байна.

Эрүүлжүүлэх ажиллагааны гол зорилго нь хууль зүйн талаасаа:

Согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэсний улмаас өөрийгөө удирдан жолоодох чадвараа алдах энэ байдлаасаа шалтгаалан гэмт хэрэг, захиргааны зөрчил үйлдэх, осол хэрэгт өртөх, осолдох амь нас, эрүүл мэндээрээ хохирохоос урьдчилан сэргийлэхэд оршино.

Эрүүл мэндийн талаасаа:

Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийн ухаан санааг сэргээх, согтууруулах ундааны үйлчлэл нөлөөлөлийг бууруулах, тухайн этгээдийн хордлогыг тайлах, ухаан санааг нь сэргээх үйл ажиллагаа гэж ойлгодог байна.

“Эрүүлжүүлэх ажиллагааг цагдаагийн байгууллага нь эрүүл ахуйн шаардлага хангасан тусгай зориулалтын байранд 24 цагаас дээшгүй хугацаагаар, ийм байр байхгүй газарт архидан согтуурч, нийгмийн хэв журмын зөрчил гаргаж байгаа этгээдийг амь нас, эрүүл мэндэд нь хохирол учруулахгүйгээр эрүүлжүүлэх арга хэмжээ авна” (Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль-1997 он) гэж заажээ. Энэ заалтаас үзэхэд согтуугаар гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдийн амь нас, эрүүл мэндэд нь хохирол учруулахгүйгээр ямар ч байранд эрүүлжүүлж болохоор байна.

Гэтэл хөдөө, орон нутагт эрүүлжүүлэх ажиллагааг хэрэгжүүлэх нөхцөл, боломж тун хомс байдаг байна. Учир нь хүнийг эрүүл болгох эрүүлжүүлэхийн тулд эмч, сувилагч заавал байх шаардлагатай гэтэл сум орон нутагт тусгай зориулалттай эрүүлжүүлэх байр, эмч байдаггүйгээс хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулахгүйгээр эрүүлжүүлнэ гэдэг аз туршсан хэрэг болжээ.

Энэ байдал нь цагдаагийн алба хаагчаас согтууруулах ундаа хэрэглэж гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдүүдийг удаан хугацаагаар тасаг, хэсгийн байранд өөрөөр хэлбэл зориулалтын бус байранд саатуулах, эрүүлжүүлэх үндэс болж энэ нь цагдаагийн алба хаагчаас хүний эрх, эрх чөлөө, хууль тогтоомжийн заалтыг зөрчихөөс өөр аргагүй байдалд хүргэдэг байна.

Тухайлбал: Сумын цагдаагийн тасаг, хэсэгт эрүүлжүүлэх тусгай зориулалтын байр байхгүйгээс хэсгийн төлөөлөгч, цагдаа нар согтуугаар гэмт хэрэг, зөрчилд холбогдсон этгээдийг албан өрөөндөө эрүүлжүүлдэг.

Энэ тохиолдолд цагдаагийн алба хаагч хүнийг эмчлэх, оношлох тусгай мэдлэг байхгүй учир тухайн этгээд архины хордлогод орох улмаар нас барах, зарим тохиолдолд тухайн эрүүлжигдэж байгаа этгээд цагдаагийн алба хаагчийн таьсан

шаардлагыг эсэргүүцэх, агсан тавих байдал гаргах нь алба хаагчаас хүч хэрэглэх зайлшгүй шаардлагыг бий болгож үүний улмаас тухайн этгээд гэмтэж бэртэх байдал гарч байгаа нь эргээд цагдаагийн алба хаагчийн буруутай үйл ажиллагаа болон хувирч ихэнх тохиолдолд цагдаагийн алба хаагч хуулиар хүлээсэн үүргээ биелүүлснийхээ төлөө эрүүгийн хариуцлага хүлээж гэмт хэрэгтэн болох тохиолдол нилээд гардаг байна.

Эрүүлжүүлэх байранд ажил үүрэг гүйцэтгэдэг алба хаагчдад тохиолддог нийтлэг хүндрэл бол согтуу, өөрийн үйлдлээ хянах чадвараа алдсан үйлчлүүлэгчидтэй байнга харьцаж ажилладгаараа бусад цагдаагийн алба хаагчдаас сэтгэц, физиологийн хувьд хүнд нөхцөлд ажил үүргээ биелүүлдэг. Согтуу хүнийг дуудлагаар очиж авах, эрүүлжүүлэх байранд эрүүлжүүлэх зэрэгт их бага хэмжээний эсэргүүцэлтэй байнга тулгардаг ба энэ тохиолдолд тэдэнд хүч хэрэглэх шаардлага зайлшгүй гардаг байна. Гэтэл үүнийг нарийвчлан журмалсан хууль эрх зүйн зохицуулалт тодорхой бус байна.

Нөгөө талаас согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн боловч гэмт хэрэг зөрчилд холбогдоогүй, хохирогч болоогүй этгээдийг цагдаагийн байгууллагаас эрүүлжүүлэх нэрийн дор саатуулан хорих нь “Хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хүнлэг энэрэнгүй ёсыг эрхэмлэн, хүн амын эрүүл мэндийг хамгаалах” хэмээн Үндсэн хуулийн заалт, “Хүний эрхийн түгээмэл тунхаглал”-ын 3 дугаар зүйлд тунхагласан “Хүн бүр эрх чөлөөтэй, халдашгүй дархан байх эрхтэй” гэсэн заалтыг ноцтой зөрчиж буй үйлдэл болох учраас ийм тохиолдолд цагдаагийн алба хаагчийн тавьсан шаардлагыг биелүүлэхгүй хэмээн тэдэнд хүч хэрэглэх нь хууль зөрчин хүний эрхэд халдаж буй ноцтой үйлдэл болон харагдаж байна. Харин согтсон болон мансуурсан үедээ гэмт хэрэг зөрчилд холбогдсон этгээдийн хувьд цагдаагийн алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэхгүй бол хүч хэрэглэх үндэслэл зайлшгүй үүсэх магадлалтай юм.

Гадаадын зарим орнуудын туршлагаас үзвэл согтуурсан болон мансуурсан этгээдийг эрүүлжүүлэх үйл ажиллагааг тусгай тоноглогдсон байранд болон эмнэлэг, эрүүл мэндийн төвд харин согтуурсан, мансуурсан үедээ гэмт хэрэгт холбогдсон бол орон нутгын шоронд хүлээлгэн өгдөг байна.

АНУ-ын Белмонтын Цагдаагийн газрын журамд:

900.15 Согтуу этгээд

Белмонт хотын цагдаагийн газрын түр саатуулах байр нь согтуу хүмүүсийг байлгах зориулалтгүй. Гэмт хэрэг үйлдсэн саатуулах шаардлагатай согтуу хүмүүсийг Fisrt Chance, San Mateo-ийн орон нутгийн шорон, San Mateo-ийн эрүүл мэндийн төв эсвэл согтуу хүмүүсийг саатуулах тоноглол бүхий байранд хүргэж өгөх ёстой.

Мөн согтуурсан, мансуурсан үедээ зам тээврийн осолд өртсөн жолооч, зорчигчийг албадан согтуурлын зэргийг тогтоох арга хэмжээ авах хэрэв уг этгээдээс энэхүү шаардлагыг биелүүлэхгүй бол хүч хэрэглэж болохыг тодорхой тусгаж өгсөн байна.

514.1 Зорилго, хамрах хүрээ

Согтуурсан эсвэл мансуурсан үедээ зам тээврийн осол гаргасан өөрийгөө удирдах чадваргүй явган зорчигч, жолоочийг баривчилж, тэдгээрийн цусан дахь согтуурлын хэмжээг тогтоохын тулд нотлох баримт цуглуулахад баримтлах журмыг энэ бодлогоор тайлбарлана.

514.26 Цусны дээжийг албадан авах

Согтуурсан үедээ автомашин жолоодон хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд тээврийн хэрэгслийн тухай төрөлжсөн хуулийн 13353 дугаар зүйлд заасан эрхийг нь тайлбарлаж өгсний дараа цусны дээж өгөхөөс татгалзаж байвал түүний цусны дээжийг албадан авч болно.

Зөвхөн доорх нөхцөл байдалд хүч хэрэглэж албадан шинжилгээний дээж авна. Үүнд:

- Сэжигтэй этгээдийг саатуулсан байх ёстой, алба хаагч түүнийг согтуу гэж үзэх хангалттай үндэслэл байх ёстой

- Эмнэлгийн зөвшөөрөгдсөн аргаар цусны дээжийг авах ёстой

- Баривчлагдсан этгээдийн эсэргүүцлийг таслан зогсооход шаардлагатай хүчийг хэрэглэх ёстой

Шинжилгээний дээж өгөхөөс татгалзсан эсвэл хамтран ажиллах сонирхолгүй байгаа сэжигтэй этгээдээс хүч хэрэглэн албадан шинжилгээний дээж авахад алба хаагчийн шууд захирах дарга заавал байлцана. Тухайн этгээдэд тодорхой хүч хэрэглэн шинжилгээний дээж авч байгааг хянаж байгаа дарга доорх хүчин зүйлсийг анхаарч үзэх ёстой. Үүнд:

- (a) Хүнд гэмт хэрэгт баривчлагдсан сэжигтэй этгээдээс үзүүлж байгаа эсэргүүцлийн таслан зогсооход шаардлагатай, тохирсон хүч, хэрэгслийг ашиглахыг зөвшөөрөх.

- (b) Хөнгөн гэмт хэрэгт баривчлагдсан сэжигтэй этгээдийн гарыг ард нь гавалж сандал дээр суулган шинжилгээний дээж авна.

Хэрэв шинжилгээний дээж авч байх үед сэжигтэй этгээд хяналтаас гарч эсэргүүцэл үзүүлбэл түүний үйлдлийг таслан зогсоохын тулд нэмэлт хүч хэрэгсэл ашиглахгүй, эсэргүүцэж татгалзсан тухайг рапортад тэмдэглэнэ.

Эндээс харахад согтуурсан болон мансуурсан этгээдийн согтуурал, мансуурлын зэргийг тогтоох, албадан эрүүлжүүлэх баривчлах үед шаарлагатай бол хүч хэрэглэх ёстой гэдгийг баталгаажуулаад энэ үед нэг талаас хүний эрхийг хангах нөгөө талаас цагдаагийн алба хаагчдын хуулиар олгогдсон эрх, үүргийг хэрэгжүүлэх явцыг баталгаажуулах үүднээс баримтжуулах ажлыг зааврын дагуу хийж байхаар тусгасан байна.

Манай орны хувьд шинээр батлагдан гарсан эрх зүйн актуудад цагдаагийн байгууллагаас согтуурсан этгээдтэй холбоотой дуудлагаар ажиллах үед согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагад хүлээлгэн өгч байхаар тусгагджээ.

Харин тухайн этгээд гэмт хэрэгт холбогдсон буюу ингэж сэжиглэх үндэслэл байгаа тохиолдолд уг этгээдийг цагдаагийн байгууллагын хяналтан дор эрүүлжүүлэх болон албадан саатуулах байранд хүргэх, энэ үед хүч хэрэглэх шаардлага гарахад дагаж мөрдөх хууль, ЭЗ-н зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тавигдсаар байна.

**МАНСУУРУУЛАХ БОЛОН СЭТГЭЦГЭД НӨЛӨӨЛӨХ ЭМ БЭЛДМЭЛ, БОДИСТОЙ
ХОЛБООТОЙ ГЭМТ ХЭРЭГ, ТҮҮНИЙГ ХЭРЭГЛЭСЭН ЭТГЭЭДИЙГ
ТОГТООХОД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ**



Г.Бямбадорж

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн, ЦЭЗТ-ийн
ахлах багш, магистр, цагдаагийн ахмад

Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл бодисыг хэрэглэх явдал нь газар авч хүн амын эрүүл мэндэд төдийгүй, улс орны язгуур эрх ашиг, сонирхолд хор хөнөөл учруулж үндэсний аюулгүй байдал алдагдах хэмжээнд хүрснийг цаг үе бидэнд сануулж байна.

НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албанд дараах төрлийн мансууруулах бодисыг хэрэглэж байгаа дүн мэдээ байна. Каннабис хэрэглэдэг 166.5 сая хүн, Амфетамины төрлийн сэргээх үйлчилгээтэй бодис хэрэглэгч 33.7 сая хүн, Экстази хэрэглэж байгаа 24.7 сая хүн, Опиум хэрэглэж байгаа 16.5 сая хүн, Геройн - 12 сая хүн Кокайн 16 сая хүн хэрэглэж байгаа тухай тус тус бүртгэгдсэн байна.

Монгол улсад дээр дурьдагдсан мансууруулах төрлийн бодисуудаас геройноос бусад төрлийн бодис хэрэглэгдэж байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд мансууруулах бодис хэрэглэгчдын тоо өссөөр байгааг Хар тамхи, мансуурлаас иргэдийг хамгаалах нийгэмлэгээс болон бусад төрийн, төрийн бус байгууллагууд анхааруулсаар байгаа билээ.

Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл бодистой холбоотой гэмт хэргийн талаар авч үзэхийн өмнө энэ төрлийн гэмт хэргийн бүрэлдэхүүний талаар авч үзэх нь зүйтэй.

Монгол Улсын Эрүүгийн Хуулийн 1-р зүйлийн 1.1 дэх хэсэгт Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон хувийн өмч, үндэсний баялаг, байгаль орчин, эрх зүйн журам, энх тайван, хүн төрлөхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалахад оршино⁴³. Гэж зааснаас үзэхэд иргэний амьд явах, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх нь Монгол Улсын Үндсэн Хууль, Эрүүгийн хууль болон бусад хууль тогтоомж, эрх зүйн актуудаар зохицуулагдаж, хамгаалагдаж байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг гэсэн хорин хоёрдугаар бүлэгт заасан хүний эрх, эрх чөлөөг сахин хамгаалах үйлажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгтэй тэмцэхэд олон нийтийн тусламж дэмжлэг авах, тэдний үүрэг оролцоог нэмэгдүүлэх зэрэг шат дараатай олон олон арга хэмжээг авах шаардлагатай байна.

Монгол Улсын Эрүүгийн Хуулийн тусгай ангийн 192-р зүйл “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэр, илгээх, борлуулах”, 193-р зүйл “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг үйлдвэрлэх, бэлтгэх журам зөрчих”, ЭХ-ийн 194-р зүйл “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар авах”, 195-р зүйл “Мансууруулах бодис агуулсан ургамлыг тарих, ургуулах, хураан авах” гэмт хэргийн бүрэлдэхүүний талаар товч авч үзье.

Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг гэж: Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодис бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх,

⁴³ “Монгол улсын эрүүгийн хууль” Төрийн мэдээлэл, 2002 он №05

үйлдвэрлэх, хууль бусаар олж авах, мансууруулах бодис агуулсан ургамал тарьж ургуулах, хураан авах, хууль бус эмчилгээ, эмийн сангийн ажиллагаа эрхлэх, тахал болон гоц халдварт бусад өвчинтэй тэмцэх журам зөрчих, хүчтэй үйлчлэх, хорт бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, тээвэрлэх, борлуулах, орчиндоо аюул учруулж болох амьтныг хамгаалалтгүй байлгах зэргээр хүн амын эрүүл мэнд, нийгэмд хор аюул учруулах эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ.

Монгол Улсын эрүүгийн Хуулийн тусгай ангийн 192-р зүйл “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах гэмт хэргийн Объект: Нийгмийн аюулгүй байдал, хүн амын эрүүл мэнд, байгууллагын хэвийн ажиллагаа байна.

Халдлагын зүйл: Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодис

Сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл, бодис гэж: Тодорхой тоо чанарын шинжтэй материаллаг объект бөгөөд ийм эм, бэлдмэл бодис болохыг эмнэлгийн шинжээчийн шинжлэн магадлах үйл ажиллагаа явуулж дүгнэлтээр тогтооно. Ийм бодис биш бол энэ гэмт хэргийн халдлагын зүйл болохгүй юм.

Сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл бодист НҮБ 1988 оны, Сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл, бодисыг хууль бус эргэлтийн эсрэг конвенц, ийм бодисын тухай конвенцид зааснаар 14 нэр төрлийн, тухайлбал, амобарбитал, фенметразин, пентабарбитал, декстрометорфан, ципепрол, кетамин, этаминал натри зэргийг хамааруулан ойлгодог.

Эдгээр бодис нь хүнийг төв мэдрэлийн системд өвөрмөц нөлөөлөл үзүүлж байвал тэр нь эмнэлгийн шалгуур болно. Тухайн бодисыг хэрэглэсэн хүний уураг тархи, төв мэдрэлийн системд нь давамгайлан үйлчилж мансуурал хэмээх сэтгэцийн өвчин үүсгэдэг үйлчилгээ, нөлөөлөл үзүүлдэг.

Объектив тал: Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг борлуулах зорилгогүйгээр хууль бусаар бэлтгэсэн үйлдэл байна.

Борлуулах зорилгогүйгээр хууль бусаар бэлтгэсэн гэдэг нь: Байгалийн гаралтай /намуу цэцэг/. Зэрэг ургамлаас болон химийн найрлагатай эм, бэлдмэлээс зориуд гарган авахыг хэлнэ.

Хууль бусаар олж авсан гэдэг нь: Худалдаж авах, хулгайлах, булаах, дээрэмдэх, залилан мэхлэх болон бусад гэмт хэрэг үйлдэх замаар өөрийн эзэмшилд авах үйлдэл юм. Энэ тохиолдолд цааш нь борлуулах зорилгогүй байна.

Хууль бусаар хадгалсан гэж: Хууль бус, нууц далд аргаар олж авсан, бэлтгэсэн дээрх эм, бэлдмэл, бодисыг өөрийн гэр орон, бусад газарт нууц байдалд байлгахыг хэлнэ. Энэ нь үйлдэл хийснээр төгсдөг хэлбэрийн бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг юм.

Субъектив тал: Шууд санаатай, борлуулах зорилгогүй байна.

Субъект: 16 насанд хүрсэн этгээд байна.

Хүндрүүлэх бүрэлдэхүүн:

Объект: Хүн амын эрүүл мэнд, байгууллагын хэвийн ажиллагаа

Объектив тал: Дээр дурдсан бодис, эм, бэлдмэлийг борлуулах зорилгоор хууль бусаар бэлтгэсэн олж авсан, хадгалсан, тээвэрлэсэн үйлдэл байна.

Тээвэрлэх гэдэг нь: Дурьдсан зүйлийг өөр улс, нэг улсын нутгийн захиргааны нэгжид худалдах, борлуулах зорилгоор тээврийн хэрэгслээр /галт тэрэг, машин/ явуулахыг ойлгоно.

Илгээх гэж: Шуудангийн боломжийг ашиглан хууль бусаар /нууцаар/ илгээмж, илгээлт, багажид хийж нэг газраас нөгөө газарт /гадаад, дотоод/ явуулахыг ойлгоно.

Борлуулах гэж: Аливаа аргаар үнэ төлбөртэйгээр бусдад шилжүүлэх /худалдах, бэлэглэх, бусад эд бараагаар сольж авах, өрөнд өгөх, зээлдэх үйл ажиллагаа юм.

Субъектив тал: Санаатай, борлуулах зорилготой

Субъект: 16 насанд хүрсэн этгээд байна.

Онц хүндрүүлэх бүрэлдэхүүн:

ЭХ-ийн 192.2-т заасан хэргийг онц их хэмжээгээр гэдгийг эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 29 дүгээр зүйлд заасан жишиг болон шинжээчийн дүгнэлтээр тогтоохын хамт хүний бие организмд нөлөөлөх хүчин, нөлөөллийн мөн чанарыг харгалзана. Тухайлбал: ОХУ-ын Шүүхийн практикт марихуан хатаасан -0.1-100 гр, гашиш - 0.1-100 гр, каннабисын давирхай 40 гр хүртэл, хар тамхи 0.1-10 гр, морфин 0.01-1 гр, героин - 0.005 гр, кокейн 0.2-10 гр, промедол -0.03-3 гр, фенимин - 3 гр, эфедрон 0.02-3 гр, кокаин 0.01-1гр хүртэлх хэмжээгээр жишиж үнэлдэг.

Уг гэмт хэрэгт насанд хүрээгүй хүн оролцуулж, онц аюултай гэмт хэрэгтэн, давтан урьдчилан үгсэж тохиролцсон буюу зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн бол ял хүндрүүлэх нөхцөл байдал болно.

Субъект: Албан тушаалтан байна.

Зүйлчлэлийн асуудал: Субъектын үйлдлийг ЭХ-ийн ТА-ийн 192.1-р зүйлчлэхэд тухайн бодисыг борлуулах зорилгогүйгээр хууль бусаар бэлтгэсэн, олж авсан, хадгалсан байхыг, харин 192.2-оор зүйлчлэхэд заавал борлуулах зорилгоор дурдсан үйлдлүүдийг хийдэг болохыг тогтоох шаардлагатай.

Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг борлуулах зорилгогүйгээр бага бус хэмжээгээр хууль бусаар бэлтгэсэн, олж авсан, хадгалсан. Өөрөөр хэлбэл субъект өөрийн хувийн хэрэгцээнд зориулсан байвал захиргааны хариуцлага хүлээлгэх нь зүйтэй.

Хэн нэгэн этгээд бусад этгээдээс түүний гүйлт, хүсэлтээр дээр дурдсан бодисыг хадгалахаар авсан нь энэ зүйлд заасан гэмт хэрэг болохгүй.

Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар Монгол улсын гаалийн хилээр нэвтрүүлсэн бол ЭХ-ийн ТА-ийн 192.2-ыг 188.2-той давхар зүйлчлэн хариуцлага хүлээлгэнэ.

Иргэний мөнгө, эд хөрөнгийг авах зорилгоор мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисыг зарж борлуулсан бол залилан мэхлэх гэмт хэргээр, харин худалдан авагчийн үйлдлийг ийм бодис олж авахаар завдсан гэж ЭХ-ийн 32-ыг журамлан борлуулах зорилготой байсан эсэхийг харгалзан ЭХ-ийн ТА-ийн 192 дугаар зүйлийн холбогдох хэсгээр зүйлчилнэ.

Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэлийг хээл хахуулийн халдлагын зүйл болгон өгч авалцсан бол хээл хахууль авагчийн үйлдлийг ЭХ-ийн ТА-ийн 268 дугаар зүйлийн холбогдох хэсэг 192.1 олж авсан өгөгчийн үйлдлийг дээрх бодисыг борлуулсан гэж ЭХ-ийн ТА-ийн 192.2, 269 дүгээр зүйлээр давхар зүйлчилнэ.

Монгол Улсын Эрүүгийн Хуулийн 193-р зүйл Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл бодисыг үйлдвэрлэх, бэлтгэх журам зөрчих гэмт хэргийн бүрэлдэхүүний Объект: Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг үйлдвэрлэх, бэлтгэх журам.

Халдлагын зүйл: Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодис үйлдвэрлэхэд хэрэглэгддэг бодис, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл.

Объектив тал: Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодис, тэдгээрийг үйлдвэрлэхэд хэрэглэгддэг бодис, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг үйлдвэрлэх, бэлтгэх, боловсруулах, хадгалах, бүртгэх, худалдах, хуваарилах, тээвэрлэх, улсын хилээр нэвтрүүлэх устгах журмыг зөрчсөн идэвхтэй үйлдэл, эс үйлдэхүй байна. Дээр дурьдсан үйлдлүүдийн аль нэгийг хийснээр гэмт хэрэг төгс үйлдэгдсэнд тооцогдоно.

Субъектив тал: Санаатай, шунахай сэдэлтэй, Субъект: 16 насанд хүрсэн хэрэг хариуцах чадвартай этгээд байна.

Монгол Улсын Эрүүгийн Хуулийн 194-р зүйл Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл, бодисыг хууль бусаар авах гэмт хэргийн Объект: Нийгмийн

аюулгүй байдал, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисуудыг хууль ёсоор өмчлөгчийн эрх байна.

Халдлагын зүйл: Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл, бодис

Объектив тал: Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хулгайлах

булаах, дээрэмдэх, залилан мэхлэх, завших зэргээр хууль бусаар авсан идэвхтэй үйлдэл байна.

Субъектив тал: Санаатай, шунахай сэдэлттэй байж болно.

Субъект: 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай этгээд байна.

Хүндрүүлэх бүрэлдэхүүн:

Энэ хэргийг их буюу онц их хэмжээгээр үйлдсэн, мэргэжлийн болон албан тушаалын байдлаа ашиглаж үйлдсэн, давтан үйлдсэн, бүлэглэж үйлдсэн, урьд нь энэ төрлийн гэмт хэрэгт шийтгүүлсэн этгээд үйлдсэн бол ялыг хүндрүүлэх нөхцөл байдал болно.

Монгол Улсын Эрүүгийн Хуулийн тусгай ангийн 195-р зүйл Мансууруулах бодис агуулсан ургамлыг тарих, ургуулах, хурааж авах гэмт хэргийн Объект: Нийгмийн аюулгүй байдал, хүн амын амь бие, эрүүл мэнд.

Халдлагын зүйл: Мансууруулах бодис агуулсан ургамал, Объектив тал: Мансууруулах бодис агуулсан ургамлыг тарьсан, ургуулсан, хурааж авсан үйлдлүүдийн аль нэг нь байна.

Субъектив тал: Санаатай. Өөрийн хэрэгцээнд хэрэглэх, зарж борлуулж ашиг олох сэдэлттэй хэлбэрийн бүрэлдэхүүнтэй байна. Субъект: 16 насанд хүрсэн хэрэг хариуцах чадвартай этгээд байна.

Монгол Улсын Эрүүгийн Хуулийн тусгай ангийн 196-р зүйл Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх бодисыг хэрэглэх газар зохион байгуулах гэмт хэргийн бүрэлдэхүүний Объект: Хүмүүсийн, ялангуяа залуучуудын эрүүл мэнд, ёс суртахуун байна.

Халдлагын зүйл: Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис

Объектив тал: Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх бодисыг хэрэглэх байр байгуулснаар гэмт хэргийн бүрэлдэхүүн төгсөнө.

Субъектив тал: шууд санаатай, хөнгөн хялбар аргаар ашиг олох гэсэн зорилготой.

Субъект: 16 насанд хүрсэн этгээд байна.

Хүндрүүлэх бүрэлдэхүүн:

Энэ хэргийг зохион байгуулалттай бүлэг, бүлэглэл үйлдсэн бол ялыг хүндрүүлэх нөхцөл болно.

Зүйлчлэлийн асуудал:

Мансууруулах бодис агуулсан опиум, намуу цэцэг, олсны ургамал болох конопля, каннабис, цайвар болон шар хурган засаа, хар лантанз зэрэг ургамлыг зориуд тарьж, ургуулж хурааж авсан бол энэ зүйлд заасан гэмт хэрэг болно.

Дээр дурдсан бодисыг нууцаар хэрэглэх боломж бүрдүүлэх зорилгоор зочид буудал, баар, цэнгээний газар, дэн буудал, караоке зэрэг үйлчилгээний газрын үйл ажиллагаагаар халхавчлан мансууруулах бодис хэрэглэдэг тусгай газар бий болгох, тусгай байр бий болгож тоноглогсон бол ЭХ-ийн ТА-ийн 196-р зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргээр зүйлчилнэ.

Энэ төрийн гэмт хэргийн өнөөгийн байдал:

Мансууруулах бодис хэрэглэгчид жилээс жилд нэмэгдэж буйг зөвхөн судалгаанаас бус энэ төрлийн гэмт хэрэгт холбогдогчдын тооноос харж болно. Цагдаагийн байгууллагын өгсөн мэдээллээр 1995-2005 онд хар тамхи, мансууруулах бодистой холбоотой мансууруулах болон сэтгэлцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг

хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, хурааж авах үйлдэлтэй 63 гэмт хэрэг цагдаагийн байгууллагад бүртгэгдэж хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд 152 хүн сэжигтэн яллагдагчаар татагдаж байжээ.

Харин сүүлийн 5 жилд энэ төрлийн 26 гэмт хэрэгт 64 хүн ял шийтгүүлжээ. 2007 онд 3 гэмт хэрэгт 16 хүн ял шийтгүүлж байсан бол 2010 онд 14 гэмт хэрэгт 27 хүн ял шийтгүүлсэн байна. 2002-2009 онд буюу найман жилийн хугацаанд нийт 63 гэмт хэрэгт 68 үйлдэлд 184 хүн холбогдон шалгагджээ.

Харин 2009 оноос энэ төрлийн гэмт хэрэг түүнд холбогдогчдын тоо жил бүр өсч 2014 оны эхний гурван сарын байдлаар 133 гэмт хэрэгт 365 үйлдэлд 460 хүн холбогдон шалгагдсан байна.

2010 оноос хойш бүртгэгдсэн гэмт хэргийг 2002-2009 оны дундажтай харьцуулж үзэхэд үйлдэл нь 7.6 дахин, холбогдогч нь 5.3 дахин өссөн үзүүлэлттэй гарчээ⁴⁴.

Мансууруулах бодистой холбоотой хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн практикийг судлаж үзвэл: Мансууруулах бодис хууль бусаар хил нэвтрүүлсэн хэрэгт ял шийтгүүлсэн 5 хүн тутамын 1 нь мансууруулах үйлчилгээ бүхий олсны ургамал \Тетра гидро каннабинол\ бодис агуулсан, хагас боловсруулсан бэлдмэлийг бусдад борлуулах зорилгоор Бээжин хотод бусдаас худалдан авч, Монгол улсад оруулж ирсэн гэж мэдүүлсэн байна.

Харин бусад шүүгдэгчид мансууруулах үйлчилгээ бүхий ургамлыг Монгол улсын нутаг дэвсгэрээс олж авсан, тухайлбал: Орхон, Дархан-Уул, Сэлэнгэ, Дорнод, Ховд, Төв аймгийн нутгаар ургадаг олсны төрлийн мансууруулах бодисын агууламжтай ургамлыг түүж хатааж хэрэглэх, түүнээсээ бусдад өгөх, худалдаалах зэргээр гэмт хэрэг үйлджээ⁴⁵.

Манай улсын иргэдээс гадаад оронд энэ төрлийн гэмт хэрэгт холбогдогсод 2012 оны 1 дүгээр сарын байдлаар ОХУ-д 3, Казакстанд 1, Унгарт 2, Бангладеш, Малайз улсад тус тус 1, Хятад улсад 40 монгол иргэн энэ төрлийн гэмт хэрэгт холбогдож 4 хүн цааазын ялаар шийтгэгдэж, 1 хүн хугацаагүй хорих ял сонсож, 7 хүн 15 жил, 6 хүн 6-10 жил, 1 хүн хэрэг шалгах явцад амиа хорлож 21 Монгол Улсын иргэн шүүхийн шийдвэр хүлээж байна.

2007-2011 онд нийт ял шийтгүүлэгчдийн 75 хувь нь 19-30 насны залуучууд байсан бол ял сонссон иргэдийн 69 хувь нь бүрэн дунд боловсролтой, 22 хувь нь дээд боловсролтой хүмүүс байна. Тодруулбал, ялтнуудын 22 хувь нь оюутан. Харин 30 хувь нь эрхэлсэн тодорхой ажилгүй иргэд байлаа.⁴⁶

Мөн энэ төрлийн гэмт хэрэг ихсэж байгааг лабораторын шинжилгээ хийдэг байгууллагуудын судалгааны тоо баримтаас харж болно. Гаалийн лабораторид сүүлийн 2 жил нийт 60 гаруй тохиолдол шинжлэхэд 8 нь хар тамхитай холбоотой байж, хуулийн байгууллагуудаас тодорхой сэжиг бүхий бодисыг гаалийн лабораторид шинжлүүлэхэд 40 орчим хэрэг илэрсэн. Жилд дунджаар 40 шинжилгээ хийдэг байсан ШШҮХ-ийн криминалистикийн хэлтсийн лабораторид сүүлийн жилүүдэд хар тамхи, тэр дундаа нийлэг /синтетик/ гаралтай хар тамхи мансууруулах бодисын шинжилгээ эрс өсөж өнгөрсөн жил 120 шинжилгээ хийсэн⁴⁷ нь энэ төрлийн гэмт хэрэг ихэссэнийг батална.

Манай хойд хөршийн иргэд хар тамхины хэрэглээгээрээ дэлхийд хоёрдугаарт бичигддэг бол БНХАУ-д гурван сая хүн хар тамхинд донтож байнга хэрэглэдэг гэсэн судалгааны тоо баримт байдаг нь манай улсад мансууруулах бодис, сэтгэцэд

⁴⁴ Улсын Дээд Шүүхийн Судалгааны төвөөс гаргасан судалгааны тайлан, 2012 он

⁴⁵ Цагдаа судлал сэтгүүлийн 2012 оны №4 92 дахь тал

⁴⁶ www.olloo.mn/modules.php?name...file

⁴⁷ ШШҮХ-ийн химийн лабораториас гаргасан дүн мэдээ

нөлөөлөх эм бэлдмэлтэй холбоотой гэмт хэрэг үйлдэгдэх явдал өсөн нэмэгдэх шалтгаан болж улмаар мансууруулах бодис сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл дамжин өнгөрөх, шинэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэх, гэмт хэргийн урсгал орж ирэх, уг бодисийг хэрэглэх явдал газар авах өндөр эрсдэлд орох нь дамжиггүй.

Манай улс одоогоос хэдэн жилийн өмнө дамжин өнгөрөгч орны тоонд багтдаг байсан бол одоо хэрэглэгч орны тоонд орж, Азиас гаралтай хар тамхины урсгал, худалдааны гол замууд манай улсыг дайран өнгөрч байна.⁴⁸

Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл нь овор хэмжээ төдийлөн их биш байдагтай холбоотойгоор уг бодисийг ямар ч зүйл бараан дотор хийх, биедээ болон хувцас, цүнхнийхээ халаасанд нуух, хүнсний бүтээгдэхүүний хуурамж сав, баглаа, боодол, шошго ашиглан нуух, түүнчлэн тээврийн хэрэгсэл, ачаа, баараа, хүний бие, шуудан илгээмж, захидал зэрэгт нуух зэрэг аргуудыг хэрэглэж байгааг анхаарч мансуурах бодис сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлтэй холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх бодлого, үйл ажиллагааг сайжруулж, улсын хилээр мансуурах бодис сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэрэгтэй тэмцэх арга ажиллагааг үндсээр нь өөрчилж, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд шинжлэх ухааны ололт амжилт, орчин үеийн техник технологи ашиглах зэргээр энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх үйл ажиллагаанд инноваци нэвтрүүлж ашиглах цаг нэгэнт болжээ.

Тухайлбал: Шинжилгээ, судалгаанд ашиглагдах мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын импортлох зөвшөөрлийг жилийн хэрэгцээний урьдчилсан тооцоог үндэслэн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгож байгааг өөрчилж энэхүү зөвшөөрөлийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас авдаг болгох зэргээр эрх зүйн зохицуулалтанд өөрчлөлт хийж болох юм.

Хүүхэд, залуучуудад мансууруулах бодис хэрэглэх сонирхол, сэдэл төрүүлэхэд сөргөөр нөлөөлж буй зүйлийн нэг нь интернэт сүлжээний мэдээлэл, гадаадын болон дотоодын мэдээллийн сайтуудын мэдээлэл, хэвлэл мэдээллийн хэрэгслээр гаргаж байгаа кино зэрэг нь мансууруулах бодис хэрэглэсэн хүн сэтгэлийн шаналгаа, өвчин зовлонгоос ангижирч байгаа мэт сэтгэгдэл төрүүлдэг нь тэднийг мансууруулах бодис хэрэглэхэд хүргэдэг байна.

Ийм учраас хэвлэл мэдээллийн хэрэгслийн хэт задгай байдал, интернэтийн хяналтгүй байдалд хяналт тогтоож, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлж, хүүхэд залуучдад мансууруулах бодис хэрэглээд амьдралаа алдсан хэн нэгнээр жишээ татаж ярилцлага хийх гэх мэт нээлттэй бусдад сургамж болохуйц нэвтрүүлэгүүдийг бэлтгэж хийснээр хүүхэд залуучууд ухаарна⁴⁹.

Мансууруулах бодис хэрэглэж болохгүй гээд яриад байхаар яагаад болохгүй гээд байгаа юм бол, хэрэглээд үзье гэсэн сонирхолдоо хөтлөгдөн хэрэгсэлээр байгаад мансууруулах бодисийн хамааралтай хүн болж хувирч байна.

Тэрчлэн эрдэм шинжилгээ судалгааны ажилд ашиглах мансууруулах төрлийн бодис, эм бэлдмэлийг улсын хилээр нэвтрүүлэх, түүний ашиглалт, зориулалт, тээвэрлэлт, зарцуулалтанд хяналт тавих тогтолцоог сайжруулах шаардлагатай.

Түүнээс гадна эмчийн жороор олгодог сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийг тохируулж олгоогүйгээс илүү тунгаар авах явдал гарч байгааг анхаарч сэтгэцэд

⁴⁸ www.olloo.mn/modules.php?name...file

⁴⁹ Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх асуудал ОУЭШХ-ын эмхтгэл. 20-р тал.

нөлөөлөх эм бэлдмэл бодисийг эмчлүүлэгчийн өвчний үе шат, биеийн байдал зэрэгт тохируулж олгох хэрэгтэй байна.

Илрүүлэх ажиллагаа:

Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой мэдээллийг шалгах, гэмт хэрэгтнийг илрүүлэх, гэмт хэргээс урдчилан сэргийлэх ажиллагааг амжилттай зохион байгуулах нэг гол хүчин зүйл нь цагдаагийн байгууллагын ажилтнууд мансууруулах бодис хэрэглэсэн хүнд илрэх шинжийг мэдэх, тухайн бодис ургамлыг таньж байх явдал юм.

Төв орон нутгийн цагдаагийн газар хэлтсийн нийт 80 албан хаагч нарын дунд судалгаа явуулахад судалгаанд оролцогчид мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл, бодисыг хараад таних эсэх? гэсэн асуултанд 24 буюу 30% нь танина гэж хариулсан бол 56 буюу 70% нь танихгүй гэж хариулсан нь судалгаанд хамрагсдын дийлэнхи нь дээрх бодисыг хараад танихгүй гэсэн нь энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх ажилд сөрөг нөлөө үзүүлж байна.

Тиймээс энэ төрлийн гэмт хэрэгтэй холбоотой мэдээллийг хамгийн түрүүнд хүлээн авч шалгадаг цагдаагийн байгууллагын ажилтнууд нэн түрүүнд мансууруулах бодис мөн эсэхийг тогтоох, улмаар нотлох баримт болгон хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд ашиглах үндсийг бүрдүүлж чаддаг байх ёстой.

Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой мэдээллийг шалгах, мансууруулах бодис хэрэглэсэн эсэхийг тогтоохдоо дараах нийтлэг, энгийн болон бусад аргуудыг ашиглах боломжтой. Үүнд:

Энгийн аргаар: Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэн мансуурлын төлөвт байгаа эсэхийг энгийн аргаар тогтоож болно. Ингэхдээ уг хүнийг шулуун шугам дагуулж алхуулан тэнцвэрээ хэр олж байгааг тогтоох, хөндлөн, нарийхан саадан дээгүүр алхуулан хөдөлгөөний баримжаагаа хэрхэн удирдаж байгааг хянах, цаг хэдий болж байгааг буюу, тодорхой газарт хир удаан байж байгаа болох зэрэг асуулт асуун шалгаж энэ тухай тэмдэглэл үйлдэнэ.

Мансуурсан төлөвт байгаа хүн тэнцвэрээ олохгүй гуйвах, хөдөлгөөний баримжаагаа алдсаны улмаас нарийхан зүйл дээгүүр том алхах, цагийн баримжаа алддаг зэрэг тул боломжтой бол энэ ажиллагааг дүрс бичлэгийн төхөөрөмжөөр бэхжүүлнэ. Бие, хувцас, эд зүйлд мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис, ургамлын зүйл, тамхи, тариур зэрэг хэрэгсэл байгаа эсэхийг шалгах.

Шаардлагатай тохиолдолд мансуурсан хүнд эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх арга хэмжээ авна. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисыг хэрэглэсэн сэжиг бүхий хүн байвал Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1.6-д зааснаар шалгах ба мөн зүйлийн 1.5-д шинжилгээнд цус, шээсний дээж авч болно.

Онцлог байдлаар: Сэтгэцэд нөлөөлөх, мансууруулах эм бодис хэрэглэсэн хүний нүдний хүүхэн хараа томорсон, гэрлийн тусгалд урвал өгөхгүй байх, сэтгэцийн байдлын онцлог, хэл яриа, хөдөлгөөний хэмнэл алдагдсан шинж илэрдэг. Тухайлбал: Сэтгэцэд нөлөөт эм бэлдмэл хэрэглэсэн үед хэт хөөрөл, сэтгэл санааны хямрал, уналтад орсон байдаг.

Сэтгэцэд нөлөөлөх, мансууруулах эм бодис хэрэглэсэн байж болзошгүй этгээдийн биеийн хэсэгт тариурын ором байгаа эсэхийг шалгана. Сэтгэцэд нөлөөлөх, мансууруулах эм бодис хадгалсан байж болзошгүй хүн эд зүйл, ачаа тээшинд үзлэг, нэгжлэг хийхдээ албаны нохойг ашиглах.⁵⁰

Үзлэг, шалгалт хийх явцад хүмүүсийг ажиглах: Үзлэг, шалгалт хийх явцад хүмүүсийн байдал төрхийг сайтар ажиглаж байх нь нэн чухал байдаг. Учир нь

⁵⁰ “Цагдаагийн Байгууллагын Үйл Ажиллагааны Журам” Код-119

хүмүүс тулгамдаж, цочирдсон үедээ тайван байхдаа хэзээ ч гаргахааргүй, өөрийгөө санаандгүй илчилсэн хариу үйлдлийг үзүүлдэг.

Үзлэгийн бүхий л үед ажиглаж, хүний догдолсон шинжийг таньж чаддаг байх нь ч бас чухал. Үзлэг хийж буй орчны эзэн, шалгуулж буй хүнийг байнга ажиглаж, асуулт асуун, царайг ажиглаж, тухайн хүн түгшиж байгаа эсэхийг мэдэж болно.

Үзлэг хийж буй үед хориотой зүйл, хулгайн бараа, мансууруулах бодис зэргийг нуусан газраас хол байхад хүн тайван байж, тийм газар руу дөхөх буюу очих үед сандарч мэгдсэн төрх илрэх нь олонтаа тохиолдоно.

Хууль бус үйлдэл хийсэн хүнд түгээмэл илрэх шинжийг олж ажиглах:Өөрт таараагүй, тухайн улиралд тохироогүй хувцас өмссөн байх. Жишээ нь дулаан үед зузаан хувцас өмссөн, эсвэл томдсон хувцас өмссөн гэх мэт.

Нарны шил байнга зүүх, шалгуулж буй болон үзлэг хийлгэж буй хүн хөлрөх, догдолсон шинж илрэх. Жишээлбэл энгийн асуултад илт уцаарлаж хариулах, хөдөлгөөний идэвхи нэмэгдэх, илүү хөдөлгөөн хийх, уцаарлах, сааталд орох, яарах буюу удаашрах хөдөлгөөн.

Шалтгаангүй, илүүц инээх, хэт найрсаг байх, сэтгэл дундуур шинж үзүүлэх, жижиг зүйлд анхаарлаа хурцаар хандуулах, саймширч, яриаг дэмжин тал засах, үг хөдөлгөөн хоёр зөрөх. Жишээлбэл: Үгүй гэсэн мөртлөө толгой дохих эсвэл эсрэгээр, толгой өвдөх мэтийн өвчин хэлж баашлах, улмаар эмнэлгийн тусламж дуудах, шалгуулж буй хүн үзлэгийн үед биеэ авч явах төлөв өөрчлөгдөх, цухалдах, хариу үйлдэл үзүүлэхээ болих, дуугаа хураах гэх мэт.

Зогсолтгүй чалчих, хэт олон асуулт асуух, юмаа унагах зэргээр үзлэг хийж байгаа ажилтнуудын анхаарлыг сарниулахыг оролдох, юмаа мартах дүр эсгэх. Жишээлбэл, түлхүүрээ олохгүй байна гэх мэт.

Гадна төрх байдлаар: Харц тогтохгүй, орчны зүйлсийг гүйлгэн харах, тааз ширтэх, нүд салгахгүй ширтэх зэрэг олон янзаар илэрдэг. Харц тогтохгүй байх нь санал үл нийлсэн, идэвхигүй байгаагийн шинж. Асууж байгаа хүнээсээ харцаа буруулах, уйдсан шинжтэйгээр эргэн тойрныг харах, Хөмсөгөө өргөх, зангидах зэрэг нь сэтгэл дундуур, айсныг илэрхийлнэ.

Харц нь нэг газраа тогтохгүй байх, шал ширтсэн доошоо харах, нүдээ байн байн анивчих, нүдний хүүхэн хараа үе үе томрох нь стресстэй, байнга өргөссөн байдал нь мансууруулах бодис хэрэглэснийх, хацраа алгадах нь өөрийгөө тайвшруулж байна,уруулаа хазах, амаа мурийлгах, зажлах уруул нь хатсанаас болоод байн байн долоох, ус гуйх, цагаа олоогүй байн байн инээх, удаан инээх, байн байн шүлсээ залгих, хүнд нөхцөл байдал дахь хариу үйлдэл, зүрхний цохилт хурдсах, хүзүү, дух, шанааны судасны цохилт илт мэдэгдэх, толгойгоо доош нь тонгойлгох, амьсгал хүндрэх, амьсгал нь дуу чимээтэй гарах, нүүрний булчингууд хатуурч эхлэнэ.

Гар, хурууны хөдөлгөөн түргэсэх, хумсаараа оролдох, гар болон хураагаа илэх, гараа базлах, атгах, зангидах, үнэт эдлэл, бие болон хувцасаа үрэх, хувцаснаасаа үс, ноос хялгас түүх, биеийнхээ аль нэг хэсгийг маажих, алгадах, илэх, арчих, үсээ самнах, илэх зэрэг нь өөрийгөө тайвшруулж байгаа хөдөлгөөн байдаг.

Дуу хоолой тухайн хүний сэтгэлийн хөдөлгөөн, юу мэдэрч байгаа, тухайн асуудалд яаж хандаж байгаа зэргийг эргэн тойрныхонд нь нэлээд тодорхой хүргэж чаддаг бөгөөд хүний зан байдал, темпераментын шинжийг ч илэрхийлнэ.

Хүний сэтгэл хөдлөлийг түүний хоолой илэрхийлээд зогсохгүй айдас, түгшүүр төрөх үед хоолойн өнгө өөрчлөгддөг. Эгзэгтэй зүйлийг асуух үед хүний дууны өнгө өөрчлөгдөх, хоолой чичрэх, дуу гарахгүй болох, хэт чанга гарах зэрэг нь түүний дотоод сэтгэлийн хямралыг харуулдаг. Хоолой чичрэх, хоолойн өнгө

өөрчлөгдсөн зэргээ хаацайлж хүмүүс исгэрэх, худал инээх, хоолойгоо ойр ойр засах, худал ханиах зэрэг үйлдэл хийдэг.

Хурдан ярих нь сэтгэл хөдөлсөн ба сэтгэл санаа зовсон, хэн нэгэн хүнийг юунд ч юм бэ итгүүлэхээр маш их хичээсэн, хувийн хүнд хэцүү байдлын талаарх яриа, харьцаагаа зогсоох гэсэн хүслийг гол төлөв илэрхийлдэг.

Үгээ сонгож чадахгүй түгдчих, ээрэх, үгийг гуйвуулах, мушгих, үгээ дутуу орхих зэрэг нь өөртөө итгэлгүй, эсвэл ямар нэгэн зүйлийг нуух гэж оролдох, үгээ тасалж, зөөж тавин ярих гэх мэт өөрчлөлт байдлаар нь илрүүлж болно⁵¹.

Дээрхи бүгдээс үзвэл: Хар тамхи мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл, бодистой холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх, талаар тодорхой ажил зохиож байгаа ч тодорхой үр дүнд хүрдэггүй, алба хаагч нар хар тамхи мансууруулах бодис сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл, бодистой холбоотой гэмт хэргийг шалгах арга тактикт эзэмшээгүй, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх талаар явуулж байгаа ажлын идэвхи сул, давтамж бага, цагдаагийн төрөл мэргэжлийн албадын болон цагдаа, тагнуул, хил, гаалийн байгууллагын хоорондын уялдаа холбоо сул, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд алба хаагчдийн мэдлэг, ур чадвар дутмаг зэрэг нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд сөрөг нөлөө үзүүлж байна гэж дүгнэж болох юм.

Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг амжилттай зохион байгуулах чиглэлээр дараах саналуудыг дэвшүүлж байна. Үүнд:

- Гэмт хэргийн тухай хуулийн төсөлд мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисын төрөл, ангилал, хэмжээг хууль зүйн хувьд тодорхой болгож, ялгамжтай зүйлчлэх боломжийг бүрдүүлэх.
- Мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисын хэмжээг өөрийн улсын нийгэм эдийн засгийн хөгжил, үндэсний болон зан заншлын онцлог, үндэсний аюулгүй байдлын талаарх төрийн бодлого, монгол хүний бие физиологийн онцлог шинжид тулгуурлан Эрүүгийн хуульд их, онц их хэмжээг шинжлэх ухааны үндэстэй тогтоох.
- Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг борлуулах зорилгогүйгээр хууль бусаар бэлтгэсэн, олж авсан, хадгалсан үйлдлийг давтан үйлдсэн этгээдийн үйлдлийг хүндрүүлэх бүрэлдэхүүнд зааж өгөх.
- Энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг Тагнуулын байгууллага, Цагдаагийн байгууллага, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, Гааль, Хил хамгаалах байгууллага, Мэргэжлийн хяналтын зэрэг байгууллагууд нь салбарынхаа чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа нь төдийлөн үр дүнд хүрэхгүй байгаа учир эдгээр байгууллагуудыг бодлогын хувьд нэгтгэн зангидах төв байгууллага, эсвэл байнгын ажиллагаатай Үндэсний хороо байгуулах.
- Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт эм бэлдмэлд донтох эмгэгийг судлах, эмчлэх талаар мэргэшсэн эмч ховор иймээс эмч нарыг мэргэшүүлэх сургалтыг дотооддоо болон гадаадад зохион байгуулах.
- Цагдаагийн байгууллага хурааж авсан мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисоор дээжийн сан бүрдүүлж, сангийн харьцуулалт хийх боломжтой болгож ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн хичээлийн сургалтанд ашиглах, сонсогчдод болон ажил үүрэгээ гүйцэтгэж байгаа алба хаагчдад энэ төрлийн бодисын талаар мэдлэг олгох.

⁵¹ Цагдаа судлал сэтгүүлийн 2012 оны №4 93 дахь тал

- Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай мэдээллийг цагдаагийн байгууллагаас шалгахад нэн шаардлагатай хэрэгсэл, төхөөрөмж, тухайлбал төрөл бүрийн бодисыг тодорхойлох тест, криминалистикийн цүнх, харьцуулах бодисыг болон дээжийг агуулах сав, үзүүлэн зэргийг жижүүрийн албанд байршуулах.
- Хэсгийн байцаагч, төлөөлөгч нар өөрийн хариуцаж буй нутаг дэвсгэр дээрээ мансууруулах бодис агуулдаг ургамлыг тарьж ургуулж буй болон ийм төрлийн бодисын хориотой наймаа байж болзошгүй газрууд, гар дээрээс худалдаа эрхлэгчид гэх мэт газруудад хяналт тавьж, энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй хүмүүсийн үйлдэл, биеэ авч яваа байдал, амьдралын хэв маягын талаар мэдээ мэдээлэл олзлох, цуглуулах, хүлээн авах ажлыг шинэ шатанд гаргаж, тэдгээрийн талаар субъ ектын судалгаа явуулах зэрэг болно.

ХАР ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИСТОЙ ХОЛБООТОЙ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗАРИМ АСУУДАЛ



Ш.Чулуун

ХСИС-ийн ЦС-ийн ЦЭЗТ-ийн ахлах
багш, докторант, цагдаагийн хошууч

Мансууруулах төрлийн бодис гэдэг нь байгальд зэрлэг байдлаар ургадаг олсны ургамал, намуу цэцэг, Мексикийн мөөг, кокийн бут зэргийг хамруулан ойлгох бөгөөд эдгээр мансууруулах үйлчилгээтэй түүхий эдийг химийн урвалд оруулах, нийлэгжүүлэх буюу синтетик хэлбэрт оруулснаар цэвэр кокайн, герион буюу дэлхий нийтээр хэлж хэвшсэн “Хар тамхи”-ыг гарган авдаг байна. Бусад хар тамхи, мансууруулах бодисын бүх төрлүүдийг дээрх кокайн, героиноос гарган авдаг ба түүнээс гаргаж авсан бусад бодисоор анагаах ухаанд олон төрлийн тайвшруулах, өвчин намдаах зэрэг эм, тариа үйлдвэрлэхэд ашиглаж байна.

Сая сая хүнийг хар дарсан зүүд шиг харанхуйн дунд уусгагч хар тамхины бараан мөр дэлхий даяар аалзны тор шиг хүрээгээ тэлсээр байна. Тамхи таван нас хорооно гэдэг байхад тунг нь хэтрүүлбэл үхлийн аюултай гэгддэг хар тамхи тав бус тавин насыг тань аваад зогсохгүй там шиг амьдралд таныг унагаж байна.

Хар тамхи нь хүний бие эрхтэнд архи, тамхинаас 60 дахин илүү шарталт өгдөг хортой бодис юм. Энэ нь хүний сэтгэцэд нөлөөлж улмаар сэтгэцийн хамааралтай болгодог. Хүнийг сэргээгээд, тайвшруулаад, солиоруулдаг. Дараа нь холимог болж эргээд гутранги үзэлтэй болгодог байна.

Хар тамхи нь төв мэдрэлийн системийг өдөөгч үйлчилгээтэй бөгөөд хэрэглэсэн хүн сэтгэцийн өвөрмөц үйлчлэлд нь татагдан, маш хурдан хугацаанд түүний хамааралд орж, дахин хэрэглэсээр дон тусдаг.

Удаан хугацааны хэрэглээний дүнд турж эцэж, арьс шаргалтаж, идээт бижрүүнүүд гарч, судасны хана хатуурч, цусны бөөмөнд бижрүү үүсч, нойргүйтэж, ядаргаа, стресст орж, бэлгийн сулралд ордог. Мөн сэтгэхүйн чадвар нь эрүүл хүнийхээс доогуур түвшинд хүрч, эцсийн дүн шууд үхэлд хүргэдэг.

Дэлхийн улс орнуудын хэмжээнд **15-64** насны **230 сая** хүн хар тамхи, мансууруулах бодис хэрэглэж байгаагаас 27 сая орчим нь тогтмол хэрэглэдэг. Үүнээс

200 орчим сая хүн каннабис, **15 орчим сая** хүн амфетамин, **15,9 сая** хүн опиум /героин/, **13,7 сая** хүн кокаин хэрэглэдэг гэсэн судалгаа гарсан байна.⁵²

Монгол улс нь газар зүйн байршлын хувьд мансууруулах бодис буюу хар тамхины хэрэглээгээр эхний байруудыг эзэлдэг хоёр том улсын хооронд оршдог. Анх 1990-ээд оноос хар тамхины хэрэг манай улсад гарч эхэлсэн бөгөөд 11 гэмт хэрэг бүртгэгдэж байжээ.

Тэгвэл манай улсын хэмжээнд хар тамхи байнга хэрэглэдэг хүний тоо **1999** онд 45, **2000** онд 50, **2002** онд 170, **2006** онд 410, **2013** онд 561 хүн хар тамхи, мансууруулах бодис хэрэглэдэг гэж бүртгэгдсэн байна. Энэ бол зөвхөн судалгаагаар илэрсэн хэрэглэгчдийн тоон үзүүлэлт юм. Нэг хүний цаана 4 хэрэглэгч байдаг гэсэн эрдэмтдийн тооцоо байдаг. Тэгэхээр үүний цаана 2000 гаруй хэрэглэгч байна гэж тооцож болохоор байна.

Хар тамхи, мансууруулах бодисыг хэрэглэх хүүхэд залуусын тоо өдөр бүр нэмэгдэж байна. Энэ талаар үндэсний хэмжээнд хийгдсэн тодорхой судалгаа одоогоор гараагүй байдаг бөгөөд харин “Хар тамхи, мансууруулах бодисоос иргэдийг хамгаалах нийгэмлэг”-ээс улсын хэмжээнд мансууруулах бодис хэрэглэгчдийн тоо болон голчлон ямар бодис хэрэглэж байгаа талаар судлагааг 2013 онд явуулж байжээ.

Энэхүү судалгаа нь эрүүл мэндийн сангийн санхүүжилтээр хийгдсэн бөгөөд холбогдох төрийн байгууллага хамтраад 100 хэрэглэгчдийн дунд судалгаа хийхэд 49 хувь нь олсны ургамал буюу канабисийг татаж хэрэглэдэг. Бусад нь LCD, экстац, мөс гээд олон төрлийн хар тамхи хэрэглэдэг болохыг тогтоосон байна.

Өмнөх судалгаагаар өвсний болон олсны ургамлыг татаж хэрэглэдэг байсан. Канабисээс гадна хамгийн аюултай нь LCD юм. Энэ нь солиоролд хүргэдэг. Дээрх 100 хүний 28 хувь нь энэ мансууруулагчийг хэрэглэсэн байна. Мөн нэг хүн дунджаар 2-8 төрлийн мансууруулах бодис хэрэглэж үзсэн тоо баримт гарчээ. Энэхүү нөхцөл байдлыг тодруулж асуухад судалгаанд оролцогчид олдцоор нь хэрэглэдэг гэж хариулсан байна.

Манай Улсын иргэд сүүлийн жилүүдэд дэлхийн олон оронд янз бүрийн шугамаар зорчих нь ихэссэн. Энэ нь манай иргэдийн соёл, ахуй амьдралд эергээр нөлөөлж байгаа сайн талтай боловч нөгөө талаас үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн хууль бус үйл ажиллагаа болох хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлтэнд санаатай болон санамсаргүй байдлаар оролцож, гэмт хэргийн золиос болох нөхцлийг бүрдүүлэх гол шалтгаан нь болдог байна.

Дэлхий дээр хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлтийн сүлжээ үүсгэн идэвхтэй ажиллаж байгаа **Алтан гурвалжин /Тайланд, Лаос, Мьянмарын хилийн бүс/, Алтан хавирган сар /Афганистан, Пакистан, Ираны хилийн бүс/, Мөнгөн гурвалжин /Колумб, Болив, Перу, Мексикийн хилийн бүс нутаг/, Хар гурвалжин /Нигер, Гана, Кени, Судан, Өмнөд африк/** гэгдэх Африкийн орнуудын гэмт бүлэглэлүүд Төв болон Зүүн өмнөд Азийн орнуудын иргэдийг хар тамхины хууль бус наймаанд элсүүлэх, татан оролцуулах, тээвэрлүүлэх явдал газар авч байна.⁵³

Энэ төрлийн гэмт хэрэгт гол төлөв Зүүн өмнөд Азийн орнуудад сурч буй манай оюутан залуус, биеэ үнэлэгчид, хулгай хийх зорилгоор маршрутаар зорчигч иргэд тээвэрлэгчийн үүргийг гүйцэтгэж байна.

⁵²НҮБ-ын мансууруулах бодистой тэмцэх албанаас гаргасан 2012 оны тайлан мэдээ

⁵³www.gia.gov.mn/тагнуулын_ерөнхий_газар/

Хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэгт манай иргэд өртөж байгаа шалтгаан нь иргэдийн амьжиргааны түвшин доогуур, энэ талын мэдлэг, мэдээлэл дутмаг, амар хялбар аргаар мөнгө олох хүсэлтэйгээс гадна Зүүн өмнөд Азийн орнуудад визгүй зорчих давуу тал байдаг нь гол хүчин зүйл болж байна.

Манай улсын иргэд энэ төрлийн гэмт хэрэгт холбогдож байгаа шалтгаан нөхцлийг авч үзэхэд дийлэнх хувь нь БНХАУ-д үйлдэгдэж байна. Хил залгаа ӨМӨЗО-ны Эрээн хотод дээрх төрлийн мансууруулах бодисын хэрэглээ газар авсан, манай иргэд байнга зорчдог, биеэ үнэлэгч, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон иргэд энэ төрлийн гэмт хэрэгт хэрэглэгч гэсэн ангилалд байсан бол сүүлийн 2-3 жилийн хугацаанд энэ төрлийн гэмт хэргийн тээвэрлэгч гэсэн ангилалд хамаарах болоод байна.

Олон улсын жишгээр дамжин өнгөрч буй хар тамхины 20 хувь нь тухайн оронд үлддэг гэсэн судалгаа байдаг бөгөөд одоогийн байдлаар манай улсаар хэдий хэмжээний мансууруулах үйлчилгээтэй эм, бэлдмэл, бодис дамжин өнгөрч байгааг гаргасан судалгаа тоо баримт өнөөдрийг хүртэл байхгүй байна.

Эхэн үедээ зөвхөн цөөн тооны иргэд хар тамхи, мансууруулах бодисыг хэрэглээний журмаар /хагас нийлэгжүүлэх аргаар гаргаж авсан мансууруулах бодис/ бага хэмжээгээр хууль бусаар нэвтрүүлэх байдлаар үйлдэгдэж байсан бол өнөөдөр уг гэмт хэрэг үйлдэгчид нь ашиг орлогын үндсэн эх үүсвэр болгох зорилгоор тээвэрлэж, зарж борлуулах гэмт хэргийг үйлдэх болсон болсон байна.

Энэ төрлийн хууль бус үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалттай гэмт бүлэглэлүүдийн зүгээс манай иргэдийн Зүүн өмнөд Азийн орнуудад визгүй зорчих боломжтой байдал, гэнэн итгэмтгий зан, амар хялбар аргаар мөнгө олох зэрэг сул талуудыг нь ашиглан хууль бус эргэлтэнд татан оруулж байгаад цаашид хууль хяналтын байгууллага анхаарч энэ тал дээр холбогдох арга хэмжээг авч ажиллах шаардлага зүй ёсоор тулгарч байгааг харуулж байна.

Бусдын дайвар ачааг гаалиар тээвэрлэснээр санаатай болон санамсаргүй байдлаар хар тамхи, мансууруулах бодис тээвэрлэгч болж болзошгүй тул гадаад улс, ялангуяа БНХАУ, БНСУ, Сингапур, Малайз, Макао, ОХУ, АНУ, Европын холбооны улс оронд зорчихдоо бусдын дайвар ачаа тээшийг аль болох авахгүй байх шаардлагатай байна. Авсан тохиолдолд доторх зүйлсийг сайтар шалгаж үзэх, сонор сэрэмжтэй байх нь энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх чухал алхам болох юм.

2013 оны байдлаар гадаад улсад 4 /эрэгтэй-1, эмэгтэй-3/ иргэн энэ төрлийн гэмт хэрэгт холбогдсон бол дотоодод 74 холбогдогчтой 34 хэрэг бүртгэгдээд байна. 2014 он гарсаар 27 холбогдогчтой 12 хэрэг бүртгэгдсэн байна.

2014 оны эхний хагас жилийн байлаар энэ төрлийн гэмт хэргийн улмаас гадаад улсад 37 иргэн ял эдэлж байгаагаас эмэгтэй 15, эрэгтэй 21 байна. Үүнийг ял шийтгэлээр нь ангилж үзвэл хугацаагүй хорих ялаар 9, хорих ялаар 22, цаазаар авах ялаар 5 иргэн тус тус шийтгэгдсэн байна.

Дээрх тоо баримт бусад орнуудынхтай харьцуулахад харьцангуй цөөн мэт харагдаж байгаа боловч олон улсын жишгээр 1 хэргийн ард 10 тохиолдол байдаг гэж үзвэл энэ төрлийн гэмт хэргийн нөхцөл байдал хүндрэх төлөв байдал ажиглагдаж байна.

Гадаадын улс оронд хураан авсан мансууруулах бодисыг цаашид ямар нэгэн зориулалтаар ашиглахыг эрүүгийн болон холбогдох хууль тогтоомжоор хориглосон байдаг учир шатааж устгадаг аргыг хэрэглэдэг байна.

Ингэхдээ зориулалтын уурын зуух аль эсвэл өндөр температур бүхий уурын зуух, төмөр хайлуулах үйлдвэрийн галт тогоонд хийж шатааж устгах ажиллагааг гүйцэтгэдэг.

Мөн тухайн хар тамхи, мансууруулах бодисыг шатааж буй хүний эрүүл мэнд, сэтгэцэд нөлөөлж болох учир устгалын ажлыг гардан хийх хүн нь эмчийн үзлэгт хамрагдан шинжилгээ өгсөн байх мөн хорт хийн баг, түлэгдэхээс хамгаалсан тусгай зориулалтын хувцас, өмсгөлтэй байх гэх зэрэг шаардлагыг үйл ажиллагаандаа баримтлан ажилладаг байна.

Харин манай улсад эрх бүхий байгууллагын төлөөлөл оролцсон /цагдаа, прокурор, мөрдөн байцаагч, шүүхийн байгууллагын холбогдох албаны хүмүүс/ комисс гарч хураагдсан хар тамхи, мансууруулах бодисын устгалын ажлыг хийдэг байна.

Тухайлбал: 2013 онд **Баянзүрх дүүргийн шүүхээс** 2.27 кг, тэрбум гаруй төгрөгөөр үнэлэгдэх хар тамхийг устгалд оруулсан байна. Ингэхдээ тусгай зориулалтын байр, техник хэрэгсэл байхгүй тул тус комиссын бүрэлдэхүүн хүний хөл хөдөлгөөн байхгүй, эзгүй хээр газрыг сонгон авч тус арга хэмжээг зохион байгуулсан байна. Энэ нь зориулалтын тоног төхөөрөмж, байр савтай болохыг анхааруулсан бодит нөхцөл байдал явдал болсон юм.

Манай улсадсэтгэхүйн болон мансууруулах бодист донтох эмгэгтэй хүмүүсийг эмчлэх оношлогоо эмчилгээг мэргэжлийн байгууллага зохих журмын дагуу хийж байна.

Эмчилгээний гол арга нь сэтгэл засал, хордлого тайлах эмчилгээ хийдэг. Харин тухайн хүн өвчнөө хүндрүүлэх юм бол хавдраас ялгаагүй, эцсийн шатандаа орвол эмчилгээний үр дүнд сөргөөр нөлөөлдөг байна.

Хар тамхи хэрэглэснээр хүний эрүүл мэнд, бие бялдрын хувьд донтох эмгэг буюу хараат болдог. Өөрөөр хэлбэл хар тамхи хүний биед бүхэлд нь үйлчилж хордуулдаг байна.

Дэлхийн эрүүл мэндийн бусад байгууллагуудад ч эм, эмчилгээний төрөл бус донтох эмгэгийг эмчлэх нь харьцангуй бага байдаг бөгөөд тавхан хувийн үр дүнтэй байдаг гэсэн тооцоо байдаг байна.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн лабораторид хар тамхи мансууруулах бодисын 7 төрлөөр оношлогоог хийж ингэхдээтестийн аргыг үйл ажиллагаандаа ашигладаг байна.

Хар тамхи, мансууруулах бодисын хор уршиг:



Сүүлийн 14 жилийн хугацаанд 12 хүн нас барсан. Үүний 2 хүн нь морфений тунг хэтрүүлсэн болонхугацаа дууссан морфен хэрэглэснээс нас барсан байна. Ер нь хар тамхи хэрэглэсэн цагаасаа 2-12 жилийн дотор л нас барж байна⁵⁴ гэсэн тоо гарчээ.

Монгол улсын хууль, хяналтын байгууллага нь хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчил болон бусад ажиллагааг шалгаж шийдвэрлэхдээ олон улсын гэрээ конвенц болон дотоодын хууль тогтоомж, эрх зүйн бусад актыг удирдлага болгон алба, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Тухайлбал: НҮБ-аас 1961 онд баталсан Мансууруулах бодисын тухай конвенцид 1990 онд, НҮБ-аас 1971 онд баталсан сэтгэцэд нөлөөлөх бодисуудын тухай конвенцид 1999 онд, НҮБ-аас 1988 онд баталсан “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисуудын хууль бус эргэлтийн эсрэг конвенцид 2001 онд тус тус нэгдэн оржээ.

Мөн аюулын харанга дэлдэж буй хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх ажилд Монгол улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж онцгой анхаарч энэхүү ажлын хүрээнд “Үндэсний хөтөлбөр” боловсруулж түүний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Дээр дурдсан нөхцөл байдлаас улбаалж дараах саналыг дэвшүүлж байна.

- “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль”-ийг шинэчлэн найруулж өнөөгийн нийгэмд тулгарч байгаа хүндрэл бэрхшээлийг зохицуулж чадахуйц хууль эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх
- Хууль, хяналтын байгууллагын хар тамхи, мансууруулах бодисыг шалгах, илрүүлэхэд ашигладаг албаны техник хэрэгслийг шинэчлэн дэвшилтэт шинэ технологийг үйл ажиллагаанд нэвтрүүлэх
- Алба хаагч, ажилтнуудын мэдлэг боловсролыг дээшлүүлэх зорилгоор давтан болон мэргэшүүлэх сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах, ингэснээр энэ төрлийн гэмт хэргийн илрүүлэлтэнд ахиц гарах
- Хөгжингүй болон өндөр хөгжилтэй гадаад орнуудын тэргүүн туршилгыг судлах улмаар дотоодын албаны үйл ажиллагаанд нэвтрүүлэх
- Хар, тамхи мансууруулах бодистэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудад бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэх, төр хамтарч ажиллах
- Иргэн, хуулийн этгээдийг энэ төрлийн гэмт хэргийн хор уршиг, учирч болох эрсдлээс урьдчилан сэргийлэх талаар тодорхой мэдлэг, мэдээлэлтэй болгох
- Төрийн байгууллагуудын хооронд хар, тамхи мансууруулах бодистой холбоотой мэдээллийн санг ашиглах байдал хангалтгүй байна. Хууль хяналтын байгууллагуудын дүн мэдээ зөрдөг, мэдээ, тайланг харилцан солилцох тогтолцоо сайн бүрдээгүй байна. Иймд дээр дурдсан байгууллагууд ажлын уялдаа холбоогоо сайжруулан мэдээллийн сангийн электрон сүлжээг ашиглаж эхэлбэл цаашид хяналтын тогтолцоо сайжрах нөхцөл бүрдэнэ.

⁵⁴ “Хар тамхи мансууруулах бодисоос иргэдээ хамгаалах нийгэмлэг”-ийн судалгаа

КРИМИНОЛОГИЧЕСКИЕ ОСОБЕННОСТИ СЕМЕЙНО-БЫТОВЫХ
УБИЙСТВ В МОНГОЛИИ



Далхсүрэнгийн Түвшинтөр
ХСИС-ийн докторант, цагдаагийн
дэд хурандаа



Думбурайн Мягмарцэрэн
Доктор (Ph.D), дэд профессор, Эрүүгийн
тагнуулын тэнхимийн эрхлэгч
цагдаагийн хурандаа.

TUVSHINTUR Dalhsuren
Adjunct Leu Enforcement University
of Mongolia. Police assistant colonel

MYAGMARTSREN Dumburai
Doktor (Ph.D) professor, head of department
police intelligence, Colonel Police

Аннотация: статья посвящена на наиболее часто совершаемым
убийствам в Монголии

Ключевые слова: бытовое убийство, нетрадиционное убийство

Abstract: the article focuses in the most frequently committed murders in
Mongolia

Keywords: domestic murder, unconventional murder

В настоящее время распространение преступности в Монголии стало одной из острейших проблем. Увеличивается количество преступлений, поднимается уровень насилия, его проявления становятся все более жестокими и профессиональными. В последние годы все большее внимание и беспокойство общественности и правоохранительных органов вызывает насилие в семье, ставшее наиболее распространенной формой агрессии в современной Монголии.

Бытовое преступление — это предусмотренные уголовным законом умышленные или неосторожные действия, посягающие на жизнь⁵⁵, здоровье, честь, достоинство и свободу личности, совершаемые в результате конфликтов между лицами, состоящими в брачно-семейных, родственных, дружеских, интимных или соседских отношениях, по личным неприязненным мотивам в сфере семейного или общественного быта⁵⁶. Семейно-бытовые конфликты относятся к числу сложных социальных проблем, так как у органов внутренних дел отсутствуют действенные меры для их профилактики⁵⁷. Большая часть насильственных преступлений в семье рассматривается окружающими как сугубо личное дело, поэтому многие факты

⁵⁵ Уголовный кодекс Монголии www.legalinfo.mn

⁵⁶ Коментарий Уголовного кодекса. Часть особенная. УБ.1979

⁵⁷ Ж.Авхиа “Методика раскрытия и расследования убийств” УБ.1987

просто не предаются огласке, хотя не проходит и дня, чтобы на территории какого либо населенного пункта, не совершалось тяжких бытовых преступлений.

В последние годы отмечается удельный рост уровня семейно-бытовых преступлений. Так, например, по данным ГИЦ ГУП Монголии по префектуре Ховд, Завхан, Булган в 2014 г. количество убийств на почве семейно-бытовых конфликтов возросло более чем в 2 раза. Убийства на бытовой почве – один из наиболее распространенных видов преступлений. В каждой 2-ой семье в наше время совершаются какие-либо незначительные правонарушения, а порой – совершаются убийства. Убийства на бытовой почве напрямую зависят от тех правонарушений, которые совершаются на почве семейно-бытовых отношений. И зачастую, если лицо вовремя не обращается о совершенном против него преступлении в сфере семейно-бытовых отношений в органы милиции, то данное преступление, порой даже незначительное, может перерасти в убийство на бытовой почве. Так например в районе Баянзурх города Улан-Батора гражданка Б была убита у подъезда своего дома своим мужем, который ранее несколько раз привлекался за административное нарушение в связи с избиением жены⁵⁸.

В соответствии со статистическими данными процент убийств на бытовой почве, совершаемых мужчинами, составляет примерно 75 – 80%, и минее 11.2% убийств совершаются женщинами, 5.6% составляют несовершеннолетние. Убийства на бытовой почве не зависят от месяца, но замечено, что большее количество преступлений совершается в зимнее время, в середине недели и в ночное время с 22-06 часов, то есть примерно в 65% случаях.

Данное преступления – неорганизованное, оно скорее всего носит спонтанный характер. В 80% случаев убийства совершаются на почве пьянства, в 10% — на почве ссор и 10% случаев – по иным причинам, которые не сильно распространены среди убийств на бытовой почве. Возраст "семейных" преступников характеризуется следующим: удельный вес возрастной группы 14-17 лет составил — 10,4%; 18-24 лет — 55,3%; свыше 30 лет — 34,3%. Что касается всех умышленных убийств и покушений на убийства, то усредненный удельный вес аналогичных возрастных групп распределился следующим образом: 14-17 лет — 11,5%, 18-24 лет — 54,5%; свыше 30 лет — 44%⁵⁹. Таким образом, среди несовершеннолетних "семейных" убийц примерно столько же, что и среди всех убийц.

Рассматривая социальный портрет личности “семейных” убийц, следует остановиться на их отношениях с потерпевшим. На момент совершения преступления проживали совместно от 1 до 3 лет — 18,5%; убийца знал свою жертву от 3 до 10 лет — в 50,5% случаев, а от 10 и более лет — в остальных случаях. Это указывает на довольно длительное общение друг с другом убийцы и будущей жертвы. Подавляющее большинство изученных уголовных дел показало возникновение и формирование в течение продолжительного времени неприязненных, перерастающих с течением времени в открыто враждебные, отношений, как правило, связанных с острыми конфликтами, взаимопричинением психотравм, усугубляемых употреблением спиртных напитков, нередко совместным. Так, в 66-82,4% случаев убийца находился в состоянии алкогольного опьянения, потерпевший — в 61,5% по статистическим данным столицы⁶⁰.

Поводом к совершению преступления нередко является противоправное, аморальное поведение потерпевшего. Так, большинство (56,2%) преступников

⁵⁸ Уголовное дело №20135634

⁵⁹ Данные ГИЦ ГУП Монголии 2014 год

⁶⁰ Данные ГИЦ ГУП Монголии 2014 год

указало, что потерпевший перед совершением преступления вел себя агрессивно, грубо. При этом 26% отметили, что потерпевший оскорблял, унижал их или других членов семьи; 11% — угрожал убийством, причинением телесных повреждений; 9,6% — наносил легкие удары (пощечины и т.п.), причинял физическую боль (щипал, выкручивал руки, сдавливал различные части тела и т.п.); 5,5% — запрещал, ограничивал пользование имуществом, жилым помещением и т.п.; 4,1% — ограничивал свободу⁶¹.

Криминологическое изучение насилия в семье должно учитывать то, что семья как важнейшее звено общества не может не испытывать на себе все его тяготы и проблемы, все его материальные и духовные трудности, не преломлять в себе нынешние процессы экономической неустроенности и тревожных ожиданий. Значительная часть проявлений насилия связана с нерешенностью материального обеспечения семьи, в первую очередь инвалидов и престарелых, с жилищными проблемами, неустроенностью мигрантов из регионов. Но есть очень важный аспект социально-психологического характера, определяемый теми отношениями, которые складываются между членами семьи. Если насилие имеет место между супругами (сожителями), то оно обычно стимулируется ревностью и мстостью за действительные или мнимые обиды⁶², а также переживаниями, связанными с сексуальной неудовлетворенностью, прежде всего по вине мужчины.

Насилие между ними может порождаться соперничеством за верховенство в семье; в иных случаях жена (сожительница), прочно держащая рычаги управления в своих руках, постоянно руководит мужем, чему он в трезвом состоянии не противится, но в состоянии алкогольного опьянения силой пытается утвердить главенство в семье и одновременно отомстить за все обиды.

Насилие против родителей (как правило, со стороны сыновей) обычно представляет собой “возвращение ударов”, т.е. когда, став взрослым, человек мстит за незаживающие обиды, которые причинили ему отец или мать в его детские и юношеские годы, но в этом плане в связи традицией, в Монголии очень редки, но последнее время участились за счёт американизации. В других случаях агрессия может быть связана с материальными претензиями к родителям. Но и в случае корыстной агрессии ей, как правило, тоже предшествуют конфликты и неприязнь⁶³.

Еще одна категорию семейных убийств — убийства из любви. Убийствами из любви, несмотря на некоторую внешнюю парадоксальность, можно назвать такую категорию “родственных” убийств, когда убивают тех своих родственников или мужа, чаще жену, о которых тем самым хотят проявить заботу, защитить их, т.е. действуют из любви к ним.

Иными словами, убивая, преступник спасает их от чего-то, что представляется ему страшным, хотя при этом и не принимается во внимание, что нет ничего страшнее смерти близкого и из ситуаций, субъективно воспринимаемых как весьма опасные, могут быть и другие выходы⁶⁴. Виновные обычно страдают различными расстройствами психической деятельности, иногда их даже признают невменяемыми.

Однако наличие указанного расстройства само по себе не объясняет, почему человек совершил столь чудовищный поступок: большинство психически больных и тем более психически аномальных подобных действий не совершает. Психическая

⁶¹ Данные опроса, проведенного негосударственным органом “Содружество отцов” УБ.2012.стр.45

⁶² Учебник Уголовного права, часть особенная.УБ.1979., авторский коллектив под руководством Ж.Авхиа

⁶³ Г.Совд “Курс Уголовного права Монголии, часть особенная”УБ.1965.

⁶⁴ С.Нарангэрэл “Уголовное право Монголии.Часть особенная”УБ.1998.

патология может способствовать совершению противоправных деяний, но никогда не является их причиной, во всяком случае единственной⁶⁵.

Следует признать, что в настоящее время уровень знаний о природе семейного насилия недостаточен в Монголии, что обуславливает необходимость проведения развернутых комплексных (с применением системного подхода) социально-психологических, криминологических и медико-психиатрических исследований семейной сферы, посвященных как практическим, так и теоретическим вопросам. Теоретические изыскания должны быть направлены на системное изучение факторов, порождающих семейные конфликты и обуславливающих их перерастание в различные варианты преступного поведения. Прикладная сторона должна соответствовать разработке системы превентивных мер, призванных ликвидировать либо нейтрализовать действие криминогенных факторов, порождающих насилие в семье.

Нынешняя криминогенная ситуация в Монголии — качественно новый феномен, как по масштабам преступных проявлений, так и по степени разрушительного влияния на жизнедеятельность общества, функционирование и безопасность государства, права и свободы его граждан. Дела об убийствах вызывают, как правило, наибольший общественный резонанс, и по результатам их расследования граждане в значительной мере судят об эффективности работы правоохранительных органов⁶⁶.

С криминологической точки зрения важно различать во всем массиве изучаемых убийств две группы, условно обозначаемые как «традиционные» и «нетрадиционные»⁶⁷. «Традиционные» — это совершаемые в основном в сфере быта и досуга. Вторая группа — «нетрадиционные» убийства, относящиеся к сфере организованной, профессиональной преступности, ранее не имевшие столь широкого распространения (убийства по заказу, различного рода преступные разборки в сфере бизнеса, устранения конкурентов и т.п.), расследование которых представляет наибольшую сложность, это является одной из причин их низкой раскрываемости.

Сложившаяся в настоящее время ситуация позволяет прогнозировать, что дальнейшем этот вид убийства вполне совершится в Монголии. Организованная преступности расширится на территории Монголии, так как продолжается передел сфер влияния в экономике, с чем обычно связаны убийства богатых, руководителей предприятий, региональных чиновников и т.д. На совершение заказных убийств влияет криминализация общества, особенно молодежи⁶⁸. Снижение данного вида преступлений можно ожидать лишь с наступлением социально-экономической стабилизации в стране.

Библиографический список:

Конституция Монголии.

1. Уголовный кодекс Монголии.
2. Состояние преступности в Монголии за 2005 по 2014 год /УБ.: ГИЦ ГУП Монголии.
3. Комментарий Уголовного кодекса. Часть особенная. УБ.1979.ст.16
4. Антонов В.Н. XXI Век юридической науки и практики// Владивосток .1999 .С.318.
5. Ж.Авхиа “Преступления против личности борьба с ними ” УБ.1982.,

⁶⁵ С.Жанцан “Уголовное право Монголии.Часть особенная, в схемах. Вопросы квалификации”УБ.2002


⁶⁶ Антонов В.Н. XXI Век юридической науки и практики// Владивосток .1999 .С.318.

⁶⁷ Ю.Н.Кручин “Монгольско русский словарь”М.УБ.2004

⁶⁸ Ж.Болдбаатар “Уголовное право Монголии”УБ.2011

6. Ж.Авхиа “Методика раскрытия и расследования убийств”УБ.1987.,
7. Учебник Уголовного права, часть особенная.УБ.1979., авторский коллектив под руководством Ж.Авхиа
8. Г.Совд “Курс Уголовного права Монголии, часть особенная”УБ.1965.
9. С.Жанцан “Уголовное право Монголии.Часть особенная, в схемах. Вопросы квалификации”УБ.2002.
10. С.Нарангэрэл “Уголовное право Монголии.Часть особенная”УБ.1998.
11. Ж.Болдбаатар “Уголовное право Монголии”УБ.2011.
12. Архив суда префектуры Дархан-Уул, уголовное дело № 20131245
13. Ю.Н.Кручкин “Монгольско русский словарь”М.УБ.2004.
14. www.legalinfo.mn

Приложения



	Нетрезвом виде	С применени ем оружия	Участие несовешен нолетних	Участие лиц женского пола	Совершенн ые ностранны ми гражданам и	Из-за насилия в семье
■ 2010 он	82	0	1	6	0	3
■ 2011 он	84	0	2	6	1	7
■ 2012 он	83	1	9	16	0	1
■ 2013 он	75	1	4	17	0	2
■ 2014 он	66	0	1	17	0	5

НОТОЛГОО ГЭЖ ЮУ ВЭ?

\Канад улсын эрх зүйн зохицуулалт\



Я.Цэлмэн

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн,
мөрдөх ажиллагааны онол тактикийн
тэнхимийн ахлах багш, докторант,
цагдаагийн ахмад

Түрүүч нь өмнөх дугаарт хэвлэгдсэн.

**Бусад орчин үеийн бодлого болон үндсэн зарчмуудад нөлөө үзүүлсэн
нийгмийн ашиг сонирхлууд**

А. Хуулийн дагуу бус зөвтгөгдөн цагаагдсан талаарх хэрэг

1.63.Бэлгийн хүчирхийлэл мөлжлөгийн хохирогчид ихэнхдээ хүүхдүүд байх нь нотолгооны талаас баримтжуулахад төвөгтэй байдлыг бий болгодог. Хуучин баримтжуулах шаардлагууд болон стереотип дээр суурилсан байдал нь хохирогчийн мэдүүлэг болон ял шийтгэлээс зугтаахтай нягт холбоотой байдаг. Түүнчлэн, цуу үгэнд үндэслэсэн байдал болон хүүхдүүдийн өрсөлдөх чадварыг бий болгох дүрмүүд нь бодит нотолгоон дээр дүгнэгдэн гарсан байдаг.

1.64.Сүүлийн үед гарсан дүрэм болон нотлон баримтжуулах шаардлагууд нь одоогоор гаргагдсан байна. 2006 онд, парламент нь 14 наснаас дооших хүүхдүүдийн гэрчийн мэдүүлгийг хүлээн авахтай холбоотойгоор арга замыг хуульчилсан байна. Канадын Нотолгооны Хуулийн 16.1-н дагуу, 14 наснаас дооших хүн бол одоогоор гэрчлэн нотлох чадвар болон бий болсон аливаа нөхцөл байдлыг илэрхийлж чадах тал дээр тийм ч гаргууд байдаггүй. Тийм болохоор цуу үг дам яриаг хэрэглэх ба хуулийн хүрээнд 18-с дооших насны гэрчлэгчийн хувьд асуултанд хариулах боломжгүй байх ба шалтгаантай гэж үзвэл илүү баримт нотолгоо шаардах крауны хувьд хүүхдүүдийн нотолгоог дэмжих үүднээс холбогдох батлагдсан заалтын дагуу /гэмт хэргийн кодын⁶⁹ 715,1 ба 715,2 заалт/ болон хүнийг /гэмт хэргийн кодын 486,1 ба 486,2-заалт/ хамгаалахтай холбоотойгоор хийгдсэн байна.

В. Гэмт хэргийн хохирогч шүүх үйл явцаар хохироогүй хэмээн тогтоогдсон хэргүүд

1.65.Баримт нотолгоо бага байдаг, бэлгийн мөлжлөгийн тохиолдолд, хамгаалах зөвлөл нь гомдол гаргагчийн өмнө нь бэлгийн хүчирхийлэлд орж байсан түүхийг нь судлах болдог. Хязгаарын хувьд одоогоор гомдол гаргагчийн бэлгийн үйл ажиллагаатай холбоотой нотолгоотой танилцах, хөндлөнгийн хяналт шалгалтан дахь хамгаалах зөвлөлийн ур чадвар байдаг. /Гэмт хэргийн кодын 276⁷⁰ / гомдол гаргагчийн хувийн эмнэлгийн, сэтгэл санааны, эмчилгээний, бусад талын мэдээллийг /гэмт хэргийн кодын 278,2/ хүлээн авах хамгаалах зөвлөлийн хянадаг.

Эдгээр заалтууд нь стереотипийн шалтгаан болон зан араншингийн өөрчлөлт, түүнчлэн гомдол гаргагчийн эмчилгээний байдалд санаа тавих, хувийн

⁶⁹ R.S.C. 1985, с. C-46

⁷⁰ R. v. Darrach, [2000] 2 S.C.R. 443, [2000] S.C.J. No. 46 (S.C.C.).

нууцыг сахин мөрдөх үүднээс шүүхэд зарим талаар гомдол гаргагчийг хамгаалсан байр сууринаас хандахыг заажээ.

1.66.Дүрмийн 7-н дагуу байх эрхийг ойлгохын тулд дээр тусгагдсан гомдол гаргагчийг хамгаалах байдал нь гэмтэн буруутан гомдол гаргагчийн хувийн нууцтай холбоотойгоор буруутгалыг гаргаж ирэх үед шүүх ажиллагаанд төдийлөн тус болдоггүй ба ач холбогдолтой хэм хэмжээ нь үндсэндээ шударга⁷¹ удирдлага захиргааг нөлөөлөх эрсдэлтэй байдлаар үргэлжилдэг.

1.67.Түүнчлэн, нотолгооны дүрмүүд нь хамгаалалт ба ялалтыг хматад нь тэнцүү байдлаар хэрэглэдэг хэдий ч, шударга бус байдлаас хамгаалахад шаардлагатай гэмтэн буруутан этгээдэд амралт өгнө. Тийнхүү, үнэн бодит анализ дүн шинжилгээ нь тодорхой нөхцөл байдлуудад гэмтэн буруутан этгээд цуу үгэнд үндэслэсэн нотолгоо⁷²-д хандаж байвал хүчин төгөлдөр бус болно.

D. Хуулийн дагуух бус буруутгалуудын талаарх хэргүүд

1.68.Гэм бурууг нь яллах, эргэлзээг батлах шаардлага, бүтэн хариуцлагатай байдлаар хийх Крауны үүрэг хариуцлага, шүүхийн нэгдсэн санааны хэрэгцээ зэрэг үндсэн зарчмууд нь зөвхөн гэмт хэрэгтэнг тодорхой болгох, тогтооход тусалдаг. Гэхдээ заримдаа хуулийн дагуух бус буруутгагдсан байдлын эсрэг хангалтгүй хамгаалалт нотолгоотой байхад хэрэглэгддэг.

1.69.Нотолгооны тодорхой нэг хэлбэрүүд нь Канад улсад хуулийн дагуух бус зарим буруутгалуудын өмнө нь байсаар байдаг. Дээд шүүх “Маршал, Милгаард, Морин, Софонов, Парсонс, Трускотын шинж тэмдгийн чанартай нэрүүд болон аллагын хэрэг дэх сэрэмжлүүлэг”⁷³ –г гаргасан байна.

